



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛ



ХБНГУ-ЫН  
ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН

# ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙ: ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ

Сургалтын гарын авлага

## THEORIE UND – METHODIK ZUR AUSLEGUNG UND ANWENDUNG DER GESETZE: STRAFRECHT

Handbuch für Richter

Улаанбаатар хот  
2018 он

Шүүхийн ерөнхий  
зөвлөлийн хаяг:

Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо,  
Улаанбаатар хот,  
Монгол Улс, Зип – 15170  
Утас: 70008045  
Факс: 70007021  
Веб сайт: [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)  
И-мэйл: [contact@judcouncil.mn](mailto:contact@judcouncil.mn)

Төслийн хаяг:

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь  
төлөөлөгчийн газар,  
“Эрх зүйн боловсрол” академи  
Сүхбаатарын гудамж 11/1,  
Улаанбаатар хот  
Утас: 321294, факс: 327350  
веб сайт: <https://mongolia.hss.de/mn/>  
<https://www.facebook.com/HSFMongolia>  
И-мэйл: [hss@mongol.net](mailto:hss@mongol.net), [akad-rb@mongol.net](mailto:akad-rb@mongol.net)

Шуудангийн хаяг:

ш/х 46-835, Улаанбаатар 14201, Монгол Улс

COPYRIGHT:

Шүүхийн ерөнхий зөвлөл,



**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛ**



Энэхүү сургалтын гарын авлагыг Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу буцалтгүй тусламжийн хүрээнд хэвлэн гаргав. Гарын авлагыг зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулах, худалдан борлуулах болон бусад хэлбэрээр зохиогчийн эрхийг зөрчихгүй байхыг анхааруулж байна.

Анхны хэвлэл 600 хувь, 2018 он

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: “Адмон принт” ХХК

Цаасны хэмжээ: B5 172x245

Хэвлэлийн хуудас:

“Адмон принт” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## ӨМНӨХ ҮГ

Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны манаанд хэрэг маргааныг эцэслэн шийдэх онцгой бүрэн эрх гагцхүү шүүх эрх мэдэлд бий. Шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлсний дүнд бий болох эцсийн үр дүн нь шүүхийн шийдвэр билээ. Шүүхийн шийдвэрийг сайн, муугаар нь ангилах объектив бололцоо хязгаарлагдмал хэдий ч түүнд тавигдах шаардлага гэж бий. Үндэслэгдсэн байх, хуулийг тайлбарлан хэрэглэсэн байх зэргийг ийм шаардлага гэж үздэг хандлага хэдийнээ тогтжээ. Хуулийг батлан гаргах үндэслэгээ болсон зарчим, зорилго, үнэт зүйлсийг “тайлж” уншдаг, хэм хэмжээг хэрэглэхдээ тэр агуулгаар нь үндэслэдэг байх чадварыг шүүгчид заавал байх ёстой чадвар гэж үзэх болжээ.

Шүүгчийн хууль тайлбарлан хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх нь шүүхийн сургалтын нэг үндсэн зорилт юм. Энэ зорилтын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс МУИС-ийн Хууль зүйн сургуультай хамтран эрүү, захиргаа, иргэний эрх зүйн хууль тайлбарлах онол, арга зүй сэдэвт сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсрууллаа. Эдгээр сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах ажилд тухайн салбарын мэргэшсэн нэр хүндтэй эрдэмтэн, багш нар ажилласан юм. Энэхүү гарын авлагад эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нийтлэг зарчим, үнэт зүйлс, ололт, үр дүнг бүтээлчээр тусгаснаас гадна Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлалыг онол, арга зүйн үндэслэлтэйгээр шүүхийн практиктай нягт холбон тайлбарласнаараа шинэлэг, ач холбогдолтой болсон бөгөөд гарын авлагыг боловсруулж, мэргэн оюун ухаан, цаг хугацаагаа харамгүй зориулсан доктор, профессор Д.Баярсайханд онцгойлон талархал илэрхийлж байна.

Ийнхүү өндөр түвшинд боловсруулсан энэхүү сургалтын гарын авлагаар дамжуулан шүүгчдийн хүртээл болгох бидний санаачилгыг сайшаан хүлээн авч, тал бүрээр тусалсан ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, түүний “Эрх зүйн боловсрол” академийн хамт олонд гүн талархал илэрхийлье. Энэ бүтээл шүүгч Таны шийдвэр бичих нөр их ажилд дэмжлэг болно гэж найдаж байна.

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**ГАРЫН АВЛАГЫГ БОЛОВСРУУЛСАН:**

Д.Баярсайхан МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн  
тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

**ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

**ЭМХЭТГЭСЭН:**

С.Алунгоо Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн  
Шүүхийн сургалт хариуцсан референт

## АГУУЛГА

<b>БҮЛЭГ 1. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОНОЛЫН СУУРЬ АСУУДЛУУД.....</b>	<b>7</b>
1.1.Хуулийг тайлбарлах ба хэрэглэх ойлголтын агуулга.....	8
1.2.Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлага.....	11
1.3.Хууль тогтоогчийн хүсэл зориг ба хуулийг тайлбарлан хэрэглэх.....	13
1.4.Тайлбарын объект ба түүний тайлбарлал.....	15
1.5.Хууль зүйн техник, нэр томьёо.....	20
<b>БҮЛЭГ 2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ТАЙЛБАРЛАХ ТОДОРХОЙ АРГУУД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭ .....</b>	<b>27</b>
2.1.Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онолын урсгал, чиг хандлагууд.....	28
2.2.Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргууд, давуу болон сул тал.....	32
2.3.Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний тайлбарлах аргуудыг хэрэглэхэд анхаарах асуудал.....	43
2.4.Эрүүгийн хууль тайлбарлан хэрэглэх онол, зарчмыг шүүхийн шийдвэр бичихэд хэрэглэх арга зүй.....	50
<b>БҮЛЭГ 3. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ ОНЦЛОГ.....</b>	<b>57</b>
3.1.Эрүүгийн эрх зүйн онцлог шинж, зорилго.....	58
3.2.Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал.....	60
3.3.Гэмт хэрэг ба ялын онол, орчин үеийн чиг хандлагууд.....	65
3.4.Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх онцлог.....	73
3.5.Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг харгалзан үзэхийн ач холбогдол.....	76
<b>БҮЛЭГ 4. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУД ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА, ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХДЭЭ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ.....</b>	<b>79</b>
4.1.Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмууд, тэдгээрийг тодорхойлох шалгуур.....	80
4.2.Эрүүгийн эрх зүйн зарчмын хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол.....	82
4.3.Хууль ёсны зарчим.....	84
4.4.Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим.....	87
4.5. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим.....	89
4.6.Шударга ёсны зарчим.....	92
4.7.Энэрэнгүй ёсны зарчим.....	95

4.8.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим.....	97
4.9.Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим .....	99
4.10.Эрүүгийн эрх зүйн зарчмыг хууль тайлбарлан хэрэглэхэд анхаарах зарим зүйлс ба товч дүгнэлт .....	101
<b>ТЭМДЭГЛЭЛ .....</b>	<b>104</b>

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН**  
**ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОНОЛЫН**  
**СУУРЬ АСУУДЛУУД**

## БҮЛЭГ 1. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОНОЛЫН СУУРЬ АСУУДЛУУД

### 1.1. Хуулийг тайлбарлах ба хэрэглэх ойлголтын агуулга

Орчин үед ямар ч хууль өөрөө маш тодорхой, ойлгомжтой гарах ёстой бөгөөд хэрэглээний зориулалт, агуулгыг бүрэн хангасан байх шаардлагыг зайлшгүй тусган илэрхийлэх болжээ. Энэ нь ялангуяа хөгжингүй болон өндөр хөгжилтэй орнуудад эрх зүйн орчин тогтвортой, хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх соёл, хандлага төлөвшсөн байдагтай холбоотой. Пост-социалист орнууд болон шилжилтийн үеийг туулж буй орнуудад эрх зүйн орчин тогтворгүй, хуулийн хэм хэмжээнүүд тодорхой бус, хоёрдмол утгатай буюу хэт ерөнхий, зарим тохиолдолд тэдгээрийг шууд хэрэглэхэд хүндрэлтэй зэрэг асуудал нэлээд түгээмэл илэрдэг нь сүүлийн үеийн харьцуулсан эрх зүйн судалгаанаас харагддаг. Хуулийг тайлбарлах асуудал нь ихэнхдээ эх газрын эрх зүйн тогтолцоотой орнууд, тэр тусмаа пост-социалист улс орнуудад илүү хамааралтай ойлголт юм. Өөрөөр хэлбэл нийгмийн амьдрал, харилцааг тухайн цаг үеийн шаардлагад нийцүүлж, **code, codex** буюу төрөлжсөн хуулиар зохицуулж, хуульчлан чиглүүлэх, хуулиар журамлах явдлыг эрх зүйн зарчим, бодлого болгон хэрэгжүүлж ирсэн тогтолцооны онцлогтой холбоотой. Энэ нь нийгмийн амьдрал одоо болон ирээдүйд ямар байх ёстойг абстракт байдлаар хийсвэрлэн томъёолж, нийгмийн харилцааны журамлах ёстой нийтлэг тулгамдсан асуудлыг хуульчлан зохицуулна гэсэн үг билээ. Ийм учраас зарим үед тийнхүү хуульчлах үедээ оновчтой бус томъёолох, тухайн заалт нь бодит амьдралтай зөрчилдөх, хуулийн заалт, агуулга нь хоёрдмол утгатай, хэрэглээний шаардлага хангахгүйд хүрэх нь бий.

**Хуулийг тайлбарлах<sup>1</sup> гэж юу вэ?** Хамгийн энгийнээр илэрхийлбэл хуулийн тодорхой бус заалт, агуулгыг тодорхой, ойлгомжтой болгон тодруулж, тодотгон илэрхийлэх үйл явц юм. Хуулийг тайлбарлах ажиллагаа бол нэг талаас албан ёсны (*Парламентын ба Улсын Дээд Шүүхийн буюу Үндсэн хуулиар эрх олгогдсон*) төрийн эрх бүхий субъектээс хэрэгжүүлэх хуулийн хэрэгжилтийг нэг мөр, яв цав хангахад чиглэгдсэн эрх зүйн дагуух зүй ёсны

<sup>1</sup> **Тайлбар, тайлбарлах** – “*Үгийн утгыг тайлж, дэлгэрүүлэх, нэмэн таниулах*”. Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь, УБ., 1966, 515-р тал. Хууль зүйн утга нь **Interpretation of law**-хууль, гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийн бичвэр, хэм хэмжээнүүдийн агуулга, утга, зориулалтыг тодотгон таниулж, лавлан нээн илрүүлэх (Black’s law dictionary /fifth edition/, see p. 733-734). Харин эрх зүйн онолын бүтээлүүдэд хэрхэн тодорхойлсныг үзвэл: **С.Нарангэрэл** “Эрх зүйн эх толь бичиг” УБ., 2011 (666-р тал) бүтээлдээ “Эрх зүйн хэм хэмжээнд илэрхийлэгдсэн хууль тогтоогчийн хуульчилсан, заавал биелүүлэх ёстой хүсэл зоригийн утга санаа, агуулгыг тодорхой болгоход чиглэгдсэн төрийн байгууллага, янз бүрийн байгууллага, иргэний үйл ажиллагаа”, **Ч.Нямсүрэн** “Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал” УБ., 2010 (338-р тал) бүтээлдээ “Эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг тодруулах, нээн харуулах, ойлгох, таниулах үйл ажиллагаа”, **Д.Баярсайхан** “Эрх зүйн онол” УБ., 2010 (201-р тал) бүтээлдээ “Эрх зүйг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний утга, агуулга, хэллэг, нэр томъёо, заалт, зарчмыг тодруулан тогтоох, ойлгомжтойгоор тодорхойлох, түүнийг зөв хэрэглэх явдлыг хангаж шийдвэрлэхэд чиглэгдсэн үйл явц” гэж тус тус тодорхойлжээ. Эрх зүйн онолын барууны эрдэмтдээс (*F.Savigny, K.Larenz, R.Alexi*) эрх зүйн тайлбарын агуулга нь эрх зүйн хэм хэмжээний утга, утгын харилцан холбоо, хууль тогтоогчийн хүсэл зоригийн мөн чанар, логик үндэслэл зэргийг цогц байдлаар тодорхой болгон тайлбарлах тухай номлосон байдаг (Д.Б.).



үйл явц. Нөгөө талаас албан бус буюу мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хуульчид болон зарим үед байгууллага, албан тушаалтан, иргэдийн зүгээс хуулийг өөр өөрсдийн итгэл үнэмшил, ухамсрын дагуу тайлбарлаж буй үйл явц болдгийг ч үгүйсгэх аргагүй. Хуулийг тайлбарлах нь бичмэл хуулийн уламжлалтай эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд зайлшгүй үйл явц юм. Гэхдээ тухайн орны хуулиудын бичвэрийн оновчтой байдал, хуулийн хэрэгжилтийн зохистой орчин, эрх зүйн соёл, шүүхийн практик хэрэглээний төлөвшил, тогтвортой орчин зэргээс шууд хамаарч хуулийн тайлбарлах арга, хэлбэр, техник, процедур нь өөр өөр байх ажээ. Тэгвэл хуулийг яагаад тайлбарлах шаардлагатай болдог вэ? Энд нийгмийн хөгжлийн объектив, субъектив шалтгаанаас гадна гол нь эрх зүйн үндэслэл бүхий онолын зүй тогтол, онцлогийг нь танин мэдэх нь нэн чухал юм. Эрх зүйн онолд хуульд тайлбарлах нь ямар хэрэгцээ шаардлагад үндэслэгддэгийг дараах үндэслэл, шалтгаантай холбон авч үздэг. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээнүүд анхлан бүтээгдэж гарахдаа түүний зарчим, заалтууд нь ихэнхдээ хийсвэрлэн томъёологдсон буюу ерөнхий нөхцөл, нийтлэг горимуудыг тогтоосон шинжтэйн дээр хууль зүйн тодорхой баталгаа, хэрэгжилтээр дамжиж байж бүрэн хангагдана.
2. Эрх зүйн хэм хэмжээ нь хууль зүйн техник, эрх зүйн соёл, сэтгэлгээг бүтээлчээр ашигласны үр дүнд бий болж үйлчлэх тул зарим талаар хуулийн текст, агуулгыг хувь хүн, иргэн субъект бүр бүрэн гүйцэд ухаж, нэгэн мөр төсөөлж ойлгох боломжгүй.
3. Хууль, хуульчилсан актууд болон олон улсын соёрхон баталсан гэрээ, хуулиуд хоорондоо бүрэн уялдаж авцалдахгүй байх, зөрчилдөх, улмаар эрх зүйн хийдлийн сөрөг, зохисгүй нөхцөл, орчин бий болсон үед тэдгээрийг зөвтгөх, даван туулах шаардлага аяндаа гардаг.
4. Эрх зүйн хэм хэмжээнд тодорхойлогдсон хууль зүйн нэр томъёо, ойлголт нь тодорхой бус, зарим ойлгомжгүй заалтуудыг тодруулах, оновчтой болгох зүй ёсны шаардлага тавигддаг.<sup>2</sup>
5. Хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн зөрчлийн хэрэг, тохиолдлыг хянан шийдвэрлэхэд тухайн холбогдох эрх зүйн хэм хэмжээний утга, агуулгыг тодруулах шаардлага аяндаа гардаг.<sup>3</sup>
6. Эрх зүйн хэм хэмжээ нь ерөнхий, нийтлэг, хийсвэр шинж чанарыг илэрхийлдэг боловч нийгмийн харилцааны зохицуулалтын тодорхой нөхцөл байдалд хэрэгждэг<sup>4</sup> г.м.

Ромын эрх зүйд **Contemporanea exposito est optima et fortissimo in lege** буюу *“Аливаа хуулийн тайлбар нь хуулийн заалт, агуулгатайгаа яв цав нийцэж тохирч байх аваас тэрхүү хууль нь үнэнхүү хүчтэй, нэр хүндтэй байж чадна”*<sup>5</sup> гэсэн номлол, зарчим олон жил хэрэглэгдэж үйлчилсэн байдаг.

<sup>2</sup> Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ. 2010, 200-201-р тал

<sup>3</sup> Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ. 2004. 296-р тал

<sup>4</sup> Мөн тэнд.

<sup>5</sup> Д.Баярсайхан, Ромын эрх зүй, УБ., 2000, 200-202-р тал

Ер нь хууль тайлбарлах гэдгийг эрх зүйт төрийн шаардлагад нийцүүлж “эрх зүйг тайлбарлах” гэсэн утгаар авч үзэж, хэрэглэж байх учиртай билээ. Хуулийг тайлбарлах танин мэдэхүйн уг сурвалж нь Ромын эрх зүйгээс эх үндэстэй боловч онолын үндэслэл нь позитивист болон нормативист онолын тэр тусмаа эх сурвалжийн болон чиг үүргийн онол, арга зүйтэй салшгүй холбогдож үүсэж хөгжсөн байдаг. Эхэн үедээ хуулийн ойлгомжгүй, тодорхой бус заалтыг тусад нь салган авч үзэж үгчлэн утгачилж тайлбарлах, эсхүл нэр томъёоны талаас нь дэлгэрүүлж, тодорхойлох зэргээр гол төлөв хэм хэмжээний догматик хандлагаар тайлбарлахыг оролдож байв. Харин эдүгээ кейсийн буюу казуаль талаас нь зориулалт, чиг үүргийг хангах, хэм хэмжээнүүд хоорондын хийдлийг арилгах, тэдгээрийн уялдаа, хамаарал талаас нь тодруулж, хуулийн зорилго, агуулгад нийцүүлж тайлбарлах хандлага давамгайлж байна. Ялангуяа хуулийн үг хэллэг ба утгын уялдаа холбоог хангах, хуулийн зорилгыг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэх, хууль тогтоогчийн хүсэл зориг, агуулга, үндсэн зарчмыг алдагдуулахгүй байхад их анхаарах болжээ. Эрх зүйн тайлбар нь хуулийн тайлбараас илүү аналитик түвшинд, хэрэглээний логик аргачлалаар хийгддэгээрээ ялгаатай.

### **Хуулийг хэрэглэх гэж юу вэ? Энэ нь хуулийг тайлбарлахтай яаж холбогдох вэ?**

Хуулийг хэрэглэх<sup>6</sup> гэдэг нь шууд утгаараа хууль зүйн тодорхой асуудал (хэрэг, зөрчил, тохиолдол)-ыг хуульд нийцүүлж, шийдвэрлэхэд чиглэгдсэн үйл явц юм. Хуулийг хэрэглэх нь хуулийг биелүүлэх болон хуулийг дагаж мөрдөхөөс ялгаатай ойлголт. Хуулийг биелүүлэх гэдэг нь хуулиар үүрэг болгосон хэм хэмжээг тухайн субъект хэрэгжүүлэхийг хэлдэг бол хуулийг дагаж мөрдөх гэдэг нь хуулиар хориглоогүй буюу хуулиар зөвшөөрсөн хэм хэмжээг сахин хангаж байгааг илэрхийлнэ.

Хуулийг хэрэглэх ажиллагаа бол нэг бүрчилсэн шинжтэй буюу ихэнхдээ төрийн эрх бүхий субъектээс хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрх зүйн дагуух процесс юм. Өөрөөр хэлбэл энэ нь нэг талаас эрх зүйн зөрчлийн хэрэг маргааныг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа болдог бол нөгөө талаас хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн процесс ажиллагаа байдаг. Жишээ нь: шүүгч бүрэн эрхийнхээ дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан хэлэлцээд шийдвэр гаргах, прокурор яллах дүгнэлт үйлдэж, эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх, нэг хуулийн этгээд ба иргэн, нөгөө хуулийн этгээд ба иргэнтэй гэрээ хэлцэл байгуулах; компанийн захирал тушаал гарган хүнийг ажилд авах; иргэд өөрсдийн эзэмшил, өмчлөлийн эд зүйлсээ бусдад худалдах, шилжүүлэх зэрэг нийгмийн харилцаанд байнга давтагддаг хуулийн дагуух зүй ёсны үйлдлүүд нь хуулийг хэрэглэж байгаагийн тод томруун жишээ мөн. Хуулийг хэрэглэх нь хуулиар

<sup>6</sup> Хэрэглээ, хэрэглэх - Латин, англи үгийн *actus, useim, iudicatum*: “тохируулан үйлдэх, шийдэл гаргах” зэрэг утгыг илтгэх бөгөөд “Хуулийг хэрэглэх” (применение закона), “*use of law*”-“эрх зүйн хэм хэмжээг хууль зүйн тодорхой хэрэг, тохиолдолд тохируулж, дүгнэлт, шийдэл гаргах ажиллагаа” гэсэн агуулгыг илтгэх ажээ. (Проблемы теории права и государства, М., 1999, с. 79), (Д.Б.)

олгогдсон эрх, үүрэг, хариуцлагыг тухайн субъект ухамсарласны үндсэн дээр хууль ёсны эрх, бүрэн эрхийн дагуу олгогдсон боломжийг ашиглаж, хууль тогтоомжийн хэм хэмжээ, нөхцөлүүдийг тухайн шийдэх ёстой тохиолдол, асуудалд яв цав тохируулж, хууль ёсны үйлдэл хийх ажиллагаа мөн.

Эрх зүйн онолд эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх тухай ойлголт байдаг. Энэ нь хуулийг хэрэглэхтэй адил утгатай, түүнтэй салшгүй холбоотой боловч өргөн бөгөөд академик түвшинд ойлгогдоно. “Эрх зүйн нэг бүрчилсэн актыг гаргах үндсэн дээр эрх зүйн нийтлэг хэм хэмжээг амьдралын тодорхой нөхцөлд хэрэгжүүлэхийн тулд явуулж байгаа засаглах, зохион байгуулах үйл ажиллагаа”<sup>7</sup> гэж үзэж болно. Түүнчлэн энэ нь “хуулиар эрх олгогдсон эрх бүхий субъектээс (*шүүгч, албан тушаалтан*) эрх зүйн хэм хэмжээний заалт, зарчмыг ойлгомжтойгоор тодорхойлж, тогтооход чиглэгдсэн эрх зүйн үйл явц төдийгүй эрх зүйн шийдлийг гаргахад чиглэгдсэн эрх зүйн процесс юм.”<sup>8</sup>

Хуулийг хэрэглэх нь хуулийг тайлбарлахтай салшгүй холбоотой. Сүүлийн жилүүдэд “хуулийн хэрэглээ” гэсэн ойлголт бий болж, нэлээд хэрэглэгдэх болсон билээ. Хуулийн хэрэглээ нь хуулийг хэрэглэх гэхээсээ илүү тайлбарлан хэрэглэх гэсэн утгыг илэрхийлэх болсон байна (*зарим үед хэрэглэн тайлбарлах гэсэн утгыг тусгах нь бий*). Хуулийн тайлбарын зорилго, агуулга нь хуулийг зөв хэрэглэхэд чиглэгддэг бол хуулийг хэрэглэхийн агуулга нь зөв ойлгож, тайлбарлахад оршино. Зарим судлаачид<sup>9</sup> “Эрх зүйт төрийн мөн чанараас урган гардаг эрх зүйн зарчим, хуулийн хэм хэмжээг харьцуулан тайлбарлах нь эрх зүйн хэрэглээний сонгодог арга зүйтэй илүүтэй нөхцөлдөж байна ...” гэж бичсэнийг дэмжих нь зүйтэй.

Орчин үед эрх зүйн хэрэглээний арга зүй судлалд Ф.Савигнигийн дөрвөн аргын (*үгчлэн утгачлах, түүхчлэн системчлэх, чиг үүрэгчлэх*) онолоос гадна “**Үндэслэгээний онол**” (*Ф.Пухта*), “**Цэвэр хэм хэмжээний онол**” (*Х.Кельзен*), “**Чөлөөт уян зарчмын онол**” (*Э.Фуч, Х.Кантрович*) “**Ашиг сонирхлын онол**” (*П.Хек*), “**Үнэт зүйлсийн онол**” (*П.Хек*) зэрэг олон талт аргачлал, эрх зүйн баримтлал<sup>10</sup>, чиг хандлага бий болж, шүүхийн практикт идэвхтэй хэрэглэгдсээр байна.

## 1.2. Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлага

Хуулийн тайлбар яагаад зайлшгүй болохыг эрх зүйн онолын талаас нь өмнөх хэсэгт товч өгүүлсэн билээ. Харин энэ удаад тэдгээр нийтлэг үндэслэлийг дэлгэрүүлж авч үзье.

Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлага гэдэг нь хуулийг тайлбарлан хэрэглэх шалтгаан, нөхцөл чухам яагаад бий болдгийг тодорхойлох

<sup>7</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол: үндсэн ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2010, 327 дахь тал.

<sup>8</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ., 2010, 246 дахь тал.

<sup>9</sup> Т.Саруул, Эрх зүй хэрэглэх арга зүй, УБ., 2014, 12 дахь тал.

<sup>10</sup> Т.Саруул, Эрх зүй хэрэглэх арга зүй, УБ., 2014 номноос дэлгэрүүлж үзнэ үү.

хүчин зүйлүүд юм. Хамгийн ерөнхий нөхцөлөөр авч үзвэл нэг талаас тухайн батлагдаж гарсан хуулиудыг шууд хэрэгжүүлэхэд эрх зүйн хийдэл бий болсноос хамаарч түүнийг даван туулах шаардлагаас урган гарна.<sup>11</sup> Нөгөө талаас хуулийн заалт, хэм хэмжээ нэг бүрийг нэг мөр, зөв ойлгож, хэрэглэх явдлыг хангуулах хэрэгцээ аяндаа бий болдогтой холбоотой. Хэрэв хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлагыг бодитойгоор мэдэрч, зөв үнэлэхгүйгээр тэдгээрийг үл харгалзан орхигдуулбал хууль зүйн төдийгүй нийгмийн ноцтой үр дагаварт хүргэдэг. Ялангуяа Үндсэн хуулиас эхлээд органик хуулиудад хуулийн зарим заалт, нэр томьёо нь нэн ойлгомжгүй буюу шууд хэрэглэх боломжгүй тохиолдолд тухай бүр нь оновчтой тайлбарлаж байх зайлшгүй шаардлага бий. Зарим үед Улсын Дээд Шүүхээс Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан онцгой бүрэн эрхийн дагуу Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргахдаа хууль зүйн шинжлэх ухааны үндэслэл муутай, нийтлэг жишгийн ойлголтоос ангид байдлаар, субъектив агуулга бүхий тайлбар хийвэл энэ нь “негатив тайлбар” (*negative interpretation*) болох бөгөөд хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэхэд нэлээд хүндрэлтэй байдал үүсгэх нь бий. 1996-2009 оны хооронд болсон зарим, ганц нэг жишээг энд дурдаж болно.<sup>12</sup>

Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлагыг онолын хувьд объектив ба субъектив гэсэн хоёр хүчин зүйлээр авч үзэж болно.

I. *Объектив шалтгаан, хүчин зүйл:*

- Хуулиудын тогтворгүй байдал;
- Хуулийн хэрэгжилт хангалтгүй байх;
- Нийгмийн эрх зүйн ухамсар, соёл төлөвшөөгүй;
- Эрх зүйн шинэтгэлийн талаарх төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй;
- Нийгмийн хөгжлийн түвшин дорой;
- Улс төрийн бодлогын тогтворгүй байдал г.м.

<sup>11</sup> В.Н.Хропанюк, Теория государства и права, 2-е издание, М., 2001, с. 268.

<sup>12</sup> Улсын Дээд Шүүх 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 216 дугаар тогтоолын 1-т: “Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан “Зөвшилцөх” гэдгийг ... хууль, бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн гаргаж буй шийдвэр, авах гэж буй арга хэмжээний талаар хуульд заасан байгууллага, албан тушаалтантай санал солилцохыг ойлгоно.”; 2-т: “... бичгээр санал авахыг ойлгоно” гэж тайлбарласан. Гэтэл “*consensus*”, “*консенсус*” гэдэг үг хууль зүйн шинжлэх ухаанд “*Ерөнхий нөхцөлөөр тохиролцох, хамтран ойлголцож шийдэлд хүрэх*” гэсэн утгатай болохыг (*Black's law dictionary*) нийтлэг жишгийн дагуу хүлээн зөвшөөрсөн байдаг. Академич С.Нарангэрэл 2007 онд хэвлүүлсэн Эрх зүйн эх толь бичигтээ (219-р тал) уг ойлголтын утгыг “*Санал нэгтгэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрэх*” гэж тайлбарласан нь шинжлэх ухааны үндэслэлтэй юм. “Санал солилцох” гэдэг утга нь “Зөвшилцлийн” агуулгыг илэрхийлэхгүй бөгөөд буруу тайлбар юм. Улсын Дээд Шүүх 2009 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1-д: “... Албан тушаалын байдал гэж албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх, үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөөг хэлнэ” гэж тайлбарлажээ. Энэ нь тухайн ойлголтын шууд утгыг алдагдуулж, хуулийн агуулгаас өргөжүүлж тайлбарласан гэж судлаачид үздэг. 2012 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш хуулийн заалт, утгын тайлбарыг хийхдээ нэр томьёоны буюу абстракт тайлбар гаргах явдлыг хориглосон билээ. Харин Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргана ...” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Чухамдаа 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өнөөг хүртэл УДШ-ийн хуулийн тайлбар гаргах эрх зүйн зохицуулалт тодорхой бус нөхцөл байдлын улмаас зогсонг байдалд ороод байна (Д.Б.).

II. Субъектив шалтгаан, хүчин зүйл:

- Хуулиудын заалт, агуулга, утгын тодорхой бус, ойлгомжгүй байдал;
- Эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудын бүрэн хуульчлагдаагүй;
- Хууль зүйн хэллэг, нэр томъёоны нэгэн мөр ойлголт бүрэн цэгцэрч төлөвшөөгүй;
- Анхан шатны шүүхийн шийдвэрийн оновчтой бус, тогтворгүй;
- Хууль тогтоомж дахь эрх зүйн хийдлийн нөхцөл, хүчин зүйл багасаж арилаагүй;
- Шүүхийн практикийн зохисгүй, оновчтой бус байдал;
- Хууль хэрэглэх болон хуулийг тайлбарлах ажиллагаа процессын эрх зүйн зохицуулалтгүй байх;
- Эрх зүйн хэрэглээний соёл хангалтгүй, хууль зүйн техникийн хөгжил сул г.м.

Хуулийг тайлбарлан хэрэглэх нь эрх зүйн хэрэглээний хамгийн голлох хэлбэр нь мөн тул хууль зүйн аливаа асуудлыг шийдвэрлэхэд тухайн нөхцөл байдал, орчныг сайтар судалсны үндсэн дээр тэрхүү тайлбар шаардлагатай болсон үндэслэл, шалтгааныг урьдчилж тодорхойлсон байх ёстой. Юуны өмнө хуулийг тайлбарлах нийтлэг хэрэгцээ, үндэслэлийг танин мэдэж, судалсны дараа тухайн тодорхой асуудлыг үнэлж тогтоох ёстой. Хуулийг тайлбарлан хэрэглэх тодорхой шалтгааныг тогтоохын тулд хуулиудад байгаа заалт, агуулгаас гадна хуулийн (өөрийнх нь) нэр томъёо, УДШ-ийн тайлбар, зөвлөмж зэргээс гадна Монгол Улсын олон улсын гэрээний тайлбар, хууль зүйн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичгүүдийн (англи хэл дээрх) тайлбарыг<sup>13</sup> заавал уншиж судалсан байх учиртай. Шүүхийн шийдвэрүүдийн<sup>14</sup> жишиг, практикийг судлан тогтоох нь зайлшгүй юм. Үүнээс гадна монгол хэлний үгийн болон утгын тайлбар толиудыг судалж, эзэмшсэн байх нь тухайн хэрэгцээг хангах нэг арга болно.

Дээр дурдсанаас гадна академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” (2007-2015)-ийг заавал уншиж, утгыг нь судалж эзэмшсэн байх нь чухал юм. Д.Солонго “Үндсэн хуулийн эрх зүйн тайлбар толь” УБ., 2002; Д.Ганзориг “Захиргааны эрх зүйн тайлбар толь” УБ., 2003; Б.Улаанбаатар “Иргэний эрх зүйн тайлбар толь” УБ., 2005 зэрэг эх сурвалжийг тухайн тохиолдолд анхаарч судлах нь зүйтэй юм.<sup>15</sup>

### 1.3. Хууль тогтоогчийн хүсэл зориг ба хуулийг тайлбарлан хэрэглэх

Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь чухамдаа хууль тогтоогчийн хүсэл зоригийн<sup>16</sup> тухайд хуульд хэр зэрэг ойлгомжтой тусгагдсан эсэхээс

<sup>13</sup> Black's law dictionary (eighth edition), Thomson west, 2004; CorlCreifeld/Klaus Weber, et.d. Rechtsworterbuch, Munchen, 2014; Большой юридический словарь, под ред. А.Я.Сухарева, М., 2008.

<sup>14</sup> Монгол Улсын шүүхийн сонгодог шийдвэрийн эмхэтгэл, УБ., 2015, 2016, 2017.

<sup>15</sup> Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь, УБ., 1966, С.Шагж, Монгол үгний тайлбар, УБ., 1994, ШУА, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ., 2016 гэх мэт.

<sup>16</sup> Хууль тогтоогчийн хүсэл зориг-“Воля законодателя, wills and intention of the law makers-Хууль тогтоох субъект буюу парламентын хүсэл эрмэлзэл, байр суурь, чиг баримтлалын нийлбэр цогц”. Энэ нь хуулийн үзэл баримтлал, зорилго, агуулгаар дамжин илэрнэ (Д.Б.).

ихээхэн хамаарна. Хууль тогтоогч гэдэг нь парламент тул түүний хүсэл зориг нь парламентын хүсэл зориг юм. Хууль тогтоогчийн хүсэл зориг нь тухайн хуулийн үзэл баримтлалд илүү тусгалаа олсон байхаас гадна хуулийг гаргах хэрэгцээ шаардлага, зорилгыг илүү тод илэрхийлсэн байна. Энэхүү хүсэл зориг нь үзэл баримтлал, зарчим, чиг хандлагыг тусгах бөгөөд хуулийн агуулга, нөхцөлийг тодорхойлно.<sup>17</sup> Хууль тогтоогчийн хүсэл зориг нь хууль тогтоох ажиллагааны явц, үр дүнгээр тодорхойлогдож, хуульд тусгагдаж илэрсэн байна. Хууль ёсны зарчмын нэг чухал агуулга болох хуулийг нэгэн мөр ойлгох шаардлага нь хууль тогтоох ба хууль хэрэглэх үйл явцын хоорондын уялдаа хамааралтай, нэгдмэл (“*нэг амин сүнстэй*”) байх процессын агуулгыг илэрхийлнэ.<sup>18</sup>

Тэгвэл хууль тогтоох хүсэл зоригийн агуулгад ямар шаардлага тавигддаг вэ? Үүнд:

1. Хууль тогтоогчийн хүсэл зориг нь ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн байх;
2. Олон улсын гэрээ, эрх зүйн түгээмэл хандлага, суурь зарчимтай уялдсан байх;
3. Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулга, хэм хэмжээг зөрчөөгүй байх;
4. Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгааг хангасан байх;
5. Нийгмийн амьдралын тодорхой, тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байх;
6. Хүний эрхийн зарчим, шаардлагад нийцсэн байх;
7. Хууль тогтоомжид тавигдах шаардлагыг<sup>19</sup> тусгасан байх;
8. Хууль гаргасны дараах үр дагаврыг бүрэн тооцсон буюу эрх зүйн орчныг тогтвортой байх нөхцөлийг хангах г.м.

Дээр дурдсанаас гадна хууль тогтоогчийн хүсэл зориг хуульд тусахдаа өөрийн стандарт шаардлага, нөхцөлийг хангах учиртай ажээ. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн агуулгаас үзэхэд хууль тогтоогч нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх, хуулийн төслийн хэл найруулгад тавигдах үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлж, хоёрдмол утгагүй, товч тодорхой ойлгоход хялбараар бичих, нэг нэр томъёогоор өөр өөр ойлголт илэрхийлэхгүй байх, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн үг хэллэг, нэр томъёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг шаардлагыг хуульчилсан<sup>20</sup> билээ. Хууль тогтоогчийн

<sup>17</sup> Е.В.Сырых, Критерии качества закона, М., 2000, с. 44-45.

<sup>18</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016, 120-121-р тал.

<sup>19</sup> Хууль тогтоомжид тавигдах шаардлага гэдэг нь хууль тогтоомжийн чанарын шалгуурыг хангахыг хэлнэ. Энэ нь хуулийн хэлбэр, агуулгад байдаг нийгмийн болон хууль зүйн шинж чанарын нийлбэр бөгөөд нийгмийн бодит байдал, түүний тодорхой хэрэгцээг хангах чадавхаар нөхцөлдсөн байна. (Е.В.Сырых, Критерии качества закона, М., 2000, с. 44).

<sup>20</sup> “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 44-45-р тал.

хүсэл зориг нь хуулийг хэрэглэх субъектын үйл ажиллагааны танин мэдэхүйн чухал эх сурвалж болох ёстой. Хуулийг тайлбарлан хэрэглэх үйл ажиллагаа хууль тогтоогчийн хүсэл зоригийн буюу хуулийн агуулгаар хязгаарлагдан тодорхойлогдох учиртай. Учир нь хууль нь өөрөө хэм хэмжээний утга санаа, зориулалт, чиг үүргийн нарийвчилсан нөхцөлийг хатуу сахихыг шаарддаг. Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь эрх зүйн үйлчлэлийг шууд хангах процесс учраас хууль ёсны бөгөөд бодитой байх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.<sup>21</sup> Хууль ёсны гэдэг нь угаасаа тухайн хуулийн зорилго, зарчим, хэм хэмжээг гуйвалтгүй дагаж, сахин хангах явдал юм.<sup>22</sup> Бодитой байх гэдэг нь тухайн хууль үйлчлэхдээ нийгмийн зайлшгүй хэрэгцээ, цаг үеийн шаардлагыг хангаж хэрэгжинэ гэсэн үг. Хуулийг тайлбарлах, хэрэглэх ажиллагаа нь хуулийг “амьдруулж”, хэрэгжүүлж буй утгаараа бол хуулийг бүтээх үйл явцын хүрээнд хамаарагдаж байгаа юм. Хууль бүтээх ажиллагаа нь бодлогын цогц асуудал бөгөөд хууль санаачлахаас эхлээд хууль бүрэн хэрэгжих хүртэлх бүх үе шатыг хамардаг байна.<sup>23</sup>

#### 1.4. Тайлбарын объект ба түүний тайлбарлал

Хуулийн тайлбарын тухай ойлголтыг илүү гүнзгий танин мэдэхийн тулд энэхүү тайлбарын объект болон тайлбарлалын асуудлыг авч үзэх нь зайлшгүй. Хуулийн тайлбарын объект нь өргөн утгаараа тухайн хууль бүхэлдээ юм. Гэхдээ ихэнх тохиолдолд хуулийн тодорхой заалт, нэр томъёо, хэллэг, ойлголт зэрэг нь тайлбарын объект болдог. Өөрөөр хэлбэл хуулийн хэлбэр, агуулгыг тодорхойлж бичигдсэн өгүүлэгдэхүүний өртөгдөн буй бүх зүйлс объект болно. Онолын үүднээс бол эрх зүйн хэм хэмжээний тайлбарын объект нь эрх зүйн хуульчлагдсан эх сурвалжийн бичвэрийн ойлгомжгүй, тодорхой бус хэсэг, тэдгээрийн шийдэх ёстой асуудлууд мөн. Товчоор бол тайлбарлах ёстой бичвэрийг дутуу илэрхийлэгдсэн тэрхүү өгөгдөхүүн юм.

Хуулийг тайлбарлах ажиллагаа нь логик бодомж бүхий сэтгэж танин мэдэхүйн үйл явц мөн тул энэ нь өөрийн объектой байх нь зүйн хэрэг. Тайлбарлах ажиллагаа нь танин мэдэх үйл явцын хувьд объектив байхаас гадна субъектив үйл явц болдог. Учир нь эрх зүйн хэм хэмжээг тодорхой субъект тайлбарладаг бөгөөд түүний үр дүн нь сэтгэн бодохуйн субъектив хэлбэрээр илэрнэ.<sup>24</sup> Субъект нь хэн болохоос хамаарч тайлбарын объектыг тодорхойлох өгөгдөл, нөхцөлүүд янз бүр байдаг. Хуулийн тайлбарын объектыг тодорхойлохдоо тухайн тайлбарын арга хэлбэр, төрөл, субъектын онцлог хийгээд тухайн улсад оршин буй эрх зүйн тогтолцооны хэв маяг, эрх зүйн хэрэглээний соёл зэргийг харьцуулан харгалзаж авч үздэг. “Эрх зүйн хэм хэмжээний тайлбарын объект” гэдгийг доктор Ч.Нямсүрэн “... Тодорхой тохиолдлыг зохицуулах хэм хэмжээг агуулсан эрх зүйн хэм хэмжээний актын

<sup>21</sup> В.В.Лазерев, Применение права, К. 1991, с. 41-43.

<sup>22</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ., 2010, 68-р тал.

<sup>23</sup> Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, УБ., 2016, 17-р тал.

<sup>24</sup> Ч.Нямсүрэн, дурдсан бүтээл, 340-р тал.

бичвэр, зүйл, заалт, үг, өгүүлэмж мөн”<sup>25</sup> гэж тодорхойлжээ. Ер нь тайлбар бол өөрийн гэсэн объекттой. Энэ нь тайлбарын төрөл, ангиллаас хамаарч олон талт өгөгдөхүүн болно. Нийтлэг жишгийн түгээмэл арга зүйд үндэслэн авч үзвэл тайлбарлал нь “... ямар нэг үзэгдлийн гол агуулгыг тогтоох, тодорхой бус хоёрдмол утгатай зүйлийг ойлгомжтой болгох, үйл баримт хоорондын холбоо, харилцан хамаарлыг тодорхойлоход оршино”.<sup>26</sup>

Тайлбарлал бол тайлбарлах үйл явцын тогтолцоо мөн бөгөөд эрх зүйн хэм хэмжээний “амин сүнс” буюу зорилго, агуулгыг нь бодитойгоор тогтооход мөн чанар нь оршино.<sup>27</sup> Хуулийн тайлбарын объектыг шууд утгаар нь тайлбарлах зүйл гэж ойлгож болно. Энэ нь органик түвшинд илрэхдээ тухайн бичвэрийн хэлбэрийн тусгагдсан зүйлс. Энд хуулийн бүлэг, зүйл, заалт, анги, хэсэг зэрэг тухайн хэм хэмжээний бүтцийн хэсгүүдээс гадна ойлголт, нэр томъёо зэргийг өөртөө багтаана. Өөрөөр хэлбэл эдгээр заалт, нэр томъёо нь хэл зүйд үндэслэгдсэн статик агуулга бүхий тайлбарын объект болно. Энэ нь функциональ түвшинд илрэхдээ тухайн бичвэрийн агуулгыг тусгасан зүйлс юм. Тухайлбал хуулийн зорилго, зарчим болон хуулиудын хоорондын хэм хэмжээний уялдаа зэргийг хамааруулж ойлгоно. Энэ нь дээрх тайлбарлах зүйлүүд динамик агуулга бүхий тайлбарын объект болдгийг харуулна.

Дээр дурдсан объект нь тайлбарлах зүйлийн хүрээ хязгаарыг ангилан төрөлжүүлэхэд чухал ач холбогдолтой.<sup>28</sup> Тайлбарын голлох үндсэн объектыг тайлбарлах зүйл гэсэн утгаар тус тусад нь тодруулж авч үзье. Үүнд:

- 1. Хуулийн заалт:** Энэ нь хуульчлагдсан хэм хэмжээний гипотез, диспозиц, санкцийн бүтцийг бүхэлд нь болон тодорхой хэмжээнд илэрхийлсэн үг, өгүүлэмж бүхий бичвэрийн хэсэг. Хуулийн заалт нь ихэнхдээ энгийн, энгийн нийлмэл, хавсарсан нийлбэр өгүүлэмж бүхий хэсгээс бүрдэнэ. Жишээ нь: Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд “Хүн бүр эрх зүйн этгээд мөн” гэсэн энгийн өгүүлэмж бүхий заалтыг иргэн хүн шууд уншихад утгыг нь тэр бүр ухаж ойлгохгүй боловч хүн бүхэн эрх зүйн холбогдол бүхий агуулга илэрхийлж буйг төсөөлнө. Энэ нь Иргэний хууль болон бусад хуулиар нарийвчлан тодорхойлогдох замаар тайлбарлагдана. Хуулийн заалтыг тайлбарлах нь объектыг олж тогтоох утгаараа нэг талаас тухайн заалт хэдийгээр тодорхой боловч түүнийг тодруулж, хэрэглэх нөхцөлийг нь илүү дэлгэрүүлэх замаар тайлбар хийх хандлага бий. Нөгөө талаас нь авч үзвэл хуулийн заалтын ойлгомжгүй, тодорхой бус хэсгийг тусгайлан ялгаж авч үзэх явдал нь илүү чухал хамааралтай байдаг. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “... Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр,

<sup>25</sup> Мөн тэнд.

<sup>26</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016, 325-р тал.

<sup>27</sup> Б.Спасов, Закон и его толкование, М., 2008, с. 91-94.

<sup>28</sup> А.В.Смирнов, А.Г.Манукян, Толкование норм права, М., 2008, с. 82-84.



хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь хавсарсан нийлмэл өгүүлэмж бүхий объект болно. Энэ заалтад гипотез, диспозицийн төдийгүй нөхцөл шаардсан өгүүлэмжийн хувьд үг зүйн болон чиг үүргийн тайлбар хийх шаардлага аяндаа бий болдог. Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.1 дэх хэсэгт “Хүний биед хохирол учруулахгүйгээр халдаж зодсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтад тайлбарлалын объектыг тодруулах шаардлага зүй ёсоор бий болох бөгөөд “... хохирол учруулахгүйгээр халдаж зодох ...” гэдэг өгүүлэмжийг тусгайлан ялгаж тайлбарлах шалтгаан гарцаагүй гарч ирж байна.

- 2. Хуулийн нэр томьёо:** Энэ нь хуульд тусгагдсан хууль зүйн хэллэг буюу тусгайлан тэмдэглэгдсэн өгүүлэмж мөн. Нэр томьёо нь нэг талаас хууль зүйн шинжлэх ухаанаар хүлээн зөвшөөрөгдсөн хэллэг, тэмдэглэгээг тусгахаас гадна хуульд орсон буюу хуульчлан тайлбарласан нэршил, хэллэг мөн хамаарагдана. Жишээ нь: Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэж тайлбарласан нь бий. Энэхүү тайлбарлал нь тухайн ойлголтын нэр томьёог объект болгон тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ ойлголтыг хууль зүйн шинжлэх ухааны тайлбар толь, нэвтэрхий толь бичиг, сурах бичгүүдэд хуулийн тайлбарын үндсэн агуулгатай нь зөрчилдөхгүйгээр өргөжүүлж тайлбарласан байдгийг харж болно. Хуулийн нэр томьёо нь зайлшгүй тайлбар шаардсан шинжтэй байдгаас үүдэн энэ нь ихэвчлэн хуульд тайлбартайгаар тодорхойлогдсон байдаг. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт “Гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг ...” ойлгохоор заасан. Гэтэл энэ нь амьдрал дээр энэ ойлголтоор хэрэглэхэд маргаан дагуулсан хүндрэлтэйгээс гадна хэтэрхий өргөн хүрээгээр тодорхойлсон нь амьдралд бий болсон харилцааг зохицуулахад учир дутагдалтай нөхцөл байдлыг бий болгодгийг судлаачид<sup>29</sup> тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл хуулийн нэр томьёо хэдийгээр товч тайлбартайгаар хуульчлагдсан байдаг ч тайлбарлалын зориулалт, объект талаас нь үзвэл давхар тайлбарлах хэрэгцээг илэрхийлсэн байдгийг анхаарах ёстой. Түүнчлэн гадаад нэр томьёо нь тайлбарын объект болох нь олонтоо. Жишээ нь: Ипотек, лизинг, костодиан, индекс, кадастр, мандат, дипломат, дилер, жендэр, арбитр, нотариат, кибер халдлага, интернет, систем, стандарт гэх мэт. Эдгээр нэр томьёоны зарим нь хуульд өнгөцхөн тайлбартай тусгагддаг

<sup>29</sup> А.Дугармаа, Гэр бүлийн эрх үйн нэр томьёоны зарим асуудал, “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 166-р тал.

ч хууль зүйн нэр томъёо судлалын хувьд утгачлан тодорхойлогдсон тэрхүү утгаар нь нэрлэн хэрэглэж ойлгох учиртай. Бүхэлд нь авч үзвэл хуулийн нэр томъёо (*идэвхтэй хэрэглэгддэг 2500 шахам хууль зүйн нэр томъёо*) нь тайлбар, тайлбарлалын үндсэн объект болохын хувьд нэг талаас энэ нь хэрэглээний шинжтэйгээс гадна хэрэглэгдэх зориулалтыг шууд хангах чиг үүрэгтэй байна. Түүнчлэн хуулийн заалтуудын утгыг тайлах, хэрэглэх нөхцөлийг тодорхойлоход чухал түлхэц үзүүлдэг.

3. **Хуулийн утга, уялдаа, хамаарал:** Энэ нь хуулийн тайлбар, тайлбарлалын объектын чухал бүрэлдэхүүн хэсэг болно. Учир нь хуулийг тайлбарлах агуулга, шаардлага нь зөвхөн хуулийн заалт, нэр томъёог тайлбарласнаар хязгаарлагдахгүй, гол нь хуулийн утга, агуулга болон тэдгээрийн уялдаа, холбоо, хамаарал, нөхцөлүүдийг зөв ойлгож тодорхойлох учиртай билээ.<sup>30</sup>Өөрөөр хэлбэл хуулийн аль нэг зүйл, заалтад хийсэн тайлбар нь бусад зүйл, заалтынхаа ач холбогдлыг алдагдуулсан байж болохгүй. Иргэний хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага, үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана” гэж заасан нь бий. Гэхдээ хуулийн утга, агуулгыг алдагдуулахгүйгээр объектив хандлагад нийцүүлж тайлбарлахыг хэлнэ. Харин хэт субъектив хандлагаар “хуулийг давж”, хуулийн утгаас ангид байдлаар тайлбарлаж болохгүй гэсэн үг билээ. Хуулийн утга, агуулга гэдэг нь тухайн хуулийн “амин сүнс” нь мөн бөгөөд хуулийн зорилго, зарчим, түүний зориулалтын үндсэн нөхцөл, мөн чанарын илэрхийлэл мөн. Хуулийн утга нь хуулийн зорилго ба түүнийг хангах гол агуулга, зохицуулах зүйлийн хэмжээ, хязгаараар тодорхойлогдсон байна. Хуулийн утга нь тайлбарын объект болохдоо шууд агуулгаар нь хэрэглэх нөхцөл зарим үед тодорхой бус байж болно. Тэгвэл уг хуулийн зорилго, зарчмыг онцгойлон анхаарч хандах замаар уг асуудлыг авч үзэх ёстой.
4. **Хуулийн зорилго:** Энэ нь тухайн хуулийн агуулга ямар хүрээнд илэрхийлэгдэх тэрхүү чиг хандлагыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл хуулийн зохицуулах зүйл ямар харилцааг тодорхойлох вэ? гэдгийг илэрхийлдэг. Ихэнх хууль Монгол Улсын хувьд тодорхой зорилтыг тусган томъёолсон байдаг. Хуулийн зорилго, зорилт нь эрх зүйн мөн чанарын хувьд нэг утгатай. Ихэнхдээ хуулийн зорилго, хуулийн зорилт гэсэн томъёоллоор хуульчлагдсан байх ажээ. Хуулийн зорилго нь эрх зүйн үзэл баримтлал, чиглэлийг хуулийн зарчим, агуулгад нийцүүлж, шууд бус илэрхийллээр томъёологддог бол хуулийн зорилт нь хуулийн бүтцийн эхэнд шууд томъёоллоор тусгагдсан байдаг. Зарим тохиолдолд хуулийн зорилго шууд тодорхойлогдох нь бий. Жишээ нь: 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 1.1

<sup>30</sup> Н.А.Власенко, Язык права, Н., 1997, А.М.Васильев, Правовые категории, М., 1976 зэрэг эх сурвалжаас тодруулж үзнэ үү.

дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэж заажээ. Энэхүү зорилгыг тайлбарын объектын агуулга, нөхцөл талаас нь авч үзвэл өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн зорилттой харьцуулахад харьцангуй явцуу бөгөөд нэлээд ерөнхий утгаар томъёолсон нь харагдана. 2002 оны Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино” гэж Эрүүгийн хуулийн зорилтыг тодорхойлж байв. Хуулийн зорилго, зорилт нь тухайн хуулийн агуулгыг бүхэлд нь бүрэн тусгасан байхаас гадна мөн чанарыг нь оновчтой илэрхийлсэн байх ёстой. Эрүүгийн хууль бол гол нь нийтийн болон хувийн эрх ашиг, өмч, халдашгүй эрхийг шууд хамгаалахад чиглэгдэх учиртай билээ. Зарим хуулийн зорилт нь тухайн хууль болон бусад холбогдох хуулийн зорилт, агуулгыг тусгасан шинжтэй байдаг. Жишээ нь: Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавигдах шаардлага, төрийн алба хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулахад оршино” гэжээ. Эндээс харахад төрийн албаны нийтлэг зохицуулалтад хамаарахаас гадна төрийн алба тус бүрийн институтийг тодорхойлоход болон нийтийн албаны тогтолцооны эрх зүйн орчныг тогтооход холбогдол бүхий хууль болох нь харагдаж байна. Хуулийн зорилго, зорилт нь хуулийн агуулгатайгаа нийцэж зохицуулалтын хүрээ хязгаарыг бодитойгоор тусган тодорхойлсон байх ёстой. Ийм нөхцөлд хуулийн утга, агуулгад системчилсэн логик тайлбар хийх боломж бүрдэнэ.

- 5. Хуулийн зарчим:** Энэ нь хуулийн тайлбарын нэг чухал объект болдог. Хуулийн зарчим гэдэг бол тухайн хуулийн зорилго, агуулгыг хангахад чиглэгдсэн эрх зүйн үзэл баримтлал бөгөөд хуулийн хэрэглээний арга зүйн чиглэмж нь болно. Жишээ нь: Шинэ Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хүнийг үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн заалтыг гэм буруугийн зарчмын нэг агуулга болгон хуульчилснаар өмнө нь гэмт хэрэгт тооцож байсан гүтгэх, доромжлох хэргийг гэмт хэрэгт тооцохгүйгээр зөрчилд хамааруулсан байна. Энэ хуулийн 1.2 дугаар зүйл (“Хууль ёсны зарчим”)-ийн 4 дэх хэсэгт “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэж заасан нь хуулийг тайлбарлан хэрэглэхэд шинэ алхам болсон юм. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийг олон улсын

эрх зүйн нийтлэг хэм хэмжээ, зарчим, жишигтэй уялдуулахад чухал ач холбогдолтой. Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно” гэсэн нь эрүүгийн эрх зүйн суурь зарчимд харшилж байгаа бөгөөд төсөөтэй хэрэглэхийг хориглох болон “*lex certa*” зарчимтай зөрчилдсөн заалт болсон билээ. 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1.7.3 дахь хэсэгт “Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно” гэж заасан нь хэргийн бодит байдлыг тогтоох зарчмын нэг агуулга мөн боловч мэтгэлцэх явдал нь эрүүгийн процессын зарчим болохыг үгүйсгээгүй байна. Хуулиудад тусгагдсан зарчмууд нь хуулийн тайлбарлах зүйл буюу объектын салшгүй бүрэлдэхүүн хэсэг төдийгүй хуулийн заалт, нэр томьёо, ухагдахуун болон утга, агуулгыг тайлбарлах чухал нөхцөл нь болдог. Тайлбарлал бол тайлбарын агуулгын илэрхийлэл бөгөөд оновчтой, бодитой, зохистой байхаас гадна эрх зүйн логик үндэслэл бүхий хууль зүйн шинжлэх ухааны хүлээн зөвшөөрсөн арга зүйг хэрэглэсний үр дүнг тусгасан байдгаараа онцлогтой.

### 1.5. Хууль зүйн техник, нэр томьёо

“Хууль зүйн техник”<sup>31</sup> гэдэг ойлголт нь эрх зүйн зориулалтын утгаараа эрх зүйг бүтээх буюу хууль тогтоох ажиллагааны хүрээнд илүү хамааралтай боловч хуулийг тайлбарлан хэрэглэхэд зайлшгүй холбогдож яригддаг. Эрх зүйн онолд “Хууль зүйн техник гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний актын төслийг боловсруулах, хэлэлцэх, батлан гаргахад зайлшгүй баримтлах технологийн горим, техник хэрэгсэл, тэдгээрийн уялдан холбогдсон арга, зарчим, практик чиглэмжийн цогц бүрдлүүд мөн.”<sup>32</sup> Орчин үед “хууль зүйн техник” гэдэг ойлголтыг өргөн утгаар нь бус харин эрх зүйн хэрэглээний талаас нь прагматик хандлагаар тодорхойлох болсон байна. Жишээ нь: Оросын эрдэмтэн Т.В.Кашанина “Юридическая техника” гэсэн өөрийн бүтээлдээ “Хууль зүйн техник гэдэг нь хууль зүйн ажлыг хийх болон түүний явцад хууль зүйн баримт бичиг боловсруулах дүрэм, багаж хэрэглүүрийн цогц”<sup>33</sup> гэж тодорхойлсон нь бий. Доктор Ч.Нямсүрэн “Хууль зүйн техник нь эрх зүйн хэм хэмжээний болон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актуудыг бэлтгэх, хэлбэршүүлэх, эмхлэн цэгцлэх болон түүнийг хэрэглэхэд ашиглагдаж байгаа журам, арга, хэрэгслүүдийн цогц”<sup>34</sup> гэж тодорхойлсон. Доктор (Sc.D) Д.Лүндээжанцан бичихдээ “... Эрх зүйн нэг бүрчилсэн зохицуулалтын буюу

<sup>31</sup> “Хууль зүйн техник” - латины “Juris techne” - “Хуулийг урлах ур чадвар, урлахуй” гэсэн язгуур үгийн утгыг илэрхийлж гарч ирсэн ба оросоор “юридическая техника”, англиар “legal technique” - “Хуулийг бүтээх арга зүй, ур чадвар, технологийн горим” гэсэн агуулгыг тусгаж, илэрхийлдэг ажээ (Д.Б.).

<sup>32</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ., 2010, 158-р тал.

<sup>33</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник (С.Гэрэлмаа, Д.Отгончимэг, Н.Тунгалаг нарын орчуулга), УБ., 2016, 73-74-р тал.

<sup>34</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, УБ., 2010, 223-р тал.

эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актууд олон тооны байдаг учраас тэдгээрээс ижилтгэх, нэг стандарт шаардлагад нийцүүлэхийг шаардах нь зүй ёсных юм. Ийм учраас эрх зүйг хэрэглэх техник нь эрх зүйн салбар бүрийн онцлогоор тодорхойлогдох боловч нэгдсэн нэг стандарт, загварт захирагдах зүй тогтолтой”<sup>35</sup> гэж дурджээ. Эрх зүйн хэм хэмжээний бүтцийн болон чиг үүргийн онолын зарим судлаачид “...Хуулийн хэрэглээний болон тайлбарлан хэрэглэх арга зүй нь хууль зүйн техникийн тусгай төрөл ...”<sup>36</sup> болохыг тэмдэглэсээр ирсэн ба ялангуяа хуулийг тайлбарлах техник нь эрх зүйг хэрэглэсэн акт, баримт бичиг, шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд зайлшгүй холбогдох учиртай ажээ.

Хууль зүйн техникийн мөн чанарыг ойлгохын тулд түүний зорилгыг танин мэдэх нь чухал юм. “Хууль зүйн техникийн зорилт нь хууль тогтоомжийн байх ёстой хэлбэр, агуулгад оруулан эрх зүйн соёлыг илтгэн харуулах, хууль зүйн нэр томъёо, хэл найруулгыг нийтэд ойлгомжтой, хүртээлтэй хэрэглэж, хэвшүүлэх ...”<sup>37</sup> явдал бөгөөд ялангуяа хуулийг тайлбарлан хэрэглэхдээ хууль тогтоогчийн хүсэл зоригийг агуулгаар нь нээн илрүүлж илэрхийлэх, эрх зүйн хийдэл, зөрчилдөөнийг даван туулах, эрх зүйн зорилго, зарчмыг хамгийн зохистойгоор харуулахад чиглэгдэнэ. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын салбарын хувьд хууль зүйн тусгай тайлбар хийх замаар хууль хэрэглэх техникийн горим, стандартыг дагаж мөрдөх нь тухайн асуудлын хувьд онцгой ач холбогдолтой юм. Хууль зүйн тусгай тайлбар хийх арга, аргачлал нь эрх зүйг хэрэглэх техникийн үндсэн бүрэлдэхүүн, төрөл хэсэг нь болдог.<sup>38</sup> Хууль зүйн техникийн мөн чанар, агуулгыг бүрэн таньж, эзэмшихийн тулд хууль зүйн техникийн ерөнхий болон тусгай дүрэм, арга, зарчмуудыг судлах нь чухал юм. Хууль зүйн техникийн ерөнхий дүрэм гэдэг нь хууль зүйн агуулга бүхий эрх зүйн хэм хэмжээний акт гаргах, хэрэглэх болон хууль зүйн ажил гүйцэтгэх, эрх зүйн баримт бичиг боловсруулан гаргахад баримтлах технологийн нийтлэг горим, арга зүйн чиглэмж, түгээмэл арга барилуудын цогц мөн.

**Хууль зүйн техникийн ерөнхий дүрэм** нь аливаа хууль тогтоомжийг тухайн нийгмийн хэрэгцээ, бодит байдлын шаардлагатай явцав зохицолдуулж, нийцүүлэх нөхцөл, агуулгыг хангахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл бүхий л хуулиудад тавигдах хамгийн нийтлэг стандарт, шалгуур нөхцөлүүдийг тодорхойлох явдал юм. Хууль зүйн техникийн нийтлэг хэм хэмжээ, нөхцөлүүд нь зөвхөн хууль тогтоох техникээр хязгаарлагдахгүй, хуулийг хэрэглэх техник, шүүн таслах ажиллагааны баримт бичиг боловсруулах техникийг нэгэн адил өөртөө тусгасан шинжтэй байдаг.<sup>39</sup> Хууль зүйн техникийн онол,

<sup>35</sup> Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, УБ., 2016, 80-р тал.

<sup>36</sup> Brain Bix, Jurisprudence: Theory and context, N., 1999, p. 78-79.

<sup>37</sup> О.Амархүү, Эрх зүйн онол, УБ., 2018, 200-р тал.

<sup>38</sup> С.С.Алексеев, Общая теория права (Том 2), М., 1982, с. 303-304

<sup>39</sup> С.С.Алексеев, Проблемы теории права, Свердловск, с. 313.

арга зүй судлалын тэргүүлэгч эрдэмтдийн дийлэнх хэсгийн үзэж байгаагаар<sup>40</sup> хууль зүйн техникийн ерөнхий дүрэм нь:

1. Агуулгын дүрэм;
2. Бүтцийн дүрэм;
3. Хэлбэржүүлэлтийн дүрэм;
4. Логикийн дүрэм;
5. Хэл зүйн дүрэм;
6. Процедурын дүрэм гэсэн зургаан хэсгээс бүрдэнэ.

**Агуулгын дүрэм** гэдэг нь хууль тогтоомжийн хэм хэмжээнүүд ба хэрэглээний нийтлэг өгөгдсөн нөхцөлүүдийг тухайн бодит байдлын шаардлага, хууль тогтоогч хийгээд хууль хэрэглэгч субъектын хүсэл зориг, үйлдлийн гүйцэтгэлтэй нийцүүлж, уялдуулах шалгуур, стандартыг хэлнэ. Тухайлбал, хуулийн зорилгыг тухайн зохицуулах ёстой нийгмийн харилцааны бодит шаардлагатай уялдуулж тодорхойлох, эсхүл тухайн хуулийн зорилго, зарчмууд нь хуулийн бүлэг, зүйл, хэсгийн нөхцөл, агуулгатайгаа нарийн нягт уялдаж нийцсэн байх хэрэгцээг хангахад оршино. Хуулийн ерөнхий анги, хэсэг нь тусгай анги, хэсэгтэйгээ бүрэн дүүрэн, бодитойгоор нийцэх ёстойг харуулна. Үүнээс гадна аливаа хууль зүйн үйл ажиллагаа<sup>41</sup> нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй төрийн бодлогоор дэмжигдэж хамгаалагдсан байдаг. Нэг жишээ дурдахад Захиргааны ерөнхий хуулийн 1 дүгээр зүйл (*хуулийн зорилго*), 3 дугаар зүйл (*хуулийн үйлчлэх хүрээ*), 4 дүгээр зүйл (*захиргааны үйл ажиллагааны зарчим*)-д заасан хэм хэмжээнүүд нь хоорондоо шууд хамааралтайгаар уялдаж, холбогдсон төдийгүй хэрэглэх нөхцөлүүд нь нийтлэг шалгуурыг шаардсан байвал эдгээр нь хууль зүйн техникийн агуулгын дүрэмтэй тохирч байгааг харуулна.<sup>42</sup> Хэрэв хуулийн зорилго, хамрах хүрээ, зарчим болон нийтлэг нөхцөлүүдийг хуульчилсан хэм хэмжээнүүд нь хоорондоо зөрчилдсөн, уялдаатай буюу шууд хэрэглэх боломж хязгаарлагдсан нөхцөлд энэ дүрмийн шаардлага хангагдаагүй гэж үзнэ.

**Бүтцийн дүрэм** гэдэг нь хуулийг гаргах болон тайлбарлан хэрэглэх үйл ажиллагаанд системчлэн, дэс дараалалтай хандах, органик зохион байгуулалтын зүй тогтол, зарчмыг зайлшгүй харгалзах шаардлагыг илэрхийлдэг. Хуулийн зүйл, анги, хэсгүүд нь ерөнхий ба тусгай нөхцөлөөр хэрэглэх системчлэлийн шалгуурт нийцсэн байх, эх сурвалжийн баримтат өгөгдөхүүн, нарийвчилсан зүйлчлэлийг тогтоох, хэрэглэх явдлыг тусгана. Нэг хуулийн нэг буюу хэд хэдэн заалт нь бусад хуулийн тодорхой хамааралт нэг ба хэд хэдэн заалттай системчлэлийн нөхцөлийн дагуу бүтцийн хувьд зохицуулалт, хэрэглээний агуулгаар шууд холбогдож хангагдах ёстой гэсэн үг. Харин шууд зохицуулах болон хэрэглэх зориулалт бүхий тодорхой нэг

<sup>40</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник (*монгол орчуулга*), УБ., 2016, 93-95-р тал; Н.А.Власенко, Правила законодательной техники в нормативных правовых актах субъектов РФ, Н., 2001, с. 170-174; Ю.А.Тихомиров, Законодательная техника: Понятие и элементы, М., 1994, с. 9 г.м.

<sup>41</sup> “Хууль зүйн үйл ажиллагаа”-“Юридическая деятельность”, “legal activities” хууль тогтоох төдийгүй хууль хэрэглэх процесс ажиллагааны нэгдмэл утгыг илэрхийлнэ (*Д.Б.*).

<sup>42</sup> Т.В.Кашанина, Хууль зүйн техник (*монгол орчуулга*), УБ., 2016, 96-99-р тал.

заалт нь өөр бусад заалттайгаа уялдахгүй зөрчилдөх зэргээр хэрэглээний нөхцөл хангагдахгүйд хүрвэл бүтцийн дүрэм хэрэгжих боломжгүй байдал үүснэ. Оршил, үндсэн, төгсгөлийн гэсэн ерөнхий бүтцээс гадна тайлбарласан, нотолсон, дүгнэсэн байх шалгуурыг хангана. Ялангуяа энэ нь зарим тохиолдолд шүүхийн шийдвэр, тогтоол гаргах ажиллагааны стандарт тогтооход чухал ач холбогдолтой дүрэм юм.

**Хэлбэржүүлэлтийн дүрэм** гэдэг нь нэг талаас эрх зүйн хэм хэмжээнүүдийн хуульчлагдсан хийгээд албан ёсны дүр, төрх олж тогтсон байдлыг илэрхийлэхээс гадна аливаа хууль зүйн үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичгүүдийг (*тушаал, тогтоол, захирамж, шийдвэр, гэрээ*) чухам ямар бүрдүүлбэрээр боловсруулж гаргах болон гүйцэтгэх стандарт нөхцөлийг илэрхийлнэ. Энэхүү хэлбэржүүлэх дүрмийн шаардлагыг ямар ч хууль тогтоогч болон хуульч, шүүгч, төрийн албан тушаалтан хэн боловч хайхрахгүй байж болохгүй. Хэлбэржүүлэлтийн буюу бүрдүүлбэрийн дүрэм нь хууль ба хуулийг хэрэглэх баримт бичгийн эрх зүйн хэм хэмжээний хууль зүйн үндэслэлд нийцсэн байдал, албан ёсны баримтат эх сурвалжийг тусгасан хийгээд хууль зүйн хүчин чадлыг баталгаатай хангасан байх зэрэг шаардлагыг тусгана. Хуульд байхгүй үндэслэлийг субъектив үнэлэмжээр гаргаж ирэх эсхүл ямар ч үндэслэл дурдахгүйгээр тухайн дүгнэлт, шийдлийг тодорхойлох, материаллаг бус процессын журмыг бүрдүүлбэрийн голлох нөхцөл болгон үндэслэх зэрэг зохисгүй хандлага нь энэ дүрэмд харшилсан үйлдэл болно. Түүнчлэн тухайн акт нь нэр төрөл, агуулга, огноо, гарын үсэг зэргийг наад захын шалгуур болгон хэлбэржүүлсэн байна.

**Логикийн дүрэм** нь хууль тогтоох хийгээд хууль хэрэглэх, тайлбарлах техникийг зүй тогтолт шинжээр нь хангахад чухал түлхэц үзүүлнэ. Логикийн дүрэм гэдэг нь эрх зүйг бүтээх болон эрх зүйн хэрэглээнд сэтгэлгээний бодомж бүхий үе шаттайгаар тодорхой алхам хийх, учир шалтгаан, хамааралт байдлыг үндэслэлт шинж, аргументацийн нөхцөлөөр тодорхойлохыг хэлнэ. Тухайлбал, эрх зүйн хэрэглээний хүрээнд хууль зүйн тодорхой хэрэг, тохиолдол, асуудлыг шийдвэрлэхийн тулд хэм хэмжээний гипотезийн нөхцөлүүдэд анализ хийж, дедукцийн бодомж, төсөөллийг гаргаж авах, эрх зүйн субсумци хийх, хууль зүйн үр дагавар бүхий дүгнэлт, шийдлийг гаргах аргументацийн нотолгоо, силлогизийн үндэслэгээ, хамаарлыг тодорхойлох зэрэг логик үйлдлүүд хийхийг шаарддаг. Энэ нь зөвхөн прагматик мэдлэг, туршлагад үндэслэгдэхгүй бөгөөд гол нь академик түвшний онолын мэдлэг, сэтгэлгээний ур чадвараас ихээхэн хамаарна.

**Хэл зүйн дүрэм** нь хууль зүйн бүхий л үйл ажиллагаа эцсийн эцэст хүмүүст зориулагдсан, тэдний ойлголт, ухамсар, соёлын агуулгад нийцэхүйц бөгөөд хэрэглэгч, үйлчлүүлэгч, иргэн бүхэнд хуулиуд бүрэн ойлгомжтой, утга, агуулгын хувьд маш тодорхой, шууд хэрэгжүүлэхэд хялбар дөт байх учиртай. Хэл зүйн дүрмийн хувьд жишээ нь: монгол үг, өгүүлбэр, найруулга зүйн стандарт, шаардлагад бүрнээ нийцсэн байх агуулгыг илэрхийлнэ. Ялангуяа хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн гэрээ байгуулах, шүүхийн шийдвэр,

тогтоол боловсруулахад хэл зүйн дүрмийг ягштал сахин хангах явдал онцгой ач холбогдолтой. Өмнөх хэсгүүдэд энэ талаарх эх сурвалж ба арга зүйн зарим асуудлыг товч хөндөж бичсэнийг уг ойлголттой холбон авч үзэх нь зүйтэй. Ер нь тодорхой бус, хоёрдмол утгатай, ерөнхий буюу ойлгомжгүй хэллэг, өгүүлэмж нь хэл зүйн дүрэмд харшилж буйг харуулна. Тодорхой, ончтой<sup>43</sup>, хүртээмжтэй албан ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шалгуур бий.

**Процедурын дүрэм** нь хууль зүйн техникийн ерөнхий дүрмийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ихэнхдээ процессын агуулга бүхий үйл явцын үр дүнг тусгахаас гадна хууль ёсны байх, ончтой, үр дүнтэй, зохистой, нотолгоотой бөгөөд маргаангүй байх шалгуурыг хангахыг шаардана. Процесс буюу ажиллагаа нь цаг хугацааны хэмнэлтийн нөхцөлийг хангах, үйлдлүүдийн уялдаа шатлал, хамаарлыг тодорхойлох, гүйцэтгэлийн бүрэн ба оновчтой байдлыг хангах процессын эцсийн шийдэл, санкцийн нөхцөл, хэмжээ, үр дагаврыг зөв тодорхойлох зэрэг стандарттай байдаг. Процесс нь бүхэлдээ хууль ёсны болоод нийтлэг ашиг сонирхолд нийцсэн, нэг удаагийн буюу тогтвортой, үр нөлөөтэй хэрэгжих агуулгыг тусгана.

Бүхэлд нь авч үзвэл хууль зүйн техникийн ерөнхий дүрмүүд нь тухайн техникийн бүрэн агуулгатай зохицолдсон байхаас гадна эрх зүйн үр нөлөө, чанар, оновчтой, тогтвортой хүртээмжтэй байдлын чухал илэрхийлэл болно.<sup>44</sup> Хууль зүйн техникийн ерөнхий дүрэм, аргад үндэслэн хууль зүйн техникийн тусгай аргачлал, зарчмууд нь салбар эрх зүйн нарийвчилсан зохицуулалтын явцад хэрэглэгддэг болохыг санах нь зүйтэй. Хууль зүйн техникийн үндсэн, түгээмэл аргуудад:

1. Хийсвэрлэн томъёолох арга;
2. Казусын томъёоллын арга;
3. Либераль томъёоллын арга гэсэн энэ гурван аргыг хэрэглэдэг.<sup>45</sup>

Орчин үед хууль бүтээхэд чиглэгдсэн дээр аргуудаас гадна хуулийг хэрэглэх техникийн нийтлэг аргуудад аналитик тайлбарын арга, үндэслэгээний аксиомчлох арга, хэсэгчлэн адилтгах арга, бодит үнэлэмжийн арга, зөвшөөрөгдсөн шийдлийг хангах арга зэрэг цөөнгүй аргыг багтаан хэрэглэж иржээ.<sup>46</sup> Эдгээр аргууд нь хөгжингүй орнуудад хууль зүйн техникийн зорилго, агуулга, ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх чухал хөшүүрэг болж хэрэглэгдсээр байна. Хууль зүйн техникийн тогтолцоо нь хууль зүйн техникийн зорилго, агуулга, дүрэм, аргаас гадна түүний хэрэгслээс бүрддэг. Хууль зүйн техникийн хэрэгсэл нь хууль зүйн нэр томъёогоор илэрч, тусгагдсан байдаг.

<sup>43</sup> “Ончтой” гэдэг нь оновчтой, маш тодорхой, шууд хэрэглэх бүрэн боломжтой, хамгийн зохистой өгүүлэмж бүхий хэллэгийг илэрхийлнэ (Д.Б.).

<sup>44</sup> С.Явич, Сущность права, Л., 1985; Эффективность правовых норм, М., 1980; В.Н.Протасов, Проблемы теории права и государства: Вопросы и ответы, М., 1999.

<sup>45</sup> Энэ аргуудын тухай Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ., 2010 оны номын 159-160-р талаас дэлгэрүүлэн уншина уу.

<sup>46</sup> Altmon, Andrew, Critical legal studies, P., 1990; М.Л.Давыдова, Юридическая техника: Проблемы теории и методологии, Волгоград, 2009; Moore R., Legal norms and legal science, Hawaii, 1989 г.м.



**Хууль зүйн нэр томьёо:** Энэ ойлголт нь харьцангуй өргөн хүрээнд хэрэглэгдэх бөгөөд зөвхөн хуулийн нэр томьёогоор хязгаарлагдахгүй юм. “Хууль зүйн нэр томьёо” гэдэг нь хууль зүйн утга, агуулга бүхий эрх зүйн ойлголт, ухагдахууны нэр, утгыг тусгайлан тэмдэглэсэн өгүүлэмж, хэллэг мөн. Энэ нь хууль зүйн ойлголтоос ялгаатай. Хууль зүйн нэр томьёо бол нэг талаас хууль зүйн техникийн хамгийн гол хэрэгсэл төдийгүй эрх зүйн хэрэглээн дэх бүтээлч үйл ажиллагааны танин мэдэхүйн чухал эх сурвалж болдог. Чухамдаа хууль зүйн нэр томьёог зөв оноож, зохистойгоор ойлгож, хэрэглэж чадсанаар эрх зүйн хэрэглээний үр нөлөөтэй, хүртээмжтэй байх нөхцөл бүрэлдэнэ. Нэр томьёоны талаар Д.А.Керимов “...Ойлгогдоно, танигдана гэхдээ тодорхойлохгүй” гэж хэлсэн бол доктор Ч.Нямсүрэн “...Нэр томьёо нь товч, оновчтой, утга санаа бүрэн төгс, тодорхой байх” тухай дурдаж “Хууль зүйн нэр томьёог нийтлэг, хууль зүйн шинжлэх ухааны, тусгай”<sup>47</sup> гэсэн гурван төрөлд авч үзжээ. Хууль зүйн нэр томьёо нь эрх зүйн мэдлэг, практик, судлагдахууны үндсэн ойлголт, утгыг тусгайлан товчлон тэмдэглэсэн өвөрмөц хэллэг болох бөгөөд төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны хэрэглэгдэхүүн болохын хувьд хэрэглээний шинжтэй, утга агуулга нь логик зүй тогтлоор холбогдсон, тогтвортой, гаргалгааны нөхцөлийг тусгасан зэрэг онцлогтой байна. Ялангуяа хуульд тусгагдаж, тайлбарлагдсан байдаг учраас амьдралд ойр, практикт хэрэглэх бүрэн боломжтой байдаг. Эдүгээ дэлхийн хууль зүйн шинжлэх ухаанд хууль зүйн 25.000 нэр томьёог бүртгэн оноож<sup>48</sup> нэвтэрхий толь бичгүүдэд (*Black’s Law dictionary 2012*) тодорхойлж тайлбарласан байна. Эдүгээ Монгол болон эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад хууль зүйн 12.000 нэр томьёо, хэллэгийг нөөцлөн бүртгэж оноож тодорхойлсноос Монгол Улсад 2500 гаруй нэр томьёо хууль зүйн практикт түгээмэл идэвхтэй хэрэглэгддэг ажээ.

Хууль зүйн нэр томьёог эрх зүйн онолын болон терминологи судлалд дараах төрлөөр ялган ангилж үздэг. Үүнд:

1. Хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёо;
2. Хуульд тусгагдсан хуулийн нэр томьёо;
3. Хууль зүйн латин хэллэг, нэр томьёо;
4. Олон улсад, тэр тусмаа олон улсын харилцаанд түгээмэл хэрэглэгддэг олон улсын эрх зүйн хэллэг, нэр томьёо;
5. Хууль зүйн техникийн нэр томьёо г.м.

Дээр дурдсанаас гадна хууль зүйн салбарын биш бусад мэргэжлийн боловч хуульд тусгагдсан нэр томьёог хууль зүйн нэр томьёоны ангилалд хамааруулж үздэг. Хууль зүйн нэр томьёо нь хууль зүйн техникийн хэрэгсэл болохын хувьд дор дурдсан стандарт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Нэр томьёоны үг, утга нь маш тодорхой, оновчтой, ойлгомжтой бөгөөд шууд хэрэглэх боломжтой байх;

<sup>47</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, УБ., 2010, 231-р тал.

<sup>48</sup> “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 14-р тал.

2. Нэр томъёоны утга, тайлбар нь хууль зүйн шинжлэн ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн, түүний онол, арга зүйн үндэслэлтэйгээр үнэн зөв илэрхийлэгдсэн байх;
3. Нэр томъёонууд хоорондоо утга, агуулгын давхардал, зөрчилгүй байх;
4. Нэр томъёоны үг, өгүүлэмж нь хэт ерөнхий буюу хоёрдмол утгагүй байх;
5. Тухайн нэр томъёо нь тухайн хуулийн зорилго, зарчимтайгаа уялдаж, зохицсон байх;
6. Үндэсний хууль тогтоомжид тусгагдсан хууль зүйн зарим нэр томъёо нь соёрхон баталсан олон улсын гэрээнд заасан нэр томъёоны утга, агуулгатай нийцэж тохирсон байх;
7. Сургалт, судалгаа, практикт тогтвортой хэрэглэгдэхээр оновчтой тодорхойлж зориулалтын нөхцөлийг хангасан байх;
8. Нэр томъёоны тайлбар, зориулалт зарчмуудыг тухайн түүхэн цаг үеийн шалгуураар шинэчлэн тодотгож, орчин цагийн нөхцөлд нийцүүлэн тодорхойлж байх;
9. Үндэсний эрх зүйн онцлогийг тусгасан өвөрмөц нэр томъёог хөгжүүлж, баяжуулж байх;
10. Нэр томъёог индексжүүлж, түүний санг тайлбар, тодорхойлолттойгоор системчлэн каталогжуулах г.м.

Хууль зүйн нэр томъёо нь хууль зүйн техникийн бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд хууль тайлбарлан хэрэглэхтэй холбоотой онолын суурь асуудлын нэг яах аргагүй мөн билээ. Орчин үед хууль зүйн латин хэллэг, нэр томъёоны утга, хэрэглээ, зориулалтыг нарийвчлан судлан эзэмших, олон улсад түгээмэл хэрэглэгддэг нэр томъёоны латин утга, арга зүйн зарчмыг зөв ойлгож, хэрэглэх шаардлага өсөн нэмэгдсээр байна. Хууль зүйн техник, нэр томъёог зөвхөн ойлгож, судлах төдийгүй гол нь логик үндэслэл, жишгийн зарчим, дүрмийг нь танин мэдэж, бүтээлчээр зөв хэрэглэх явдал юунаас ч илүү чухал юм. Хууль тайлбарлан хэрэглэхтэй холбоотой онолын суурь асуудлуудыг тоймлон илэрхийлсэн хэсгийг энд хүрээд дуусгая. Энэ хэсэгт авч үзсэн суурь онолын асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гол нь академик түвшинд гаргахыг эрмэлзсэн ба энэ хандлага нь практикийн гэхээсээ илүү онол, арга зүйн болоод танин мэдэхүйн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ  
ТАЙЛБАРЛАХ ТОДОРХОЙ АРГУУД,  
ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭ**

## БҮЛЭГ 2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ТАЙЛБАРЛАХ ТОДОРХОЙ АРГУУД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭ

### 2.1. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онолын урсгал, чиг хандлагууд

Эрүүгийн эрх зүй нь нийтийн болон хувийн эрх ашгийг аливаа гэмт халдлагаас хамгаалах, хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангахад онцгой үүрэг хүлээдэг. Орчин үед эрүүгийн эрх зүй нь тулгуур суурь эрх зүйн хэмжээнд үнэлэгдэх болсноос гадна хүний эрхийн үнэт зүйлсийг зохистойгоор хамгаалах, төр, нийгэм, иргэний хариуцлагыг өндөржүүлэхэд чухал түлхэц үзүүлж байна. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ нь хатуу нөхцөлөөр (“*Hard norm*”) хуульчлагдсан байх шаардлагатай байдгаас үүдэн хуулийг төсөөтэй хэрэглэх тохиолдлыг үргэлж хориглосоор ирсэн билээ. Энэхүү хэм хэмжээний агуулга нь тодорхой, оновчтой байх үндэслэлээр тодорхойлогдож, нөхцөлдсөн байдаг. Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад нэн тэргүүнд төрөлжүүлсэн хуульчлал буюу хуулийн зохицуулалт бүхий бичмэл эрх зүйг дээдэлдэг. Энэ зүй тогтлын дагуу хуульчид, шүүгчид илүүтэйгээр абстракт буюу хийсвэрлэх сэтгэлгээнд тулгуурлан ажилладаг.<sup>49</sup> Эрх зүйн хэрэглээний зарчим, философи нь асуудлыг шийдвэрлэхдээ хэргийн жишиглэлт, шүүхийн шийдвэрт бус харин хуулийн агуулга, түүний нөхцөл, хүсэл зоригт илүү тулгуурлаж ханддаг нь дээрх тогтолцооны гол онцлог юм.<sup>50</sup>

Дээрх үндэслэл бүхий нөхцөл байдлууд нь хуулийн агуулга, мөн чанар, зарчмыг илүүухаж ойлгох, хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлагыг аяндаа нөхцөлдүүлж өгдөг байна. Эх газрын эрх зүйн орнуудад эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүд нэлээд онцлог мөн чанарыг илэрхийлдэг. Эдгээр шинж тэмдгүүдийг нь тоймлон илэрхийлбэл:<sup>51</sup>

1. Эрүүгийн хууль тогтоомж нь төрөлжиж, системчлэгдсэн;
2. Гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн нь хуулиар нарийвчлан зүйлчлэгдэж, ялын санкцийн хамаарлаар хуульчлагдсан;
3. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүд нь бусад салбарын хэм хэмжээтэй харьцуулахад илүү тодорхой, “хатуу нөхцөлөөр” буюу шууд хэрэглэх боломжтойгоор хуульчлагдсан;
4. Эрүүгийн хууль нь өөрөө түүнийг шууд хэрэглэх агуулгыг тусгасан г.м.

Дээрх шинж, онцлог нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг нэгэн мөр ойлгон хэрэглэх, эрүүгийн хуулийг түүний агуулгын хүрээнд тайлбарлах шаардлагыг бий болгоно. Эрүүгийн хуулийг яагаад шууд хэрэглэх хэрэгцээ бий болдог вэ? Эрүүгийн хууль бол бусад хуультай харьцуулахад илүү тодорхой, илүү нарийвчлан тодорхойлогдсон “хатуу” хэм хэмжээнүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь хуулийн агуулгыг өргөжүүлж, абстракт тайлбар

<sup>49</sup> Адомэйт, Хэньшэн, Эрх зүйн онол (монгол орчуулга: Г.Дөлгөөн, Ж.Энхбүрд), УБ, 2017, 55-р тал.

<sup>50</sup> В.И.Зубкова, Уголовное законодательство Европейских стран, М., 2013, с. 27-31.

<sup>51</sup> В.Н.Додонов, Сравнительное уголовное право, М., 2009, с. 33-36.

хийхийг хязгаарласан шинжтэй байдаг.<sup>52</sup> Харин пост-социалист орнууд болон Монгол Улсад Эрүүгийн хууль нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний оновчтой, нарийвчлалтай, тодорхой байх шаардлагыг тэр бүр хангахгүй байх нь бий. Баруун Европын хөгжингүй орнуудын эрүүгийн эрх зүй нь эрүүгийн хууль тогтоомжид байгаа хуульчлагдсан норм, хэм хэмжээний агуулгыг илүү деталь хэлбэрээр дэлгэрүүлж тайлбарласан байдгаас үүдэн тэдгээрийг нэмж тайлбарлах шаардлага тэр бүр гардаггүй. Харин хуульчийн болон шүүхийн практик хэрэглээнд процедурын тодорхой нөхцөлөөр хэрэг, тохиолдлыг шийдвэрлэх явцдаа тайлбарласан агуулга бүхий дүгнэлт, шийдвэрүүд гаргах нь биш. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргыг авч үзэхийн өмнө тухайн хууль буюу хэм хэмжээг тайлбарлах ямар онол, урсгал байдгийг танин мэдэх нь ач холбогдолтой юм. Орчин үед эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онолыг нийтлэг суурь ба тусгай гэсэн хоёр түвшинд ялган үздэг ч тэдгээрийн хоорондын уялдаа, холбоо, арга зүйн чиг хандлагыг бүхэлд нь үнэт зүйлсийн зарчмаар хамааралт байдалд нь авч үзэх болжээ.

Юуны өмнө эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нийтлэг суурь онолын урсгал, чиг хандлагыг авч үзье.

- 1. Эрх зүйн хэрэглээний сонгодог арга зүйн онол (Ф.Савигни, F.Von Savigny /1779-1861/):** Эрх зүйн хэм хэмжээнд дөрвөн аргачлалаар тайлбар хийх тухай энэхүү онол нь дүрмийн, логикийн, түүхэн, системт гэсэн аргыг бүтээлчээр зохистой хэрэглэх нөхцөл, зарчмын тухай номлодог. Хуулийн хэм хэмжээг үгийн утга, зорилгын агуулгаар тайлбарлахаас гадна логик элементийн үүднээс уялдаа, холбоо, зүй тогтолт шинжээр ойлгож хэрэглэнэ. Түүнчлэн хууль гарах түүхэн нөхцөл, шалтгааныг тухайн цаг үеийн шаардлагатай уялдуулж түүхчлэн тайлбарлах ёстой ажээ. Системт хандлагаар бол юуны өмнө тухайн хуулийн зорилгыг түүний дотоод мөн чанартай холбон хуулийн тулгуур суурийг нь гарган ирж, тэр нь тодорхой үед тэрхүү хүрээ хязгаарт тайлбарлах боломжийн тухай өгүүлдэг.<sup>53</sup>
- 2. Эрх зүйн аргументийн онол (Р.Алекс, R.Alexi):** Эрх зүйн хэм хэмжээний тайлбарт утга зүйн, генетикийн, харьцуулсан, зорилгод чиглэсэн арга зүйг илүү боловсруулахын хамт эмпирик, анализ, норматив үндэслэлийг удирдлага болгон хөгжүүлснээс гадна эрх зүйн үндэслэгээний шалгуурыг гол болгон “аналитик ба норматив хандлагыг чухалчлах”<sup>54</sup> тухайд авч үздэг.
- 3. Цэвэр хэм хэмжээний буюу норматив позитивист онол (Х.Кельзен, Hans Kelsen /1881-1973/):** Энэ нь хуулийн заалтыг тухайн үг, өгүүлэмжийн утгаар ягштал баримталж шууд ойлгож хэрэглэх тухай бөгөөд хуульд заагдаагүй ойлголтыг хуулийг давж, хуулиас гадуур тайлбарлахыг үгүйсгэдэг. Энэ нь зарим үед “шударга бус хуулийг сохроор дагах” сөрөг

<sup>52</sup> Современные уголовно-правовые системы: Типы, модели, характеристика, М., 2004, с. 69-71.

<sup>53</sup> Адомэйт, Хэньшэн, Эрх зүйн онол (монгол орчуулга: Г.Дөлгөөн, Ж.Энхбүрд), УБ., 2017, 59-62-р тал.

<sup>54</sup> Т.Саруул, Эрх зүй хэрэглэх арга зүй, УБ., 2014, 12-14-р тал.

үр дагаварт хүргэж байсныг түүхэн эх сурвалж өгүүлдэг. Гэхдээ зарим санааг нь авч хэрэглэх нөхцөлийг үгүйсгэж болохгүй.<sup>55</sup>

4. **Нэр томъёоны буюу абстракт тайлбарын онол** (Ф.Пухта, F.Puchta /1798-1846/, В.Windscheild /1817-1892/): Эрх зүйн нэр томъёо, ухагдахууныг тухайлан салган авч үзэж, ойлголтын утгыг дэлгэрүүлж, тодорхойлох, угсруулан холбох, хэрэглэх нөхцөлийг нь томъёолох замаар тайлбарлахад чиглэгдэнэ. Энэ онол хуулийн агуулга, зорилго, зарчмын уялдааг харгалздаггүй, хэт догматик гэсэн үндэслэлээр шүүмжлэлд өртөж, хэрэглээ нь хязгаарлагдаж ирсэн юм.
5. **Ашиг сонирхлын онол** (P.Heck /1858-1943/): Эрх зүйн хэм хэмжээний зорилго, агуулгад аль нэг ашиг сонирхол тусгагдсан байдгийг үндэслэл болгон нийтийн болон хувийн ашиг сонирхлын ямар хандлага хуульчлагдсан эсэхийг илүү анхаарч тайлбарлах явдал юм. Энэ онол эрүүгийн эрх зүйд төдийлөн идэвхтэй хэрэглэгддэггүй боловч Эрүүгийн хуулийг хэрэглэх хүрээнд эрүүгийн шүүхээс гаргах шийдвэрийн агуулгыг тодорхойлоход зарим үед хэрэглэгдэж болно.
6. **Шатлалын буюу эх сурвалжийн онол** (X.Кельзен): Энэ нь позитивист онолын нэг бүрэлдэхүүн хэсэг боловч эх сурвалжийн онолын баримтлал нь нэг талаас эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний утга, агуулгыг эрх зүйн олон талт эх сурвалжуудын хэм хэмжээний уялдаа холбоо, хэрэглээний шатлал, хамааралт шинжээр нь авч үзэж тайлбарладаг. Эрүүгийн эрх зүйд хамаарал бүхий олон зэрэгцсэн хууль, хууль тогтоомж, олон улсын гэрээ нэгэн зэрэг үйлчлэх болсон өнөө үед эх сурвалжийн онолын хэрэглээ өргөжин нэмэгдсээр байна.

Дээр дурдсан суурь онолуудаас гадна хууль тогтоогчийн хүсэл зоригийг эцсийн хэмжүүр болгох субъектив онолын зэрэгцээ хуулийн хүсэл зориг, агуулгыг байгаа бодит байдлаар нь шалгуур болгодог объектив онолыг энд мөн дурдаж болно. Түүнчлэн “Чөлөөт эрх зүйн онол” гэж нэрлэгдсэн хуулийн зорилго, агуулгыг өргөжүүлж, түүнд захирагдахгүйгээр шүүгчийн дотоод итгэл, үзэмжээр тайлбарлах боломжийг зөвшөөрч, номлосон зарим үзэл баримтлалыг энд дурдаж болно.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тусгай онолуудаас заримыг нь энд дурдвал:

1. **Эрүүгийн эрх зүйн хязгаарлалтын онол** (А.Р.Фон Фейрбах/1775-1833/): Энэ онол нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ нь зөвхөн хуулиар хязгаарлагдах болон түүний тайлбар нь хуулийн агуулгын хүрээнд хийгдэх үндэслэлийг гол баримтлал болгон авч үздэг. Германы эрүүгийн эрх зүйн профессор Эрик Хильгендорф энэ талаар бичихдээ “...Эрүүгийн эрх зүйд хуулиар зааж өгсөн хэм хэмжээг тайлбарлахдаа ... зөвхөн үгийн утга хүртэл хязгаартайгаар тайлбарлахыг зөвшөөрдөг. Үүнээс цааш хэтрүүлбэл ... ялыг хүндрүүлэх буюу ... төсөөтэй хэрэглэсэн

<sup>55</sup> Ханс Кельзен, Хэм хэмжээний тухай ерөнхий онол (монгол орчуулга: М.Хатанбаатар), УБ., 2013, 221-224-р тал.

болно”<sup>56</sup> гэжээ. Эрүүгийн эрх зүйд төсөөтэй хэрэглэхийг хориглодог нь эрүүгийн эрх зүйд хязгаарлалтын онолын үндэслэл, зарчмыг харгалзаж үздэгтэй холбоотой. Энэ нь хууль ёсны буюу хуульд захирагдах зарчмын шаардлагаас урган гарна.

**2. Эрүүгийн эрх зүй дэх релятив буюу харьцангуйн онол (Фр. Фон Лист):**

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээн дэх ялын агуулга, зарчмыг тайлбарлан хэрэглэхдээ туйлчлан хандах, цээрлүүлэн залхаахаас зайлсхийх, ялын үр дүн, оновчтой байдлыг харгалзан засан төлөвшүүлэх, нийгэмшүүлэх зорилгоор, пробацыйн<sup>57</sup> нөхцөлөөр уян хатан, боломжит сонголтоор эрэлхийлж, асуудлыг шийдвэрлэх хандлага юм. Энэ онол нь урьдчилан сэргийлэлтийн нийтлэг ба нэг бүрчилсэн чиг үүрэг, нөлөөллийн ач холбогдлыг эерэг ба сөрөг талаас нь авч үздэг.

**3. Эрүүгийн эрх зүй дэх зайлшгүй шийтгэлийн буюу абсолют онол (И. Кант, В. Гегель):**

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд “уламжлалт шударга ёсны хандлага”<sup>58</sup>, түүний үзэл баримтлалыг Эрүүгийн хуулийг тайлбарлахад гол үндэслэл болгон авч үзэж байсан. Энэхүү онол нь ялын бодлогыг хэрэгжүүлэх төдийгүй эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахад хэрэглэгддэг ба гол нь залхаан цээрлүүлэх, яллах талын хүчин зүйлийг илүү харгалзан гэмт хэргийн хохирол, үр дагаварт яг тохирсон ялыг оноох явдлыг онолын гол үндэслэл болгон авч үздэг. Ер нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай бол заавал ялтай байх, яллах чиг үүргийг зайлшгүй байх ёстой гэж үзэх бөгөөд эдүгээ ч энэ онолын сэтгэлгээ Монгол Улсын эрүүгийн эрх зүйд амь бөхтэй оршсоор байгаа билээ.<sup>59</sup>

**4. Субъектын онол:**

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахдаа түүнийг ямар субъект хэрэгжүүлэх вэ? гэдгээс ихээхэн хамаарч хууль тогтоогч болон Улсын Дээд Шүүх зэрэг эрх бүхий байгууллагын эрх мэдэл, чиг үүргийн хүрээнд тайлбарлах хандлага бий. Тухайлбал, хууль тогтоогч өөрийн хүсэл зоригоо хуульд дутуу тусгасан буюу тодорхой бус, ойлгомжгүй илэрхийлсэн нөхцөлд хуулийг хэрэглэх онцгой эрх бүхий субъект тухайлбал, Улсын Дээд Шүүх хуулийн зорилго, агуулгад нийцүүлж, тодорхой хэргийн шийдвэрлэсэн практикт үндэслэн тайлбарлах явдлыг үндэслэл болгон авч үздэг.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах бусад онолын хувьд гэмт хэргийн зүйлчлэл, бүтцийн болон гэм буруугийн онол, гэмт санааны онолоос гадна хэсэгчилсэн кодификацчиллын онол зэрэг хэд хэдэн үзэл, хандлагыг тухайн асуудлын хүрээнд тодорхойлж, хэрэглэсээр ирсэн юм. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онолууд нь нэг талаас тухайн салбар эрх зүйн

<sup>56</sup> Э. Хильгендорф, Д. Чанцалдулам, Германы Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2015, 23-р тал.

<sup>57</sup> **Пробац** - нөхөн төлбөр, нөхөн сэргээх (Д.Б.).

<sup>58</sup> Уламжлалт шударга ёсны хандлага гэдэг нь шударга ёсны социалист хэв маягийн сэтгэлгээний чиг баримжаа юм. Энэ нь нийгмийн ашиг сонирхолд нийцүүлж, үйлдсэн гэмт хэрэгт нь яг тохирсон ялыг оноох бодлогыг гол үзэл баримтлал болгодог (Д.Б.).

<sup>59</sup> Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2016, 22-р тал.

кодификацчилал, системчлэлийн мөн чанар, онцлогийг харгалздаг бол нөгөө талаас эрүүгийн эрх зүйн зорилго, зарчим чиг үүргийг үр нөлөөтэй хэрэглэх үзэл баримтлал, арга зүйн нь болж өгдөг байна.

## 2.2. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргууд, давуу болон сул тал

Хууль, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах ажиллагаа нь тодорхой аргын тусламжтайгаар хэрэгжинэ. Энэхүү арга нь эрх зүйн хэм хэмжээний зорилго, агуулга утгыг бүхэлд нь болон хэсэгчлэн тодруулж, дэлгэрүүлж тодорхойлоход тус дөхөм үзүүлэх хэрэгсэл, хөшүүрэг механизм юм. Хууль, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга нь эрх зүйг хэрэглэх механизмын салшгүй бүрэлдэхүүн хэсэг төдийгүй эрх зүйн хэрэглээний нөхцөл боломжийг хамгийн үр дүнтэйгээр хангах чухал хүчин зүйл болдог. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ нь харьцангуй тодорхой нэгэн мөр ойлгох боломжтойгоор хуульчлагдсан байх шаардлагаас үүдэн тэдгээрийг тайлбарлах процесс нь бусад салбар эрх зүйтэй харьцуулахад хязгаарлагдмал хүрээнд маш оновчтой тайлбарлагдах ёстой байдаг. Учир нь Эрүүгийн хуулиар гэмт хэргийн шинж бүрэлдэхүүнийг зүйлчлэн томьёолох, ялын зорилго, төрөл, хэрэглээг хуульчлах зэрэг нь маш тодорхой, утга санаа нь бүрэн ойлгомжтойн дээр “хатуу нөхцөл бүхий нормчлогдсон” байх зайлшгүй агуулгыг илэрхийлдэг. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болохгүйн дээр хэрэв Эрүүгийн хуулийн зорилго, зарчим ойлгомжгүй, оновчтой бус, түүний зарим заалт, нэр томьёо нь хоёрдмол утгатай бол эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд зөрчилдөөн, хийдэл үүсэх нөхцөл бүрдэхээс гадна зарим үед зайлшгүй тайлбарлах шалтгаан аяндаа гарч ирдэг. Гэхдээ эрүүгийн эрх зүй дэх хууль тайлбарлах нь юуны өмнө эхлээд хууль тогтоогчийн буюу “аутентик тайлбар”<sup>60</sup> тодорхой хийгдсэн байхыг шаарддаг. Зарим тохиолдолд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүд нь хэрэглэх боломжтойгоор тодорхой хуульчлагдсан байхад субъектив хүсэл зорилгоор хуулийн заалтыг түүний агуулгаас давж, зохиомлоор дэлгэрүүлж тайлбарлах нь сөрөг үр дагавартай юм.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргуудыг авч үзэхийн өмнө тухайн тайлбарын төрлийг хөндөж, харьцуулж ойлгох нь чухал ач холбогдолтой. Эрүүгийн эрх зүй судлалын онолд тухайн тайлбарыг:

- а) Албан ёсны тайлбар
- б) Албан ёсны бус тайлбар гэж ангилж үздэг.

Албан ёсны тайлбарыг дотор нь

- а) Аутентик буюу хууль тогтоогчийн тайлбар (*эх тайлбар*)
- б) Хуулиар эрх олгогдсон буюу төлөөлсөн тайлбар (*легаль тайлбар*) гэж хоёр төрөлд хуваана.<sup>61</sup>

Аутентик тайлбар хийх субъект нь Монгол Улсын хувьд хууль тогтоох дээд

<sup>60</sup> “Аутентик” - “Authenticos” жинхэнэ эх, эх тайлбар гэсэн утгатай (Д.Б.)

<sup>61</sup> Флетчер ДЖ, А.В.Наумов, Основные концепции современного уголовного права, М., 1998; Уголовное право (под ред. В.С.Комиссарова), М. 2012 г.м.



байгууллага болох Улсын Их Хурал юм. Улсын Их Хурал баталсан хуулиуддаа албан ёсны тайлбар, тодотгол хийсээр ирсэн ба ихэвчлэн нэр томъёоны тайлбар, зарим заалтын тодотгол тайлбар зэргээр хязгаарлагдсан байдаг. Төлөөлөх тайлбар буюу легаль тайлбар нь Монгол Улсын хувьд Улсын Дээд Шүүхийн тайлбар мөн бөгөөд Монгол Улсын Үндсэн Хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт “Монгол Улсын Дээд Шүүх нь ... Үндсэн Хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах...” бүрэн эрхтэй байх үндэслэлээр тодорхойлогдоно. Албан ёсны бус тайлбар нь онолын ба мэргэжлийн гэсэн хоёр төрөлд хуваагдах бөгөөд онолын тайлбар нь эрх зүйн хэм хэмжээний агуулга, зорилгод шинжлэх ухааны үндэслэлтэй хийж буй тайлбар бөгөөд оюуны бүтээлч үйл ажиллагаа юм. Мэргэжлийн тайлбарыг үндсэндээ эрх зүйн салбарт практик ажил хийж буй эрх бүхий албан тушаалтан, хуульч, мэргэжлийн хүмүүс хийнэ. Гэхдээ энэ нь мэдээж албан ёсны бус шинжтэй байна.<sup>62</sup>

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга гэдэг нь Эрүүгийн хууль тогтоомжийн зорилго, зарчим, агуулга болон түүний нэр томъёо, заалт, утгыг эрүүгийн эрх зүйн мөн чанар, агуулгад нийцүүлж, тодруулж тодотгох, дэлгэрүүлж тодорхойлох замаар Эрүүгийн хуулийг нэгэн мөр зөв ойлгож, хэрэглэх явдлыг хангуулахад чиглэгдсэн хөшүүрэг, хэрэгслүүдийн нийлбэр цогц мөн. Энэхүү аргыг нийтлэг түгээмэл болон тусгайлан гэж хоёр ангилан авч үздэг. Эрүүгийн эрх зүй дэх хууль тайлбарлах<sup>63</sup> нийтлэг арга гэдэгт хууль зүйн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн, харьцангуй түгээмэл хэрэглэгддэг дөрвөн үндсэн аргачлалыг авч үздэг.<sup>64</sup>

Нийтлэг аргуудыг сонгодог онолын анхны агуулгаар нь сэргээн буулгаж авч үзвэл:

1. **Дүрмийн тайлбар:** Хуулийн текстийг үгийн шууд утгаар нь тодотгож тайлбарлана.
2. **Телеологийн тайлбар:** Хуулийн зорилгыг түүний тодорхойлсон агуулгад нийцүүлж, утгын зориулалт, үндэслэлт шинжээр нь тайлбарлана.
3. **Түүхэн тайлбар:** Хууль тогтоомжийн түүхэн уламжлал, тэдгээрийн үнэт зүйлийг судалж, харгалзан үзэх замаар хууль тогтоогчийн хүсэл зоригийг түүхэн цаг үеийн зорилго, шаардлагад нийцүүлж тайлбарлана.
4. **Системт тайлбар:** Хэм хэмжээнүүдийг жагсаалтад оруулж, эрх зүйн холбоо, шатлал, дамжлага, хамааралт нөхцөлүүдийг эрэмбэлэн тооцож, тэдгээрийн зүй тогтлыг нээн илрүүлэх замаар тайлбарлана.

Дээрх 4 аргачлалын онол хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэсээр ирсэн бөгөөд эрүүгийн эрх зүйд

<sup>62</sup> Ж.Амарсанаа, Ардчилсан эрх зүйт ёс, УБ., 2009, 42-р тал.

<sup>63</sup> “Эрүүгийн эрх зүй дэх хууль тайлбарлах арга” ба “эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга” гэсэн хоёр ойлголт адил утгатай. (Д.Б.)

<sup>64</sup> Германы хуульч, эрх зүй судлал дахь арга зүйн онолыг үндэслэгчдийн нэг Карл Фон Савигнийн онолын аргачлал, дүрэм юм. Friedrich Carl von Savigny, The legal method and modern of law, В., 1848.

идэвхтэй хэрэглэгдсээр ирсэн байна.

Нийтлэг, түгээмэл аргуудыг эдүгээгийн орчин үеийн агуулгаар авч үзвэл:

1. Хэл зүйн тайлбарын арга;
2. Логик тайлбарын арга;
3. Түүхчлэн тайлбарлах арга;
4. Системчлэн тайлбарлах арга зэрэг болно.

**1.Хэл зүйн тайлбарын арга:** Энэ арга нь олон жил идэвхтэй хэрэглэгдсээр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд нэр томъёоны утгыг өргөжүүлэх буюу абстракт байдлаар догматик хандлагаар тайлбарлах болсноор Монгол Улсад болон Пост-социалист орнуудын хувьд нэлээд шүүмжлэлд өртөх болсон билээ. Гэхдээ энэ нь хуульд тусгагдсан болон хуулийг хэрэглэх үндэслэл болж буй хуулийн үг, өгүүлэмж, утгыг нэгэн мөр зөв ойлгож хандахад зохих нөлөө үзүүлдгээрээ ач холбогдолтой. Хуулийн үгийн утга нь хуулийн нэр томъёо, ухагдахуун болон хэм хэмжээний заалтаар дамжин илэрдэг. Эдгээр нь зарим үед шууд ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгох нь бий.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний агуулга нь тодорхой боловч зарим заалт, ухагдахуун, нэр томъёоны утгыг ойлгомжтой тодорхой болгохын тулд Эрүүгийн хуулийн үг, өгүүлбэрийн бүтцийн холбоос, утгын өгүүлэмжид дүн шинжилгээ хийх шаардлага бий болдогтой холбоотой. Хэл зүйн арга нь "... эрх зүйн хэм хэмжээний үгийн аливаа илэрхийллийн утга санааг тогтоох зайлшгүй шаардлага үүдсэн нөхцөлд хэрэглэгдэнэ.<sup>65</sup> Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл, анги, хэсгийн үг, үсэг, өгүүлбэр, найруулгыг тодорхой хүрээнд хэсэгчлэн авч, хэл зүйн болон үг, найруулга зүйн талаас үгийн утгын оноосон агуулгыг нээн илрүүлэх замаар тайлбарлах явдал юм. Хэл зүйн аргаар тайлбарлахын гол онцлог нь хэл зүйн хэлбэр, байгууламжийг задлан шинжилж, нягтлан магадлах замаар тухайн нэр томъёо, ухагдахуун, хэллэгийн хууль зүйн утга болон үгийн мөн чанар, агуулгыг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн буюу шинжлэх ухааны тогтсон үндэслэл, арга зүйд нийцүүлж тайлж, тодорхойлохыг хэлнэ.<sup>66</sup> Ялангуяа ийнхүү тайлбарлах явцад хэрэглэж ойлгоход амаргүй, тодорхойгүй байдал үүсч болзошгүй бөгөөд ийм нөхцөлд англи, герман, орос хэл дээрх хууль зүйн болон хэлний нэвтэрхий толь, сурах бичиг, гарын авлагаас эхлээд хуульч, мэргэжилтнүүдийн бүтээл, тайлбар, зөвлөмжийг судалж үзсэн байх ёстой. Тэр тусмаа хэлний үг зүй, найруулга зүйн дүрмийг ашиглахаас гадна холбоос үг, үйл үг, үйлт нэрийн төгс бус хэлбэрийг үндэслэлтэйгээр, оноосон утгаар нь тодорхойлох нь чухал юм. Жишээ нь 2015 оны Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйлийн 3.2.2 дахь хэсэгт "...Хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан бол хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцно" гэжээ. Энд "үйлдлээр хангасан" гэсэн нь оноосон утгаараа төгс үйлдлийг илэрхийлж буй мэт боловч төгс бус үйлдэл,

<sup>65</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 3 дугаар хэвлэл, 667-р тал

<sup>66</sup> С.А.Комаров, А.В.Малько, Теория государства и права, Учебно-методическое пособие норма, М., 2001; С.Лукич, Методология права, М., 1981, с. 87-88.

завдсан үйлдлээр илрэх нөхцөлийг үгүйсгээгүй байдал харагдаж байна. Үйлдэл хийх ба үйлдлээр хангах хоёр утга нь хэл зүйн агуулга, зориулалт талаасаа ялгаатай.

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж дурджээ. Энэ нь тайлбарын объект болох тухайн ухагдахууны агуулгыг бүрэн илэрхийлж чадаагүйн дээр зарим үед хоёрдмол утга бүхий өгүүлэмж тусгагдсан гэж үзэж болохоор ажээ.” Бэлгийн харьцааны шинжтэй” гэсэн өгүүлэмжийг дутуу тайлбарласнаас гадна эмэгтэйчүүдийн их эмч нь охид, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтэнд үзлэг, шинжилгээ хийх зорилгоор бэлэг эрхтэнд эмнэлгийн багаж, сорилгын хэрэгсэл оруулахыг дээрх заалтад хамааруулж болохоор ойлгогдохыг үгүйсгэх аргагүй юм.

2002 оны Эрүүгийн хууль үйлчлэх хэрэгжиж ирсэн шүүхийн практикаас үзэхэд тухайн Эрүүгийн хуульд хэл зүйн тайлбарыг нэн түгээмэл хэрэглэснээс гадна ихэвчлэн абстракт байдлаар нэр томъёоны утганд тодорхойлолт өгөх замаар тайлбарлаж байв. Гэхдээ цөөнгүй тохиолдолд хэл зүйн аргаар тайлбарлах зарчим, аргачлалаар бус үгийн утгыг субъектив үзэмжээр хуулиас давж, абстракт томъёоллоор илэрхийлж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Зарим жишээ дурдахад, Монгол Улсын Дээд Шүүхийн 2012 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 2 тоот зөвлөмжийн 2-д “... Гэм буруутай этгээд” гэдэгт гэм буруугаа хүлээн мэдүүлж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хамааруулан ойлгож болно” гэж тайлбарласан байдаг. Энэ тайлбар нь хууль зүйн утгын төдийгүй хэл зүйн хувьд үндэслэл муутай, алдаатай болсон гэж үздэг. Учир нь “гэм буруутай этгээд” гэдэг бол зөвхөн шүүхээр гэм буруу нь тогтоогдсон этгээд байх атал сэжигтэн, яллагдагчийг хамааруулсан нь эрүүгийн эрх зүйн зарчим, үгийн утга талаасаа бодитой бус, буруу томъёолол юм. Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-д “...Хүч хэрэглэхээр заналхийлэх...” гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно” гэсэн нь үгийн болон найруулга зүй, утгын хувьд хэт ерөнхий, тодорхой бусаас гадна хэт явцуу байдлаар тайлбарлагдсан байх ажээ. Герменевтикийн болон терминологи талаас авч үзвэл “заналхийлэл зөвхөн айлган сүрдүүлэх зорилго агуулдаггүй бөгөөд хүч хэрэглэх аргаар халдлага хийх бодит байдал бий болгохуйц айдас, цочролд оруулах замаар бие, сэтгэлийн төдийгүй үйл хөдлөлийн дайралт, түрэмгийллийн харьцааг” илэрхийлдэг. Зарим тохиолдолд тухайн тайлбарын агуулга нь Үндсэн хуулийн оноосон утгаас давж илэрхийлэгдсэн явдал бий. Жишээ нь: Монгол Улсын Дээд Шүүхийн 2010 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 15 дугаар тогтоолд “Иргэний журамт үүрэг” гэж Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үүргүүдийг хамааруулж үзэхээс гадна, хүний төрөлх чанараас уламжилсан ёс суртахууны хэм хэмжээгээр тодорхойлогддог зан үйлийн шаардлагыг ойлгоно” гэжээ. Гэтэл Үндсэн Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “иргэний журамт үүрэг”-ийг маш тодорхой, хоёрдмол утгагүйгээр бататган томъёолсон байдгийг дурдах нь зүйтэй.

Дээрх зарим жишээг авч үзсэнээр Улсын Дээд Шүүхийн бүх тайлбарыг бүхэлд нь дүгнэх буюу үгүйсгэсэн хэрэг огт бус, харин абстракт тайлбар нь зарим үед үгийн утга, хуулийг агуулгыг зөрчих нөхцөл байдал үүсгэдэг гэдгийг анхаарах ёстой гэсэн санаа юм. Хэл зүйн тайлбарын давуу болон сул талыг дараах байдлаар тоймлон дүгнэж болно. Үүнд:

**Давуу тал нь:**

1. Хуульд байгаа үгийн хоёрдмол буюу ерөнхий утгыг хэл зүйн талаас нь зөв тайлж, нэгэн мөр болгох боломж олгодог.
2. Тодорхой бус хэллэг, нэр томъёог утгын агуулгаар нь зохистойгоор илэрхийлснээр хуулийн хэм хэмжээний ойлгомжтой байх нөхцөл бүрдэнэ.
3. Хуулийн эргэлзээтэй, зөрчилтэй заалт хэм хэмжээг зөв тайлж, түүнийг төсөөтэй хэрэглэхээс сэргийлэх ач холбогдолтой.

**Сул тал нь:**

1. Хэл зүйн тайлбар нь эрүүгийн эрх зүйн хувьд хязгаарлагдмал нөхцөлд хэрэглэх онцлогтой байдгаас шалтгаалж Улсын Дээд Шүүхээс уг тайлбарыг хэт түгээмэл байдлаар хэрэглэх тохиолдолд Эрүүгийн хуулийн зарчим, агуулгыг эвдэхүйц сөрөг үр дагавартай.
2. Хууль тогтоогч нь Эрүүгийн хуулийн зарим агуулга, заалтыг абстракт байдлаар зөвхөн нэр томъёоны талаас нь тодруулга, тайлбартайгаар хуульчлан батлах нь Улсын Дээд Шүүх абстракт тайлбар гаргах нөхцөл шалтгааныг аяндаа бий болгодог.
3. Улсын Дээд Шүүх нь Эрүүгийн хуулийн зөвхөн нэр томъёог абстракт буюу хийсвэрлэн томъёолох аргаар тайлбарлах нь тухайн тайлбарын мөн чанарыг алдагдуулдаг.

**2. Логикийн арга:** Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний утга санааг логикийн дүрэм, аргачлал, зарчмын тусламжтайгаар нээн илрүүлэх замаар тайлбарлах арга юм. Энэ нь сэтгэж танин мэдэхүйн түвшинд логикийн бодомж, оюун дүгнэлт хийх, сэтгэлгээний гаргалгааг үндэслэл, аргументийн нөхцөлөөр тодорхойлоход чиглэгдэнэ.<sup>67</sup>Зарим тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн урьдчилсан нөхцөлийг тодорхойлсон хэм хэмжээнүүд тодорхой бус, ерөнхий утгаар хуульчлагдсан байх нь бий. Үүний зэрэгцээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргүүдийн бүрэлдэхүүний зарим элементийг тодруулж тайлбарлах шаардлага ч гардаг. Логикийн арга нь хэл зүйн дүрмийн үгийн утга тайлах, холбоос үг хэрэглэх арга, зарчимтай салшгүй холбогддог. Жишээ нь Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн, 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн нэмэлтийн 55<sup>1</sup> дугаар зүйлийн 55<sup>1.1</sup> дэх хэсэгт “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан

<sup>67</sup> В.А.Петрушев, Толкование права, М., 2008; Н.Н.Вопленко, Официальное толкование норм права, М., 2006.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах...”<sup>68</sup> тухай заажээ. “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээ” гэдэг ойлголт нь өнгөцхөн байдлаар үгийн утгаар нь ойлгоход Эрүүгийн хуулийн тусгай ангид тухайлан хуульчилсан харьцангуй тодорхой санкцийн хорих ялын доод хэмжээг илэрхийлнэ гэж төсөөлж болохоор. Гэхдээ логикийн утга, үндэслэлт шинжээр нь мөшгөвөл Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт заасан “Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил байна” гэж тухайн ялын доод дээд хэмжээг зааснаас гадна энэ хуулийн тусгай ангид цөөнгүй гэмт хэргийг зүйлчилсэн “...5 жил хүртэл хорих ял, 3 жил хүртэл хорих ял” гэж заасан тохиолдолд хэрэв интервалт хэмжээг 3-5 жил, 5-10 жил гэж заагаагүй зөвхөн гурав, таван жил хүртэл гэж хязгаарлаж заасан тохиолдолд хэрхэн ойлгох эсэх нь оновчтой бус, тодорхойгүй үлдсэн болж байна. Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 10 дугаар тогтоолын тайлбарт “...Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл хэсэгт хорих ялын доод хэмжээг заагаагүй бол энэ зүйлийг хэрэглэхгүй” гэжээ. Логикийн арга буюу логик тайлбар нь хуулийн хэм хэмжээний үг, өгүүлбэрийн утга, холбоос, нийлмэл утга санаа нь маш тодорхой, сэтгэлгээний бодомжид хоёрдмол санаа агуулаагүй байхыг шаарддаг.

Улсын Дээд Шүүхийн 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 24 дүгээр тогтоолын тайлбарт “... Валютын үнэт зүйл” гэж “ Валютын зохицуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасан “...Мөнгөжсөн, алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг ойлгоно.” гэж заажээ. Энэ тайлбарын агуулгаас үзэхэд дээр дурдсан нөхцөлд зааснаас бусад үнэт металл, эрдэнийн чулуу нь валютын үнэт зүйлд хамаарагдахгүй гэсэн логик тайлбар урган гарч байна.”<sup>69</sup> Логикийн тайлбарын өөрийн онцлог хэрэгсэл нь ойлголт, бодомж, оюун дүгнэлт, логикийн хууль аксиомууд юм. Ойлголт нь мэдэрч таньсны үр дүнд бий болсон мэдлэг, төсөөллөөс урган гардаг бол бодомж нь сэтгэж, ургуулан бодож, эргэцүүлсний үр дүнд гарах ухаарч таньсан сэтгэмж, сэтгэлгээний тусгал нь юм.

Логикийн тайлбарын дүрэм, хуулиудад:

- а) Сэргээн хувиргах төсөөллийг ойлголт болгон цэгцлэх;
- б) Ойлголтыг задлан шинжилж бодомж, эргэцүүлэл гаргах;
- в) Бодомжоос оюун дүгнэлтэд хүрэх;
- г) Оюун дүгнэлтийг задлан шинжлэх ижил төсөөтэй ба түвшин тогтоох, эсрэгээс хийх, утгачлах зэргээр оюун дүгнэлтийн хэрэглээний нөхцөлийг тодорхойлох зэрэг үйлдлийг хамруулж болно.<sup>4</sup>

Логик тайлбарын аксиомчлох арга хэрэгсэл нь үгийн утгын энгийн болон нийлмэл хэллэг, логик холбоосуудын тусламжтайгаар эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг логик зүй тогтолт шинжээр нь нээн илрүүлэхэд чиглэгдэнэ. Хуулийн өгүүлэмж, хэллэгийг логик утгын бодомж

<sup>68</sup> Эрүүгийн хэрэг. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ., 2013, 24-р тал.

<sup>69</sup> С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, УБ., 2009, 182-р тал.

гаргах аргачлалаар тооцож, тодорхойлох хандлага нэлээд түгээмэл байдаг. Ихэнхдээ логик нийлмэл хэллэгийн аксиом, дүрмийг түгээмэл хэрэглэх нь бий. Жишээ нь **конъюнктив** (*нэгдмэл*), **дизъюнктив** (*заагт*), **имплекатив** (*болзолт*), **эквивалент** (*үгүйсгэл*) холбоос үгийн утгын нөхцөлүүдийг хэрэглэх аргачлалаар авч үздэг.<sup>70</sup> Тодруулбал, Эрүүгийн хуульд “ба, бөгөөд, болон, буюу” гэсэн холбоосын нөхцөл утгыг конъюнктив бодомжийг илэрхийлдэг бол “буюу, эсхүл, түүнчлэн” гэдгийг дизъюнктив бодомжийн утгаар ойлгоно. “Хэрэв ... гүй бол”, “хэрэв... бол... мөн” гэсэн утга бүхий холбоос нь имплекатив хэллэгийн дүрмээр тодорхойлогдоно. Харин эквивалент бодомжийг тодруулбал “Болбол... байвал..., Зарим тохиолдолд... Бусад...” зэрэг утга бүхий холбоосоор илрэх бөгөөд “...Бүрэлдүүлж буй бодомжуудынх нь үнэний утга адил тэнцүү байхад өөрөөр хэлбэл зэрэг үнэн юм уу, зэрэг худал байхад үнэн байдаг. Бусад тохиолдолд худал байдаг нийлмэл бодомж юм. Харин имплекатив бодомж бол үндэслэгээ нь үнэн, мөрдлөгөө нь худал байх тохиолдолд худал байдаг, бусад бүх тохиолдолд үнэн байдаг нийлмэл бодомж мөн...”<sup>71</sup>

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 7.2.1дэх хэсэгт “Шүүх энэ хуулийн 5.1дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангах шаардлагатай гэж үзвэл ... оногдуулсан ял дээр нэмж...(7.2.1.3) “... эд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ... хэрэглэж болно” гэжээ. Энэ заалтын утгыг логикийн бодомжоор эргэцүүлж үзвэл нэг талаас шаардлагатай гэж үзвэл эквивалентийн тэнцвэрт бус үгүйсгэх бодомж тусгалаа олсноор энэ нь субъектив шинжтэйгээр заавал хэрэглэх ёстой гэсэн агуулгыг үгүйсгэж байна. Нөгөө талаас “...болно” гэж дуусгасан диспозицийн нөхцөл нь заавал биелүүлэх заалт биш бөгөөд зөвхөн зарим үед хэрэглэж болох зөвшөөрсөн хэм хэмжээ болохыг илэрхийлнэ.

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1.3.1дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заажээ. Энэ нь шууд утгаараа хүнд хэрэгт хүнд ял, хөнгөн хэрэгт хөнгөн ял оноох гэсэн агуулгыг тусгаж буй хэдий ч орчин үеийн эрүүгийн эрх зүйд абсолют (*туйлын*) онол бүхэлдээ шүүмжлэлд өртөх болсноос үүдэн тухайн хуулийн тусгай ангид заасан бүх төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилсан ялын санкцууд бүгдээрээ шударга байх шаардлагад нийцсэн үү? гэдэг бодомж аяндаа гарч ирнэ. Ер нь бол “гэмт хэрэгт ял нь яг тохирсон байх” гэсэн үндэслэгээ нь түүнийг мөрдлөг болгох тусгай нөхцөлүүдтэйгээ зөрчилдвөл уг хэм хэмжээний имплекатив бодомжийн дүрмээр бол бодитой бус, худал болно гэсэн эргэцүүлэлд хүргэж байна.

Эрх зүйн семантик логикоор бол “гэмт хэрэгт тохирсон ял” бус харин

<sup>70</sup> Layman E. Allen, Symbolic logic: Legal documents, T, 1957, p. 54.

<sup>71</sup> Л.Галбадар, Эрүүгийн хуулийн тайлбар: Онол, арга зүйн зарим асуудал (*Магистрын дипломын ажил*), УБ., 2014, 66-р тал.

“ялын хэмжээнд нийцэн түүнээс хамаарсан гэмт хэрэг байх” үндэслэл гарч ирэх бөгөөд “ял нь эзнээ олсон, үр дүнтэй, урьдчилан сэргийлэх агуулгатай байх” ёстой билээ. Мөн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1.3.4 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байдаг. Энэ нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээдийн гэмт хэрэг болон түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүхий хэм хэмжээнүүдтэй агуулгын болон логикийн хувьд зөрчилдөж байна. Учир нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө тодорхой хувь хүн гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн этгээдийн гэмт хэрэг болох бөгөөд тухайн хувь хүн хариуцлага хүлээхгүй, харин хуулийн этгээд л эрүүгийн хариуцлага хүлээх ёстой билээ. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд логикийн хэрэглээ нэн ач холбогдолтой, өргөн нэвтэрсэн байх тул түүний дүрэм, зарчим, арга зүйг судалж, бүтээлчээр хэрэглэж сурах нь чухал юм. Логикийн арга нь үнэндээ Эрүүгийн хуулийн утга санаа, мөн чанар, хэм хэмжээнүүдийн логик зүй тогтлыг бүрэн гүйцэд танин мэдэх, зөв сэтгэж, зохистойгоор ухаалгаар хэрэглэхэд чухал нөлөө үзүүлдгээрээ онцгой ач холбогдолтой. Хуульч, шүүгчдийн хувьд логикийн тайлбар хийх аргыг бүтээлчээр судалж эзэмших нь нэн чухал юм.

### **Логикийн аргын давуу болон сул талыг дүгнэн дурдвал:**

#### **Давуу тал нь:**

1. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүдийг мөн чанар, агуулгаар нь нээн илрүүлж, танин мэдэхэд чухал түлхэц үзүүлдэг.
2. Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг тэдгээрийн хэм хэмжээний уялдаа, холбоо, шалтгаан нөхцөл, хамаарал, логик зүй тогтлыг ойлгож мэдэх, улмаар нэг мөр зөв хэрэглэхэд ач холбогдолтой.
3. Эрүүгийн эрх зүйн зорилго, чиг үүрэг зарчмыг сонгодог утгаар нь тухайн хэм хэмжээнд тусган хуульчлах, тайлбарлах, хэрэглэхэд онцгой үзүүлдэг г.м.

#### **Зарим сөрөг тал нь:**

1. Зарим тохиолдолд хэтрүүлэх буюу туйлшруулж буруу хэрэглэвэл эрүүгийн эрх зүйн хэрэглээний хууль ёсны болон үнэн бодитой байх шаардлагатай зөрчилддөг.
2. Логикийн дүрэм, бодомж, аксиомыг хэт түгээмэл байдлаар эрүүгийн эрх зүйд субъектив байдлаар хамруулж тайлбарлах нь хуулийн зорилго, агуулгатай зөрчилдөх сөрөг нөлөө бий.

**3. Түүхчилсэн болон системчлэн тайлбарлах арга:** Энэ хоёр арга нь хэрэглэх зарчмын хувьд харьцангуй ялгаатай боловч зорилго, агуулга талаасаа зарим нийтлэг шинжийг илэрхийлдэг. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах буюу хэрэглэхэд түгээмэл байдлаар идэвхтэй хэрэглэгддэг. Түүхчилсэн арга гэдэг нь эрүүгийн хууль тогтоомжийг батлан гаргах үеийн түүхэн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ, бодит байдал зэргийг харгалзан

хууль тогтоогчийн болон төрийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлж, түүхэн цаг үеийн агуулгаар тайлбарлахад чиглэгдсэн арга юм. Энэ нь зарим үед улс төрийн арга гэдэгтэй дүйж ойлгогдох нь бий. Энэ аргыг түүхэн цаг үеийн шаардлагаар зарим хууль бус үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох, шинэ төрлийн гэмт хэрэгт ялын бодлогыг чангатгах, Эрүүгийн хуульд зарим нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын соёрхон баталсан Олон улсын гэрээнд Эрүүгийн хуулийг нийцүүлэх зэрэг бодит шаардлагатай уялдуулж тайлбарлах, хэрэглэхэд зориулагдсан байдаг. “Түүхчилсэн тайлбарын гол ач холбогдол нь хууль тогтоогчийн хүсэл зориг, хууль батлагдах үеийн хуулийн бичвэрт хэлэх гэсэн санааг нээн илрүүлэх, ингэснээр хуулиас давсан, хуулийн утга санаатай зөрчилдсөн тайлбар хийхээс сэргийлэх ач холбогдолтой”<sup>72</sup> юм.

“...Түүхчилсэн тайлбарыг тухайн хуулийн хэм хэмжээний бичвэрээс шууд олж харах боломжгүй”. Үүнд хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон онолын, мэргэжлийн зэрэг албан бус тайлбараас харж болно.<sup>73</sup> Жишээ дурдъя. 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулж баталсан Эрүүгийн хуульд “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” (ЭХ.9.1), “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” (ЭХ11.7), “Бэлгийн мөлжлөг” (ЭХ12.3), “Мал хулгайлах” (ЭХ17.12), “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, орон байраар хангах” (ЭХ20.8) гэх мэт өмнө нь байгаагүй, хэд хэдэн зохицуулалтыг уг хуульд шинээр нэмж тусгасныг Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад тэдгээрийг заавал хуульчлах нийгэм түүхэн нөхцөл байдалтай холбон тайлбарласан байдаг.<sup>74</sup> Түүнчлэн өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцогдож байсан “Танхайрах” (ЭХ.181), “Бусдын эд хөрөнгийг булаах” (ЭХ.146), “Гүтгэх” (ЭХ.111), “Доромжлох” (ЭХ.110), “Бусдыг болгоомжгүй алах” (ЭХ.94), “Тарчлаах” (ЭХ.100) зэрэг цөөнгүй төрлийн гэмт хэргийг декриминализаци хийх замаар гэмт хэргийн каталогоос хассаныг мөн л түүхэн болон улс төрийн тайлбар, арга зүйн хандлагаар ойлгон төсөөлөх боломжтой.

Системчилсэн тайлбар гэдэг нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний хэсэг хоорондын уялдаа холбоог харьцуулан шинжлэх, тэдгээрийн бүтцэд бүхэлд нь болон хэсэгчлэн дүн шинжилгээ хийж, тогтолцооны процедур талаас нь тайлбарлах арга юм. Энгийнээр илэрхийлбэл дэс дараалал бүхий алхам, алхмаар эрэмбэлэн харьцуулж тайлбарлахыг хэлнэ.

Хууль тайлбарлах онолоор бол системчлэн тайлбарлах арга нь:

1. Субординаци хийх;
2. Кординаци хийх;
3. Конкретизаци хийх гэсэн гурван аргачлалын дагуу хэрэглэгддэг.

**Субординаци** хийх гэдэг нь эрүүгийн эрх зүйн нэг хэм хэмжээг нөгөө хэм

<sup>72</sup> Л.Галбадар, Эрүүгийн хуулийн тайлбар: Онол, арга зүйн зарим асуудал (Магистрын дипломын ажил), УБ., 2014, 69-р тал.

<sup>73</sup> А.Ф.Черданцев, Толкование права и договора, М., 2003, с. 123.

<sup>74</sup> Монгол Улсын Эрүүгийн хуулийн төсөл (Үзэл баримтлал, танилцуулга, төсөл), УБ., 2015, 9-11-р тал.



хэмжээтэй нь захирагддаг байх агуулгаар тайлбарлана. Жишээ нь Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 2.5.4.3 дахь хэсэгт “бага хэмжээний хохирол гэж 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг ойлгоно” гэж заасан. Тэгвэл уг хуулийн 17.1 дүгээр зүйлийн “Хулгайлах” гэсэн зүйлийн хамаарал нь энэ хуулийн 2.5.4.3 дахь хэсэгт заасан хэм хэмжээнд захирагдсан утгатай бөгөөд 17.1 дүгээр зүйлийн тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй” гэсэн байдаг.

**Кординаци** хийх гэдэг нь тухайн хуулийн хэм хэмжээнүүд бие даасан бөгөөд хоорондоо нийлмэл байдлаар уялдан холбогдсон байх утгаар тайлбарлана. Жишээ нь Эрүүгийн Хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэсэн гэмт хэрэг нь үг, өгүүлбэрийн шууд утгаар ойлгож хэрэглэх боломжгүй, харин энэ зүйлийн 11.7.1 дэх хэсэгт тусгайлан заасан

1. Байнга зодсон;
2. Байнга харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;
3. Байнга... эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн гурван нөхцөлт диспозицийн аль нэг нь илэрч, нотлогдсон байхыг шаардана.

Тэгвэл Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 5.4.4 дэх хэсэгт “Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харьцахыг хязгаарласан, ... эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчсөн” зөрчилд тооцохоор хуульчилжээ. Харьцуулбал “Байнга зодож, хүчирхийлсэн бол гэмт хэрэгт тооцох, харин нэг удаа буюу зарим үед зодсон үйлдэл нь гэмт хэрэг бус, зөрчлөөр тооцогдохоор ялгаа гарч ирж байна. Энэ төрлийн зөрчил гаргасан үйлдэлд 7-30 хоног баривчлах бол тухайн төрлийн гэмт хэрэгт 6 сараас 1 жил хүртэл хорих ял шийтгэх ажээ.

**Конкретизаци** хийх гэдэг нь тухайн хуулийн ерөнхий хэм хэмжээг нарийвчлан задлах, тодотгол хийж, дэлгэрүүлж системчлэх арга юм. Жишээ нь Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлийн “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэдэгт “...16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол...” гэсэн агуулга бүхий үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцож зүйлчилсэн. Энэ нь 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохдоо харилцан тохиролцсон буюу хүч хэрэглэсэн эсэх нь тодорхой бус байдлаар хуульчлагджээ. Зарим утгаар нь хийсвэрлэн төсөөлөхөд “Хүсэл зоригоос гадуур хүч хэрэглэсэн байхыг үгүйсгэсэн байх боломжтой боловч бүхэлд нь дүгнэвэл тодорхой бус ойлгомжгүй утга энд илэрхийлэгдсэн байна. Харин Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “...Бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон ...” гэсэн нөхцөл нь хэдийгээр туйлын тодорхой бус боловч бусдын асрамж, эрхшээлд байх

хүүхдүүдийн хувьд ямар нэгэн дарамт, шахалтын улмаас бэлгийн харьцаанд орох нөхцөл боломжтойг үгүйсгэх аргагүй юм. Конкретизаци хийх нь тодорхой бус нэг буюу хэд хэдэн хэм хэмжээний хооронд харьцуулалт хийхэд чиглэгддэг.

Системчлэх арга нь хэм хэмжээний заалт хоорондын чиг үүргийн холбоосыг тайлбарын объект, тайлбарлах хэрэгцээтэй нягт холбон харьцуулан шинжилж авч үзнэ. Ялангуяа эрүүгийн эрх зүйн хувьд тухайн салбарын хэм хэмжээнүүдийн давхардал, хийдэл, зөрчилдөөнийг нээн илрүүлэх, даван туулахад зохих түлхэц үзүүлдэг.

Дээр дурдсан хоёр аргуудын давуу ба сул талыг нь тус бүрд нь дүгнэн илэрхийлбэл:

### **Түүхчлэн тайлбарлах аргын давуу болон сул тал**

#### **Давуу тал нь:**

1. Хууль тогтоомжийн хүсэл зоригийг илүү бодиттойгоор нээн илрүүлж, эрүүгийн хууль, хэм хэмжээний зорилгыг танин мэдэхэд тус дөхөм үзүүлдэг.
2. Эрүүгийн хууль, түүнд тусгагдсан хэм хэмжээний зарчим, агуулгыг төрийн бодлогын үзэл баримтлалтай холбон ойлгох, түүхэн цаг үеийн шаардлагад нийцүүлж ойлгох талаасаа чухал ач холбогдолтой.
3. Тухайн нийгмийн хөгжлийн бодит байдал, хэрэгцээ шаардлагыг Эрүүгийн хуулийн мөн чанартай холбон ойлгож, хэрэглэхэд чухал түлхэц үзүүлдэг.

#### **Сул тал нь:**

1. Зарим үед Эрүүгийн хуулийн зорилго, зарчим, агуулгыг хэт улс төржүүлж, субъектив хандлагаар ойлгох, түүний хэрэглээнд алдаа гажуудал гарах нөхцөлийг үүсгэдэг.
2. Эрүүгийн хуулийг хэрэглэх үйл явц буюу шүүхийн практикт төрийн зүгээс улс төрийн бодлогоор нөлөөлөх, Эрүүгийн хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулах, түүний хэм хэмжээг хууль тогтоогч улс төрийн агуулгаар тайлбарлах зэрэг нь эрүүгийн эрх зүйн тайлбарт сөрөг нөлөөтэй.

### **Системчлэн тайлбарлах аргын давуу болон сул тал**

#### **Давуу тал нь:**

1. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний эрэмбэ дараалал, шатлал, уялдаа холбоог тухайн тогтолцооны мөн чанар, зүй тогтолт шинжээр нь танин мэдэх, нэгэн мөр хэрэглэх явдалд эерэг нааштай нөлөө үзүүлнэ.
2. Эрүүгийн хууль тогтоомж дахь эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөн хийдлийг таньж илрүүлэх, даван туулахад ач холбогдолтой.

#### **Сул тал нь:**

1. Эрүүгийн хуулийн заалт, хэм хэмжээнүүд тодорхой, ойлгомжтой бөгөөд хоорондын нийцэл, уялдаа зохих ёсоор хангагдсан үед

абстракт байдлаар хэт нарийвчлан харьцуулж системт тайлбар хийх нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний бүтэц, стандартын хэвийн байдлыг алдагдуулахад хүргэдэг.

2. Эрүүгийн эрх зүйн онцлог нь хэм хэмжээний нөхцөлүүд маш тодорхой байх, улмаар тэдгээрийг төсөөтэй хэрэглэх боломжгүй байдлаар хуульчлагдсанаас үүдэн эрэмбэ дараалал кодификацчиллыг буруу томъёолох, хэтэрхий хайрцаглагдсан системт хандлагаар тайлбарлах нь эргээд эрүүгийн эрх зүйн хэрэглээний арга, зарчимтай зөрчилдөхөд хүрч болзошгүй юм.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах техникийн буюу тусгай аргууд<sup>75</sup> нь зарим үед хэрэглэгдэх боловч дээр дурдсан түгээмэл аргуудтай уялдсан байдаг. Энэхүү тусгай аргуудад:

1. Хууль зүйн тусгайлсан нэр томъёо хэллэг хэрэглэх;
2. Эрүүгийн хуулийн зорилгод нийцүүлж тайлбарлах;
3. Хориглолт, зөвшөөрлийн нөхцөлүүдийг хязгаарлан тооцох замаар тайлбарлах;
4. Хууль зүйн фикцийн буюу бодитойгоор хийсвэрлэх замаар тайлбарлах;
5. Хууль зүйн фактын хэрэг, тохиолдлын нөхцөлүүдэд тулгуурлан кейсийн аргаар тайлбарлах;
6. Криминализацийн болон декриминализацийн шалгуур нөхцөлүүдээр тайлбарлах;
7. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн буюу хүчингүй болгосон шүүхийн шийдвэрт тулгуурлан тайлбарлах;
8. Эрх зүйн презумпцийн буюу аксиомын аргаар тайлбарлах.

Дээр дурдсан тусгай аргууд нь Монгол Улсад төдийлөн нэвтэрч орж ирээгүйн дээр манай эрүүгийн эрх зүйн хэрэглээний онол практикт хэрэглэгдэж хэвшээгүй байна.

### **2.3. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний тайлбарлах аргуудыг хэрэглэхэд анхаарах асуудал**

Өмнөх хэсгүүдэд Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онолууд болон тайлбарлах тодорхой аргуудыг дэлгэрэнгүй тодорхойлж, жишээ, үндэслэлтэйгээр авч үзсэн билээ. Харин энэ сэдвийн хүрээнд олон улсад болон Монгол Улсын хувьд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахад тулгамдаж буй зангилаа асуудлыг хөндөж, дээр дурдсан тайлбарлах аргуудыг хэрэглэх талаарх зөвлөмж, саналыг тусгасан судалгааны үр дүнг тоймлон дурдах болно. Юуны өмнө зарим хөгжингүй орнууд болон Дэлхийн эрүүгийн загвар хуульд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргыг хэрхэн хэрэглэсэн болон тэдгээрийн жишиг, хандлага ямар байгааг авч үзэх нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйд энэ талаар цаашид анхаарах асуудлыг гаргаж ирэхэд чухал ач холбогдолтой юм.

<sup>75</sup> “Тусгай арга” гэдгийг оросын эрдэмтдийн ихэнх нь системчилсэн аргын тусгай төрөл гэж үзсэн хэвээр байна. (Д.Б.)

Оросын эрх зүйн онолын нэрт эрдэмтэн С.С.Алексеев “эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тусгай арга” гэдгийг анх удаа системтэйгээр боловсруулсан юм. С.С.Алексеев, Общая теория права, Т, с. 304.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах үйл явц Монгол Улсад зогсонги байдалд орсон төдийгүй Улсын Дээд Шүүхээс Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалт, хэм хэмжээг тайлбарлах ажиллагаа туйлын хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна. Яагаад ийм байдалд хүрснийг дүгнэн авч үзэхийн өмнө дэлхий дахинд ямар жишиг, туршлага байдаг хийгээд бид юун дээр анхаарах ёстойг тоймлон дурдах нь зүйтэй.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад Эрүүгийн хуулийн хэм хэмжээ тодорхой бөгөөд нэлээд тохиолдолд тайлбарлаж, тодруулсан байдгаас үүдэн Дээд Шүүхийн зүгээс абстракт байдлаар нэмж тодорхойлсон субъектив тайлбар бараг байдаггүй бөгөөд харин дээд шатны шүүх тодорхой эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэсэн шийдвэртээ Эрүүгийн хуулийг хэрэглэсэн үндэслэлийг хэргийн онцлог, нөхцөлд нийцүүлж тайлбарласан агуулгыг нэлээд дэлгэрүүлж тусгасан байдаг. Түүнчлэн олон жил хуримтлуулсан эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, зарим ойлголт, нэр томъёог жишиглэн тайлбарлах хандлага бий (*Скандинавын орнууд*). “ХБНГУ-ын Дээд Шүүхийн шийдвэр нь объектив хүчин зүйл буюу шүүхийн шатлан захирах тогтолцооны онцлогоос шалтгаалан хэдийгээр албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй ч “... анхан шатны шүүгч урьд дээд шатны шүүх ийм хэргийг хэрхэн шийдвэрлэж байсан бэ? гэдгийг үнэлж дүгнэх шаардлага гардаг. Иймээс энэ утгаараа Германы хувьд энэ нь харгалзан үзэх шинжтэй шүүхийн жишиг<sup>76</sup>...” гэдгийг үгүйсгэх аргагүй. Зарим судлаачид Германы эрүүгийн шүүхийн практикт Дээд Шүүхийн шийдвэрт албан ёсны шинжтэй тайлбарласан хэм хэмжээнүүд тусгагдаж ирснийг шүүхийн прецедентийн хүчин чадлыг агуулсан гэж үздэг ч судлаачдын ихэнх нь үүнийг хүлээн зөвшөөрдөггүй. Учир нь Германы эрүүгийн эрх зүйд шүүхийн прецедент нь эрх зүйн эх сурвалж болдоггүй. Хэдийгээр зарим кейсийн жишээн дээр (*Армин Мэйвсийн хэрэг 2001*) шүүхийн прецедентийн шинжтэй (*харгалзан үзэх прецедент*) шийдвэр гарч байсан ч энэ хандлага нь түгээмэл бус, өөрөөр хэлбэл шүүхийн жишгийн зохицуулалт хязгаарлагдаж ирсэн билээ.

Япон Улсын хувьд Дээд Шүүх нь абстракт байдлаар бие даасан тайлбар гаргахыг хориглодог бөгөөд энэ нь шүүх эрх мэдлийг хэтрүүлсэн гэж үзэхээс гадна зөвхөн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шийдвэрээр дамжуулж, шүүхийн жишгийн агуулга бүхий тайлбарласан хэм хэмжээнүүдийг эрүүгийн эрх зүйн хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлсэн байдаг. Япон Улсын Шүүхийн тухай хуулийн 10.3, 70.1 зэрэг зүйл, хэсгийн заалтаас үзэхэд Японы Дээд Шүүхийн хууль тайлбарласан шийдвэр гаргах буюу өөрчлөхөд 15 буюу Улсын Дээд Шүүхийн нийт гишүүдийн бүрэлдэхүүнтэй их суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэдийгээр Дээд Шүүхийн шийдвэр хуулийн тайлбарыг агуулж буй тохиолдолд энэ нь дараагийн шийдвэртээ ач холбогдолтой хэдий ч доод шатны шүүхүүд Улсын Дээд Шүүхийн тайлбар агуулсан шийдвэрийг үндэслэл бүхий гэж үзэхгүй

<sup>76</sup> Б.Гүнбилэг, Жишгийн эрх зүй, УБ., 2008, 120-р тал.

байгаа тохиолдолд хэрэглэхээс татгалзаж болно. Гэхдээ энэ нь нийтлэг бус онцгой тохиолдолд байж болох ажээ. Доод шатны шүүх Дээд шүүхийн тогтоосон тайлбар жишгээс өөрөөр шийдсэн нь илүү бодитой үндэслэлтэй болсон нь нотлогдож хүлээн зөвшөөрөгдсөн үед Дээд Шүүх өөрийн гаргасан тайлбар, жишгээ эргэж харна. Япон Улсын Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “Дээд шатны шүүхийн шийдвэр нь доод шатны шүүхийн тухайн хэрэгтэй төсөөтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал биелэгдэх хүчин чадалтай эх сурвалж болно” гэж заажээ.

Эстони Улсын хувьд Японтой төстэй боловч хуулийн тайлбар нь абстракт бус, ихэнхдээ эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрт хуулийн зарчим, зорилгод нийцүүлж шууд бус агуулгаар хэрэглээний жишиг тогтооход чиглэгдсэн байдгаараа онцлогтой. Скандинавын орнууд Швед, Дани, Норвеги зэрэг улсад шүүхийн практикт маш их ач холбогдол өгч, ирсний дээр шүүхийн жишиг тайлбарууд нь шүүхийн прецедентийн түвшинд үнэлэгдэж хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Дээд Шүүх нь нэг талаас тодорхой хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэртээ жишиглэсэн буюу тайлбарласан үндэслэл агуулгыг нэлээд өргөжүүлж тусгадаг. Нөгөө талаас эрүүгийн шүүхийн практикийг нэгтгэн дүгнэх замаар зөвлөмж, тайлбар бүхий эх сурвалж, эмхэтгэл гаргахад нэлээд анхаарч иржээ. Гэхдээ аливаа тайлбар, жишиг нь шүүхийн практикт тулгуурласан, хэрэглээний агуулгыг тусгасан шинжтэй байдаг.<sup>77</sup> Баруун Европын эрүүгийн шүүхийн практик, жишгийн хандлагаас үзэхэд Эрүүгийн хуулийн зүйл, заалт зэрэг тодорхой хуульчлагдсан бичвэрийг тайлбарлах явдал нь шүүхийн бие даасан чиг үүрэг биш харин шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд гагцхүү эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг зөв хэрэглэх шаардлагыг хангах зорилгоор зөвхөн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад (*казуаль болон логик системчлэлийн арга зонхилдог*) процедурын нөхцөлөөр хэрэгждэг байна. “Common Law” системийн буюу Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой орнуудад эрүүгийн бичмэл төрөлжсөн хуулийн уламжлал байдаггүй, шүүхийн прецедент, статут хуулийн жишиг, зохицуулалт, өндөр байдгаас үүдэн абстракт, нэр томъёоны болон хэм хэмжээний тайлбар гаргахыг үгүйсгэдэг. Гэхдээ эрүүгийн эрх зүйн институцийн хүрээнд статут тайлбарын техник, нөхцөлүүдийг тусгайлсан стандарт бүхий дүрмээр зохицуулсан байна. АНУ-ын Дээд Шүүх анх удаа Цэвэр утгын дүрмийг 1917 онд “*Caminetti v United States 24z US 470 (1917)*” гэсэн хэрэг дээр гаргасан бөгөөд “...Хуулийг бүрдүүлж буй хэллэг, томъёоллын утга санаа ойлгогдохуйц, салаа утгагүй, хоёрдмол агуулгагүй байх ёстой. Шүүх хуулийн<sup>78</sup> дагуу л хэргийг шийдвэрлэх ёстой. Хуулийн утга бүрэн ойлгомжтой, салаа утгагүй бол шүүхэд тайлбарлах шаардлага гарахгүй...” гэсэн нь бий. Энгийн утгаар буюу шууд оноосон утгаар нь тайлбарлахыг дээрх дүрэмд зөвлөсөн байдаг. Гэхдээ энэ нь шүүмжлэлд өртөх нь цөөнгүй.

<sup>77</sup> И.А.Юрченко, Уголовное право зарубежных стран, М., 2015, с. 23-26.

Р.Н.Дусаев, Эволюция уголовного права Западной Европы и США (часть 1), П., с. 129-130.

<sup>78</sup> АНУ-д хууль гэдэгт статут хуулиас гадна албан ёсны хуулийн хүчин чадалтай шүүхийн прецедентийг хамааруулж ойлгоно. (Д.Б.)

“Golden Rule” буюу “Алтан дүрмийн” стандарт нь “Энгийн болон оноосон утгаар шууд тайлбарлахад тухайн агуулга улам ойлгомжгүй болох үед боломжит салаа буюу нөхцөлт утгыг зэрэгцүүлж тайлбарлах арга хэрэглэдэг. Үгийн салаа буюу нөхцөлт утгыг тодруулахдаа шүүхийн практик хэрэглээний шаардлагад нийцүүлж хязгаарлагдмал хүрээнд тайлбарлах дүрэмтэй...”<sup>79</sup> ажээ.

Дэлхийн эрүүгийн загвар хуулийн стандарт, бүтцийг хууль зүйн техник талаас нь харьцуулж үзвэл, хуулийн хэм хэмжээнүүд маш нарийвчлан дэлгэрэнгүй томъёологдсоноос гадна бүлэг, зүйл тодорхой тайлбартайгаар хуульчлагдсан нь анхаарал татаж байна. Энэхүү загвар хуулийн үзэл баримтлалаас үзэхэд шүүх хуулийг нэмж, өргөжүүлж тайлбарлахыг хориглосноос гадна зөвхөн хэргийг шийдвэрлэх, ойлгомжгүй утгыг нь шүүхийн практик, жишгийн зарчмаар казуаль тайлбар хийх боломжийг дурдсан байдаг.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга, ажиллагааны харьцуулсан судалгааны үр дүнд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн түгээмэл зарим аргуудаас жагсаавал:

1. Эрүүгийн хуулийн текстийг тайлбарлахдаа эхлээд энгийн утгыг тодорхойлох замаар нийтлэг хэрэглээний хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар тайлбарлана.
2. Тухайн хуульд орсон тусгай хэллэг, нэр томъёог нэмж тайлбарлах шаардлагатай бол зөвхөн тухайн нэр томъёоны оноосон утгаар нь хууль зүйн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар тайлбарлана.
3. Хуулийн текстийг тайлбарлахдаа абстракт буюу хэм хэмжээний бус харин казуаль буюу хэрэг, маргааныг шийдвэрлэх нөхцөлөөр фактад тулгуурлан тайлбарлана.
4. Албан ёсны шинжтэй шүүхийн казуаль тайлбар нь хуулийн агуулга, логик хязгаарыг давж болохгүй.
5. Тайлбар буюу тайлбарласан агуулга бүхий шүүхийн шийдвэр нь хууль зүйн шинжлэх ухаанд тогтсон маргаангүй ойлголт, онол, үзэл номлолд тулгуурласан байх ёстой.
6. Тайлбарууд нь Олон улсын эрх зүйн болон Үндсэн хуулийн нийтлэг хэм хэмжээ, суурь зарчмуудтай уялдсан бөгөөд харьцангуй объектив байх ёстой гэх мэт.

Тэгвэл Монгол Улсын Дээд Шүүхээс Эрүүгийн хуулийг тайлбарлахтай холбогдсон эрх зүйн орчин ямар байсан, одоо ямар байгааг эргэн санаж, тоймлон авч үзье.

2002 оны Шүүхийн тухай хууль, 2002 оны Эрүүгийн хууль болон 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталж, 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн Монгол Улсын Шүүхийн тухай хууль зэрэг голлох хууль тогтоомжуудад дээрх асуудал хэрхэн тусгагдсан, яаж хэрэгжсэн нь анхаарал

<sup>79</sup> А.К.Романов, Английн эрхийн тогтолцоо, орчуулагч Т.Доохүү, УБ., 2002, 123-р тал.

татсан асуудал юм. 2002 оноос 2013 он хүртэлх 10 шахам жилийн хугацаанд Улсын Дээд Шүүхээс 28 удаагийн тогтоолоор нийтдээ 340 шахам нэр томьёог тайлбарлажээ.

Судлаач, магистр, хуульч Л.Галбадар өөрийн хийсэн судалгаанд (*магистрын дипломын ажил 2014*) тулгуурлан бичихдээ “...Улсын Дээд Шүүхээс 2002-2013 онд Эрүүгийн хуульд хийсэн тайлбаруудад дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн заалтыг угтуулж авч тайлбарласан, ...хуульд заагаагүй үйлдэл, эс үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцсон, эсхүл хуулийн заалтыг хэт явцууруулан гэмт хэргийн үйлдэл, эс үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцохгүйгээр ял завшуулах боломж бүрдүүлсэн, хоёрдмол салаа утга бүхий гаргалгааг бий болгосон улмаар хууль тогтоогчийн алдааг засдаг, хууль тогтоох эрх мэдэлд халддаг...”<sup>80</sup> тухай тэмдэглэсэн нь үндэслэлтэй бөгөөд үгүйсгэх аргагүй юм. Өөрөөр хэлбэл 2002 оны Эрүүгийн хуульд тодорхой бус байдлаар оновчтой бус томъёологдсон буюу хоёрдмол утгатай заалт, хэм хэмжээ түгээмэл тусгагдсанаас үүдэж Улсын Дээд Шүүх хуульд байхгүй агуулга, зарчмаар тайлбарлаж ирсэн (*абстракт буюу нэр томъёоны тайлбар*) зохисгүй практик хэрэглэгдэж ирснийг судалгааны эх сурвалж бүтээлүүдэд дурдсаар иржээ.<sup>81</sup> 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар хуулийн абстракт тайлбар хийх уламжлалт хандлагыг өөрчилж, жишгийн дагуу казуаль тайлбар хийх боломжийг хуульчилсан байна. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх...” гэж хуульчлан өгчээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 07 тоот тогтоолоор “Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсэгт заасан “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах...” гэсэн заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 07 тоот тогтоолын Үндэслэл хэсэгт: “...Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх заалтын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах Улсын Дээд Шүүхийн бүрэн эрхийг хууль тогтоогч болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад хуульчлахдаа Улсын Дээд Шүүх зөвхөн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргана гэсэн нь анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд хуулийн нэг мөр зөв хэрэглэхтэй холбоотой асуудлаар гарсан саналыг үндэслэн тайлбар гаргах

<sup>80</sup> Л.Галбадар, Эрүүгийн хуулийн тайлбар: Онол, арга зүйн зарим асуудал (*Магистрын дипломын ажил*), УБ, 2014, 56-р тал.

<sup>81</sup> “Эрх зүй” сэтгүүл 2014 №2 (28), 105-106-р тал, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” судалгааны төслийн тайлан, УБ, 2004; Т.Мэндсайхан ахлагчтай судалгааны баг, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэтгэлийн төсөл”. УБ, 2010 г.м.

Улсын Дээд Шүүхийн бүрэн эрхийг явцууруулан хязгаарласан байна...”<sup>82</sup> гэжээ. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт Улсын Дээд Шүүхийн шийдвэр, Улсын Дээд Шүүхийн тайлбар гэсэн ойлголтыг тусад нь томъёолсон гэж дурджээ. Монгол Улсад хуулийн албан ёсны тайлбарыг гаргах ажиллагааны журмыг процессын тусгайлсан хуулиар хуульчлах зайлшгүй шаардлага бий болоод байгаа билээ.

Пост-социалист орнуудад нэлээд түгээмэл хэрэглэгдэж ирсэн абстракт тайлбар нь ихэнхдээ Дээд Шүүх нь өөрийн санаачилгаар болон төрийн болон хууль, шүүхийн байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу уг тайлбарыг УДШ-ийн тогтоол хэлбэрээр гаргаж хэрэгжүүлдэг байна. Зүүн Европын болон эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад эрүүгийн хууль тогтоомжийг тайлбарлах аргад абстракт буюу УДШ өөрийн санаачилгаар тайлбарлах практикийг хориглож, бараг хэрэглэдэггүй. Харин хуулийг нэгэн мөр зөв оновчтой хэрэглэх шаардлагаас үүдэн анхан, давах шатны болон бүх шүүхүүдэд анхаарч харгалзах ёстой ойлголт, нэр томъёо, зарчмуудыг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад болон тухайн шүүхийн практикт тулгуурлан казуаль шинжтэй процедурын тайлбарыг шууд ба шууд бус байдлаар хийж хэвшүүлсэн байх ажээ.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргуудаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарч үзэх ёстой дараах асуудлууд байна. Үүнд:

1. Шүүгч нарын хувьд хэргийг шийдвэрлэхтэй холбоогүй аливаа абстракт нэр томъёоны тайлбар хийхээс аль болох зайлсхийж логикийн болон системчилсэн тайлбар хийх аргыг албан ёсны болон албан ёсны бус хүрээнд оновчтой, бүтээлчээр хэрэглэх явдал бүх шатны шүүгчдийн хууль хэрэглэх ажиллагаанд чухал ач холбогдолтой. Ялангуяа 2002-2013 оны хооронд Улсын Дээд Шүүхээс аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхтэй холбоогүйгээр гол төлөв өөрсдийн санаачилгаар абстракт байдлаар тайлбарласан буюу нэр томъёоны тайлбарууд нь ихэнхдээ субъектив шинжтэй байсныг анхаарч, Эрүүгийн хуулийн хэрэглээний практикт хязгаарлаж, улмаар хэрэглэхгүй байхад анхаарах ёстой. Ялангуяа Эрүүгийн хуулийг хэрэглэх болон түүнтэй харьцах ямар ч тохиолдолд юуны өмнө эрүүгийн шүүхийн практикт голлон тулгуурлахаас гадна хяналтын шатны болон дээд шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийн казуаль тайлбар зэргийг жишиглэн харгалзах ёстойг үгүйсгэх аргагүй юм.
2. Улсын Дээд Шүүхийн хувьд 2012 оноос хойш өнөөг хүртэл Дээд Шүүхийн тогтоолоор хуулийн албан ёсны абстракт тайлбар гаргаагүй боловч зөвлөмж гэсэн нэрээр албан ёсны бус, онолын буюу мэргэжлийн түвшинд тооцогдох тайлбарыг гаргаж байна. 1960 оноос хойш түүхэн уламжлалаас үзэхэд УДШ-ийн гаргасан тайлбаруудыг судлахад 80 гаруй хувь нь Улсын Дээд Шүүх өөрийн санаачилгаар тайлбар гаргасан байна.<sup>83</sup>

<sup>82</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхэтгэл. 5-р боть. УБ., 2017. 356-р тал

<sup>83</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхэтгэл. 5-р боть. УБ., 2007, 353-р тал.



Үндсэн хуулийн цэцэд дээр дурдсан маргааныг хянан шийдвэрлэсэн процессын үйл явцаас үзэхэд Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол болон хяналтын шатны шүүхийн тогтоолын алийг нь албан ёсны тайлбар гэж үзэх нь ойлгомжгүй, тодорхой бус байгаа билээ. Түүнчлэн Улсын Дээд Шүүх хууль тайлбарлахдаа ямар арга хэрэглэх, ямар журам, процедураар хэрэгжүүлэхийг Үндсэн хууль төдийгүй хуулиар зохицуулаагүй орхисон, энэ талаарх эрх зүйн орчин Монгол Улсад бий болоогүйн дээр 2012 оны Шүүхийн тухай хууль батлагдахаас өмнө абстракт байдлаар албан ёсны тайлбарыг УДШ-ийн тогтоолоор гаргаж байсан уламжлал нь цаашид үргэлжлэх боломжгүй болсон билээ. Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт заасан “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэсэн энэхүү үндсэн хуульчилсан заалт нь шүүхийн практик болон эрүүгийн эрх зүйн хэрэглээнд нэвтэрч хэрэгжих боломж нь нээлттэй юм. Зөвхөн хуульчилсан зохицуулалт үгүйлэгдэж байгааг эс тооцвол дээрх заалтыг Улсын Дээд Шүүх хуулиар хориглоогүй буюу хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд Эрүүгийн хуулийг нэг мөр, нэгдсэн байдлаар хэрэглэхэд чиглэгдсэн шүүхийн практикийг жишиглэн тогтоох зорилгоор тодорхой хэргийг шийдсэн нөхцөл, үндэслэлд тулгуурлан тогтоол гарган тайлбарлах боломжтой. Гэхдээ энэ нь өөрийн санаачилгаар бус анхан, давах шатны шүүхүүд болон Эрүүгийн хуулийг хэрэглэх эрх бүхий цагдаа, тагнуул, прокурор, АТГ-ын хүсэлт, саналыг хүлээн авч УДШ-ийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж, шийдвэрлэх замаар гаргах нь зүйтэй болов уу. Абстракт, нэр томъёоны тайлбарлах аргаар бус, харин казуаль буюу хэрэглээний логик, системчилсэн арга зонхилох учиртай. Хяналтын шатны эрүүгийн шүүхийн шийдвэр нь эрүүгийн хэргийг эцэслэн шийдсэн дүгнэлт, шийдэл нь албан ёсны тайлбар биш боловч, түүний үндэслэл болгож буй нөхцөл, агуулгын хэсэг нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг хэрхэн зөв хэрэглэх зарчим, жишгийг тодорхойлж буй утгаараа албан ёсны хийгээд (*онолын*) албан бус тайлбарын аль алиныг нь тусган хослуулсан шинжтэй байдаг. Тэгэхлээр эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг (*албан ёсны шууд бус тайлбар*) казуаль буюу логик, системчлэлийн аргаар хязгаарлалтын болон субъектын онолын зарчмаар тайлбарлах, тэр тусмаа дээрх хандлагаар албан ёсны тайлбар хийх боломж нь Улсын Дээд Шүүхийн тогтоол болон хяналтын шатны шүүхийн тогтоол, шийдвэрийн аль алиных нь хувьд онолын талаасаа бүрэн боломжтой билээ.

3. Хууль тогтоогч буюу Улсын Их Хурал нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхт субъект мөн бөгөөд хууль тогтоогчийн хувьд анхаарах асуудал цөөнгүй бий. Нэн ялангуяа Эрүүгийн хуулийн заалт, үг, үсэг бүхэн маш тодорхой, ойлгомжтой, шууд хэрэглэх боломжтойгоор хуульчлагдсан байх ёстой. Үүний хамт эрүүгийн эрх зүйн мэргэжлийн тусгай нэр томъёо, ойлголт, ухагдахууныг тухайн бүлэг, зүйл хэсэгт нь нэмэлт заалттайгаар

дэлгэрэнгүй тайлбартай байдлаар хуульчлах ёстой. Хэрэв Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодит шаардлага гарвал зарим тохиолдолд зөвхөн нэр томъёоны тайлбарыг дэлгэрүүлж тодорхойлсон нэмэлт, өөрчлөлт оруулж болохыг үгүйсгэх аргагүй. Гадаадын зарим хөгжингүй орны жишгээс үзэхэд “хууль тайлбарлах ажиллагааг процессын хуулиар” тусгайлан хуульчилсан байх бөгөөд энэ талаар ч судалж үзэх шаардлагатай юм.

4. Хууль тогтоогч болон шүүхээс бусад субъектын (*цагдаа, прокурор, тагнуул, АТГ г.м.*) хувьд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг онол, арга зүйн үндэслэлтэйгээр зөв тайлбарлаж хэрэглэхэд онцгой анхаарах шаардлагатай. Ялангуяа Эрүүгийн хуульд байгаа зарим заалтын агуулга салаа утгатай буюу ойлгомжгүй үед хэт субъектив байдлаар, абстракт тайлбар хийх замаар хэрэглэж болохгүй.

Энэ хэсэгт авч үзсэн асуудлыг тоймлон дүгнэвэл эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тодорхой аргуудыг хэрэглэх талаар юуны өмнө энэ талаарх гадаад улс, орнуудын нийтлэг жишиг, түгээмэл чиг хандлагыг судалж, нийтлэг арга зүйг нь мэдэж эзэмших нь маш чухал юм. Улмаар Монгол Улсад хууль тайлбарлах аргыг хэрэглэх тухайд ямар тулгамдсан асуудал бий болоод байгааг бодитойгоор мэдэрч, шалтгаан нөхцөлийг ойлгон цаашдын хандлагыг нь зөв тодорхойлоход анхаарах ёстой. Эцэст нь дээр дурдсанчлан эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргуудын сул ба давуу талыг харьцуулж шүүхийн болон хуулийг хэрэглэх практикт оновчтойгоор сонгож, хэрэгжүүлэх талаар онцгой анхаарч, ажиллах шаардлагатай болж байна.

#### **2.4. Эрүүгийн хууль тайлбарлан хэрэглэх онол, зарчмыг шүүхийн шийдвэр бичихэд хэрэглэх арга зүй<sup>84</sup>**

Шүүхийн шийдвэр бол аливаа хуулийг тайлбарлаж, хэрэглэсний бодит үр дүн төдийгүй хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасныг илтгэх чухал шалгуур мөн. Энэ нь онолын хувьд хуулийн дагуух эрх зүйн шийдлийн акт бөгөөд шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтцээс эхлээд утга, агуулга бүхэн хуульд бүрнээ нийцсэн байхаас гадна хуулийн хэрэглээний үндэслэл, зарчим, арга зүйн шаардлагыг хангасан байх ёстой. Шүүхийн шийдвэрийн нэр хүнд, үр нөлөө нь чухамдаа түүний бичилтийн чанар, үндэслэлтэй, логик уялдаатай, үнэн зөв байхаас шууд шалтгаална. Шүүхийн шийдвэрийн бичилт нь уламжлалт хандлага, хуульд заасан бүтэц, агуулгын шаардлагыг тусгахаас гадна хамгийн гол нь эрх зүйн болон онол, арга зүйн үндэслэл сайтай маргаангүй бөгөөд маш ойлгомжтойгоор илэрхийлэгдсэн байх нь нэн чухал юм.<sup>85</sup> Монгол Улсад 2015 оноос эхлэн “Монгол Улсын Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл”-ийг жил тутамд гаргаж эхэлсэн бөгөөд эдүгээ 3 боть бүхий эмхэтгэлийг гаргаж, шүүхийн практикт төдийгүй хууль зүйн сургалт, судалгааны болон

<sup>84</sup> Энэ хэсэгт Эрүүгийн хууль тайлбарлан хэрэглэх арга, арга зүйг биш харин тухайн тайлбарын онол, зарчмыг шүүхийн шийдвэр бичих, гаргах асуудалтай холбон авч үзэх болно.

<sup>85</sup> Судебное правоприменение: Проблемы теории и практики (*под ред. В.М.Сырых*), М., 2007; Л.В.Соцуро, К вопросу об обстоятельствах, имеющих значение для дела, М., 2005.

хуулийн хэрэглээнд судлах, хэрэглэх боломж, нөхцөлийг хангасан нь чухал ач холбогдолтой юм. Дээрх эмхэтгэлийн 1 дүгээр ботийн өмнөтгөлд бичихдээ “...Үйл баримтыг эрх зүйн эх сурвалжтай, бүрэн зөв тулган шалгаж, эрх зүйн дүн шинжилгээ хийсэн, эрх зүйн онол, Үндсэн хуулийн болон эрх зүйн нийтлэг зарчимд тулгуурлан тайлбарлаж хэрэглэсэн, шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй, тодорхой ойлгомжтой, хууль зүйн техникийн шаардлагыг хангаж бичсэн зэрэг шалгуур...”<sup>86</sup>-аар шүүхийн шилдэг сонгомол шийдвэрүүдийг шалгаруулсан тухай дурдсан байдаг.

Дээрх шалгуур нь өнөөгийн Монгол Улсын шүүхийн практикт зайлшгүй анхаарч харгалзах ёстой наад захын стандарт, шаардлага мөн билээ.

Шүүхийн шийдвэр нь эрх зүйн хэрэглээний акт төдийгүй процессын баримт бичиг юм. Энэ нь хуулиар тогтоосон процессын хэлбэрээр гаргасан эрх зүйн акт мөнөөс гадна хэргийг агуулгаар нь хянан шийдвэрлэсний үр дүнд зөвхөн шүүн таслах байгууллагаас гардгаараа онцлогтой.

Хууль зүйн техникийн стандартыг нийтлэг шалгуураар<sup>87</sup> авч үзвэл:

- а) Хууль ёсны байх;
- б) Үндэслэлтэй байх;
- в) Сэдэлттэй байх;
- г) Шударга ёсны байх;
- д) Бүрэн байх;
- е) Эцсийн бөгөөд шууд биелэгдэх агуулгатай байх г.м.

Шүүхийн шийдвэр нь юуны өмнө хуульд заасан шаардлага, нөхцөлийг заавал хангасан байх ёстой. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 36.2.3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэжээ. Энэхүү тодорхой, ойлгомжтой байх агуулга нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг хэрхэн зөв тайлбарлахтай салшгүй холбоотой. Тайлбарлах онол, зарчмын хувьд манай шүүхийн практикт гол төлөв абстракт хэл зүйн болон абсолют онолын хандлага нэлээд түгээмэл хэрэглэгдсэн байдаг.

Шүүхийн шийтгэх тогтоолуудад Эрүүгийн хуулийн заалт, нөхцөл, журмыг ишлэл татан, товч тусгадаг хэдий ч шүүхийн шийдвэрүүдэд хийсэн судалгаанаас үзэхэд гол төлөв нотлох баримтуудыг үндэслэл хэсэгтээ дэлгэрэнгүй дурддаг, харин эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, зарчим, арга зүйг бараг тусгаж илэрхийлэхгүй гаргаж ирсэн нь анзаарагдаж байна. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах сонгодог арга зүйн онол буюу Савигнигийн дөрвөн аргачлалын зарчмаар шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг дэлгэрүүлж тайлбарлах явдал тун хангалтгүй байна.

<sup>86</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл (1-р боть), УБ., 2015 (Н.Лүндэндорж. Өмнөтгөл), 3-р тал.

<sup>87</sup> Т.В.Кашанина, дурдсан эх сурвалж, 401-408-р тал. Эрх зүйн онолд шүүхийн шийдвэр бүхэн хууль зүйн техникийн нийтлэг жишгийн стандартыг заавал хангасан байх ёстой гэж үздэг. (Д.Б.)

2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж ирсэн шүүхийн практикаас үзэхэд давтан гэмт хэрэг, ялтанд тооцох болон хууль ёсны ба гэм буруугийн зарчим зэрэг институт нөхцөлийг хэрэглэхэд абсолют буюу туйлын онолын хандлага түгээмэл илэрч байв. Тухайн үед Эрүүгийн хуулийг эрүүгийн эрх зүйн онол, арга зүйн зарчимд нийцүүлж, жишгийн дагуу тайлбарлаж хэрэглэх практик бий болоогүй байсан гэж үзэхэд хэтрүүлэг болохгүй болов уу? 2002-2017 оны хоорондох 15 жилийн хугацаанд анхан шатны эрүүгийн шүүхийн тогтоол шийдвэрийн 45-аас доошгүй хувь нь хүчингүй болох буюу өөрчлөгдөж ирсэн нь ихэнхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэнтэй холбоотой шалтгаан нөхцөл эзэлдэг нь ч анхаарал татдаг. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилсэн Эрүүгийн хуулийг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж, шүүхийн шийдвэрт хэрхэн тусган гаргаж байгааг анхаарах асуудал болгон зарим шүүхийн шийдвэрүүд дээр тухайлан авч үзье.

Эрүүгийн хэргийн анхан шатны шийтгэх тогтоолуудад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд тэдгээр шийдвэрийн зарим нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан (ЭХ-1.2-1.9) суурь зарчмуудыг тухайн хэрэгт холбогдуулж, хэрэглээгүй, гэмт хэргийн зүйлчлэлд алдаа гаргаж, буруу тайлбарласан, онол, логикийн болон системчилсэн тайлбар хийх арга зүйг хэрэглээгүй, нотолгооны эх сурвалж, баримт сэлтүүдийг дурдсан нь хоорондоо уялдаагүй, тухайн шийдвэрийн тодорхойлох хэсэг нь эрх зүйн хэм хэмжээний үндэслэлийг тайлбарлаж тусгаагүй тогтоох хэсгийн дүгнэлт, шийдлүүд нь тодорхойлох хэсгийн агуулгатайгаа бүрэн уялдаагүй зэрэг зохисгүй хандлага түгээмэл ажиглагдаж байна.<sup>88</sup>

<sup>88</sup> **Жишээ 1:** ... Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн №00302 тоот шүүхийн шийтгэх тогтоол: Энэ шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 11.1.2.4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн 11.2 дугаар зүйлийн 1 болгон өөрчилж, тэдгээр хэм хэмжээг тайлбарлан хэрэглэхдээ онол, арга зүйн алдаа гаргаснаас гадна Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар 5.3.1 дэх хэсэгт заасан “Хүний биед халдаж зодох” зөрчлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэргээс ялган, зөв тайлбарлаж чадаагүй, зарим нөхцөлд ял завших нөхцөлийг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн. “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэрэгт прокуророос яллах дүгнэлт үйлдэж, илүүлсэн нь бүхий л талаар үндэслэлтэй байхад “Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг болгон өөрчилсөн ажээ. (Д.Б) Зөвхөн нотлох баримт, нотолгооны эх сурвалж, баримт сэлтийг хагас дутуу дурдаж, Эрүүгийн Хууль, ЭХХШтХ зэргийг иш татсан төдийгөөр шүүхийн шийдвэрийн тодорхойлон үндэслэх хэсгийн агуулгыг илэрхийлэх нь нэн хангалтгүй юм. Энэ шийдвэрт эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх ямар нэгэн тодорхой үйлдэл, гүйцэтгэл хийгээгүй ажээ. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) шүүхийн шийдвэрийн сан.

**Жишээ 2:** Сум дундын шүүхийн 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн №38А тоот шүүхийн шийтгэл тогтоол (эх сурвалж: “Эрх зүйн сэтгүүл 2016 №4. 196-201-р тал). Энэ шийдвэрт хэдийгээр 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуучин хуулийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсэгт заасан “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” гэмт хэргийн зүйлчлэлийг буруу тайлбарласнаас гадна “Гэмт хэрэг” ба “Зөрчил” гэсэн ойлголтын ялгааг бүрхэгдүүлж, Эрүүгийн хуульд байгаа нэршлээр нь бус, хуульд байхгүй томъёоллоор “...Зөрчил гаргасан нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангасан тухай ямар ч логик үндэслэлгүй, найруулга зүйн алдаатайгаар шүүхийн шийдвэр бичигдсэн байна. Түүнчлэн тухайн үеийн Эрүүгийн хуулийн 56.1 дүгээр зүйл, 78 дугаар зүйл зэрэг тухайн хэрэгт шууд хамааралтай хэм хэмжээг тайлбарлаж хэрэглээгүй орхигдуулсан. Энэ шийдвэрээс анхаарах ёстой нэг сургамж бол хуульд заасан нэр томъёог хууль ёсны зарчмын агуулгаар нь хэрэглэх, хэт ялгах баримтыг туйлшруулж үнэлэхгүй байх, шүүхийн шийдвэрийн агуулга нь нотолгооны төдийгүй эрх зүйн үндэслэлтэйгээ уялдан байхад оршино. (Д.Б)

**Жишээ 3:** ... Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн

Эрүүгийн хуулийг хэрэглэж байгаа шүүхийн практик нь эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гүн гүнзгий тусгалаа олсон байх ёстой.

“Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн санд (“[shuukh.mn](http://shuukh.mn)”) албан ёсоор байршуулсан эрүүгийн хэргийн шүүхийн тогтоол, шийдвэрүүдээс 80 шахам тогтоол, шийдвэрийг сонгон авч, дүн шинжилгээ хийж, уншин судалж үзэхэд ихэнхэд нь (65 хувь) эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, зарчмыг жишгийн агуулгаар нь гүнзгийрүүлж, тайлбарласан үндэслэлийг тусгаагүй, гол төлөв нотолгооны үндэслэлүүд нь тодорхойлох хэсгийн агуулгыг бүрдүүлсэн болох нь харагдаж байна. Эрүүгийн хэргийн практикт түгээмэл хэрэглэгддэг Эрүүгийн хуулийн 10.1, 10.2, 10.6, 11.1, 11.2, 11.3, 11.4, 11.5, 11.6, 11.7, 12.1, 17.1, 17.2, 17.3, 17.12, 22.1, 27.10 зэрэг зүйл, ангиар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн 20 шахам хэргийг шийдсэн шүүхийн тогтоол, шийдвэрүүд нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг Эрүүгийн хуульд нийцүүлж тайлбарлаж хэрэглэсний үр дүнг зохих хэмжээнд тусгасан байх боловч, өмнөх Эрүүгийн хууль үйлчилж байсан үеийн эрүүгийн эрх зүйн сэтгэлгээ, онолын уламжлалт хандлага хэвээр хадгалагдсаар байгаа нь анзаарагдаж байна. Зарим хэргийн хувьд 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад 2015 оны Эрүүгийн хуульд ялын бодлого нь зөөлөрсөн нөхцөл байдлыг шүүхийн шийдвэрт тусгахдаа хууль ёсны зарчмаас гадна шударга ёсны болон гэм буруугийн зарчмыг заавал харгалзаж, хуулийн зорилго, зарчмын хүрээнд бүх талаас нь судалж хандах ёстой билээ.

Зарим тохиолдолд бүлэглэсэн буюу хэд хэдэн этгээд хүчингийн хэргийг үйлдсэн буюу үйлдэхээр завдсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн хэм хэмжээг Эрүүгийн хуулийн 3.7, 6.5, 6.6, 2.3 зэрэг зүйл, хэсэг болон 1.3, 1.2, 1.4 дэх хэсэгт заасан зарчмууд зэрэг олон талт, бүхий л хамааралт хэм хэмжээг хоорондын уялдаа, хамаарал, утгын холбогдол талаас нь дүгнэн шинжилж, дэлгэрэнгүй тайлбарлах замаар шүүхийн шийдвэрт бичилт хийх нь зүйтэй юм. Гэтэл эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зарим шийтгэх тогтоолоос үзэхэд хэд хэдэн хүн хүчингийн хэргийн гүйцэтгэгч ба хамжигчаар холбогдсон бөгөөд бүлэглэж үйлдсэн, сэтгэл санааны шаналал зовиур үүсгэж, тохуурхан доромжилж үйлдсэн, биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн зэрэг хүндрүүлэх нөхцөл байдлууд илт байсаар атал,

№724 тоот шүүхийн шийтгэх тогтоол. (эх сурвалж: [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)) Энэ шийдвэрт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 2.2.3, 2.2.4 болон 6.8 дугаар зүйлийн 6.8.1 дэх хэсэгт заасан хэм хэмжээг буруу тайлбарлаж, буруу хэрэглэсэн, нотолгооны эх сурвалжаар тогтоосон гэмт хэргийн шинж, шалгуурыг эрүүгийн эрх зүйн зарчим, хэм хэмжээний логик болон зорилгод нийцүүлж тайлбарлах аргыг хэрэглээгүй зэрэг алдаа гарчээ. Тухайлбал анхан шатны шүүх шүүгдэгч Т.Э-нь ... хэд хэдэн удаа хулгайлсан үйлдлүүдийг нэг гэмт хэрэг гэж үзэж ял оноосон нь үндэслэлгүй бөгөөд цаг хугацаа, объект, орон зай нь өөр өөр нөхцөлд дараалсан байдлаар хийсэн хулгайн үйлдлүүдийг хулгайн нэг гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин тус тусдаа бие даасан бүрэлдэхүүн бүхий хэд хэдэн гэмт хэрэг гэж тооцогдох бөгөөд Эрүүгийн хуулийн 6.8-р зүйлийн 6.8.1-д “...гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж, нэгтгэн нийт эдлэх ялын төрөл хэмжээг хуульчилсан. Энэ шийдвэрээс анхаарах зүйл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ба тусгай ангийн хоорондын уялдаа, хамаарлын логик зүй тогтлыг зөв таньж, ухаалгаар зөв тайлбарлаж хэрэглэх учиртай билээ. Энэхүү шийдвэрийг 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 101 тоот тогтоолоор хүчингүй болгож, анхан шатны шүүхэд нь буцаажээ. (Д.Б)

тэр бүхнийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгаагүй, тухайн хүчингийн хэргийн орчин, нөхцөл байдлыг уг хэргийн объектив, субъектив шинжтэй холбон тайлбарлаагүй, өнгөц хандаж хэт хөнгөн ял оногдуулсан тохиолдол ч гарсаар байгааг үгүйсгэх аргагүй. (“...Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 159 тоот шийтгэх тогтоол...” [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)). 2015 оны Эрүүгийн хуулийн зарим тодорхой бус заалт, тодорхой бус утга санааг шүүхийн шийдвэрт тодорхой тайлбартайгаар тусгаж хэрэглэх хандлага бий болж байгаа нь сайшаалтай. Ялангуяа 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 2018 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг судалж үзэхэд нэлээд тохиолдолд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг казуаль аргаар тухайн хэргийн фактад холбогдуулж тайлбарлах, логикийн болон системчилсэн тайлбар хийсэн үндэслэлийг тухайн шатны шүүхийн шийдвэрүүдэд тусган оруулах практик бий болж байна. Жишээ нь: Монгол Улсад Дээд Шүүхийн 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдааны 101 тоот тогтоолын тодорхойлох хэсэгт: ...2002 оны Эрүүгийн хуульд нэг зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй тус тусдаа үйлдлүүдийг хохирлоор нь нэмж, нэгтгэн нэг зүйлчлэлд ял оногдуулдаг байсан зарчмыг 2015 оны Эрүүгийн хуулиар халсан болно. ...Нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангах тухай ойлголт нь аль нэг үйлдэл, эс үйлдэхүй бие дааж тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангахгүй, эсвэл өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнд тохирч харин тэдгээрийг хамтатгаснаар тодорхой гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн бий болж байх тохиолдолд хамааралтай нэг гэмт хэргийн шинж юм. ...Хэрэв тус тусдаа үйлдэл, эс үйлдэхүй нь өөр өөр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангаж байгаа боловч эцсийн дүнгээрээ нийлж өөр гэмт хэрэг болж байгаа бол сүүлчийн гэмт хэргийн шинжийг үндэслэн зүйлчилнэ” гэж дурджээ.<sup>89</sup>Түүнчлэн Архангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 14 тоот магадлалын тодорхойлох хэсэгт: “...Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа илэрсэн хэрэгт оногдуулсан ялыг өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялтай хэрхэн нэмж нэгтгэх талаар хуулийн зохицуулалтгүй, энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1.3.5 дахь хэсэгт заасан нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах зарчмыг баримтлан, мөн хуулийн 1.15 дугаар зүйлийн 1.5.2 дахь хэсэгт зааснаар “яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх...” гэсэн үндэслэлийг оруулсан байна. Энэ магадлалаар ...Сум дундын шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 113 дугаар шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаажээ. Энэ мэт жишээ цөөнгүй байна.

Дээр дурдсан хандлага нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг нийтэд ойлгомжтой болгохоор албан ёсны тайлбар хийж буй явдал биш, харин Эрүүгийн хуулийн нэг мөр хэрэглэх практикийг тогтооход ач холбогдол бүхий алхам юм.

<sup>89</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан. Жич: Дээрх албан ёсны веб сайтад байршсан эрүүгийн хэргийн шүүхийн давж заалдах ба хяналтын шатны шүүхийн магадлал, тогтоолуудад эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж хэрэглэсэн үндэслэл зарчмууд нь казуаль тайлбарын болон логик аргаар шинжлэн дүгнэх хандлага давамгайлж байна.

Энэ хэсэгт авч үзсэн судалгааны дүн болон тухайлан тэмдэглэгдсэн зүйлүүдэд онцгой анхаарч шүүхийн шийдвэр боловсруулах болон гаргах ажиллагаанд харгалзан хэрэглэх нь зүйтэй юм.

Дурдсан зүйлүүдийг тоймлон дүгнэж, энэ сэдвийн хүрээнд шүүгч нарын хувьд шүүхийн шийдвэр бичилтэд арга зүйн талаас нь анхаарч үзэх шаардлагатай дараах зарим асуудал байна. Үүнд:

1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгийг а) Нотолгооны үндэслэл, б) Эрх зүйн үндэслэл гэсэн хоёр үндсэн агуулгаар бүрдүүлж байх жишгийг тогтоон мөрдүүлэх;
2. Өнөөгийн эрүүгийн шүүхийн шийдвэр гаргалт, бичилтийн практик хандлагаас үзэхэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлийг нэрлэн тэмдэглэж, зөвхөн нотолгооны үндэслэл, нотлох баримтын хамааралт байдлыг илүү тодорхойлж тусгах явдал давамгайлж байгаа тул Эрүүгийн хуулийн шууд ба хамаарах байдлаар холбогдох бүхий л хэм хэмжээний эрх зүйн үндэслэлийг дэлгэрүүлж, хоорондын уялдаа, холбоонд тайлбарлах замаар тухайн шийдвэрт тусгаж байх;
3. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн жишиг загвар, бүтэц, маягтыг хөгжингүй орнуудын эрүүгийн хэргийн шилдэг шийдвэрийг харьцуулж судлах замаар шинэчлэн боловсруулж, Монголын онцлогт нийцүүлж гаргах нь онцгой ач холбогдолтой;
4. Эрүүгийн хуулийн зарим ойлгомжгүй, тодорхой бус заалтыг хэрхэн ойлгож хэрэглэх тухай саналыг анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдсэн хэрэг шүүхийн практиктай холбон үндэслэл бүхий танилцуулгатайгаар Улсын Дээд Шүүхэд гаргах, нөхцөл, журмыг оновчтой тодорхой болгох;
5. Эрүүгийн хэргийг шийдсэн аливаа шүүхийн шийдвэр нь хууль ёсны болон үндэслэлтэй байх шаардлагаас гадна “казуаль тайлбар бүхий фактад дүн шинжилгээ хийсэн агуулгыг заавал тусгаж байх шалгуурыг бий болгож, шүүхийн практикт нэвтрүүлэх;
6. Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрт эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг оновчтойгоор тайлбарлан түүний үндэслэлээ онол, практикийн талаас нь зохистойгоор илэрхийлж чадсан тохиолдолд тэдгээр шийдвэрийн агуулга, жишгийг анхан шатны шүүхийн шийдвэр гаргахад анхаарч харгалзаж байх журмыг бий болгох;
7. Шүүхийн шийдвэрийг хамгийн үндэслэлтэй шинэлэг агуулгаар, дэлхий нийтийн жишгийн шаардлагад нийцүүлж гаргасан нөхцөлд тэдгээрийг сурталчлах, сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах;
8. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэсэн үндэслэлийг нотолгоо, практикийн төдийгүй эрх зүйн онол, арга зүйн агуулгаар баяжуулж, казуаль агуулгаар дэлгэрүүлж тайлбарлах сэтгэлгээ, хандлагыг бий болгох г.м.





**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД**  
**ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН**  
**ХЭРЭГЛЭХ ОНЦЛОГ**

## БҮЛЭГ 3. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ ОНЦЛОГ

### 3.1. Эрүүгийн эрх зүйн онцлог шинж, зорилго

Эрүүгийн эрх зүй нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго, чиг үүрэг бүхий бие даасан салбар эрх зүй мөн. Хураангуйлж илэрхийлбэл, эрүүгийн эрх зүй нь хүний эрхийн үнэт зүйлсийг (*эрх чөлөө, нэр төр, тэгш эрх, шударга ёс, хууль ёс*) гэмт халдлагаас хамгаалахад чиглэгдсэн нийтийн эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг. “**Эрүүгийн эрх зүй**” гэдэг ойлголтыг дэлхий дахинд эрх зүйн тогтолцооны уламжлал, мөн чанарын онцлогоос хамаарч харилцан адилгүй утгаар ойлгож иржээ.<sup>90</sup> “Эрүүгийн эрх зүй бол хууль зөрчсөн ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох, ямар гэмт хэрэгт ямар ял оногдуулах болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад чиглэгдсэн хэм хэмжээний нийлбэр цогц төдийгүй эрүүгийн хууль тогтоомжоор журамлан хамгаалсан эрх зүйн үйлчлэл нөлөөллийн систем юм. Энэ салбар эрх зүй нь материаллаг эрх зүйн ангилалд хамаарагдах боловч зарим хөгжингүй орнууд, тэр тусмаа Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой оронд эрүүгийн эрх зүйн салбар, хүрээнд эрүүгийн материаллаг эрх зүй, (*Substantive Criminal Law*) эрүүгийн процессын эрх зүйн (*Criminal procedure law*) аль алиныг нь хамруулж багтаасан байдаг. Германы эрүүгийн эрх зүйн профессор, доктор Э.Хильгендорф бичихдээ: “...Эрүүгийн эрх зүй нь өргөн утгаараа материаллаг эрүүгийн эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйг бүхэлд нь хамардаг...”<sup>91</sup> гэж тэмдэглэсэн нь бий.

Монгол Улсын хувьд эрүүгийн эрх зүй нь саяхан болтол нийтийн эрх ашгийг (*нийгэм, улсын ашиг сонирхол*) хамгаалахад гол зорилго нь чиглэгдэж, харин хувийн эрх ашиг, тэр тусмаа хүний хувийн амьдрал, гэр бүл, ёс суртахуун, ахуйн хүрээн дэх гэмт халдлага эрүүгийн эрх зүйн хамгаалалтын гадна байсан гэхэд хилсдэхгүй. Энэ хандлага социалист тогтолцооны болон шилжилтийн үеийн түүхэнд илүү тод илэрч хэрэгжиж байв.<sup>92</sup>

Өнөөгийн үеийн нөхцөлд эрүүгийн эрх зүй нь хувь хүн, гэр бүл, төр, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, аюулгүй байдлын баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаагийн дээр нийгмийн хамгаалах чиг үүргийг голлон хэрэгжүүлэгчийн хувьд орчин үед тулгуур суурь эрх зүйн хэмжээнд

<sup>90</sup> “Эрүүгийн эрх зүй” – Англиар “*Criminal Law*”, Оросоор “*Уголовное право*”, Германаар “*Strafrecht*”, Францаар “*Droit penal*” гэж нэрийдэх бөгөөд “ялын эрх зүй”, “гэмт хэргийн эрх зүй” гэсэн утгаар нэрлэгддэг. Гэхдээ ялын онол, бодлого, тэдгээрийн үзэл баримтлалд илүү тулгуурласан бол “*ялын эрүүгийн эрх зүй*”, гэмт хэрэг зүйлчлэлийн онол, үзэл баримтлалыг голлон тухайн тогтолцоог бүрдүүлсэн бол “гэмт хэргийн эрүүгийн эрх зүй” гэсэн агуулга давамгайлдаг. Монгол хэлний нэршлийн хувьд “Эрүүгийн эрх” (1964-1978), “Эрүүгийн эрх зүй” (1978 оноос хойш) гэж нэрлэгдсээр ирсэн. (Д.Б)

<sup>91</sup> Э.Хилгендорф, Д.Чимэддулам, Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Удиртгал, УБ., 2015, 15-р тал.

<sup>92</sup> Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), УБ., 2011, 105-113-р тал.

үнэлэгдэх болсон билээ.

Эрүүгийн эрх зүй нь өөрийн хамгаалах зүйл, зохицуулалтын арга, тогтолцооны хувьд бие даасан онцлог шинжүүдтэй. Эдгээр гол онцлогийг нь дурдвал:

1. Бусад салбар эрх зүйтэй харьцуулахад эрүүгийн эрх зүй нь тодорхой төрлийн харилцааг шууд зохицуулдаггүй, харин хуульчлагдсан харилцааг нь гэмт халдлагаас хамгаалдаг;
2. Эрх зүйн хамгаалах чиг үүргээ императив аргаар буюу хориглолт-хязгаарлалтын хэлбэр, механизмаар дамжуулж хэрэгжүүлдэг;
3. Иргэний эрх зүйтэй харьцуулахад Эрүүгийн хуулийн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэхийг хориглодог;
4. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүдийг хууль ёсны зарчмын агуулгад яв цав нийцүүлж, заалт, нөхцөл, журмууд нь маш тодорхой буюу шууд хэрэгжих нөхцөлөөр (“*Lex certa*”) хуульчлагдсан байдаг;
5. Эрүүгийн эрх зүйн онцгой санкц буюу ялыг гагцхүү шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдсэн шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулна;
6. Эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдсон этгээдэд шүүхийн тогтоолоор ял оноох, шийтгэх, цээрлүүлэх чиг үүргээс илүү гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, ялтныг засан төлөвшүүлэх зорилго агуулдаг;
7. Эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж нь зөвхөн эрүүгийн хууль зонхилсон байх онцлогтой ба хуульчилсан акт эрүүгийн эрх зүйн эх сурвалж болохгүй;
8. Эрүүгийн эрх зүй нь нийгмийн шударга ёс, эрх зүйн тогтолцоог бүхэлд нь хамгаалахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ г.м.

Эрүүгийн эрх зүйн зорилго нь тухайн эрх зүй чухам юунд чиглэгдэж байгааг илэрхийлнэ. Эрүүгийн эрх зүйн зорилго нь Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийн зорилготой уялдсан байх боловч харьцангуй өргөн хүрээтэй ойлголт юм. “...Эрүүгийн эрх зүйн зорилго нь Үндсэн хуулиар баталгаажуулсан нийтийн болон хувь хүний эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах...”<sup>93</sup> явдал юм. Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1.1.1 дэх хэсэгт: “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.” гэж заасан билээ.

“Үндсэн хуулиар баталгаажуулсан...” гэдэг нь өргөн утгаараа Үндсэн хуульд бичигдсэн буюу үндсэн хуульчилсан бүхий л зарчим, хэм хэмжээний зайлшгүй биелэгдэх нөхцөл, боломж тэдгээрийн бататган хангагдсан байдлууд юм. Эрүүгийн эрх зүйн зорилгыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар авч үзвэл:

<sup>93</sup> Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги (лекц), УБ., 2018, 16-р тал.

**Нэгдүгээрт:** Үндсэн хууль болон Олон улсын соёрхон баталсан гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, үндэсний болон нийтийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах;

**Хоёрдугаарт:** Хуулиар хориглоогүй буюу хуулиар зөвшөөрч бататгасан нийтийн болон хувийн эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах;

**Гуравдугаарт:** Үндсэн хуулиар бататгасан төр нийгмийн тогтолцоог, гэмт халдлагаас хамгаалах;

**Дөрөвдүгээрт:** Хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах г.м.

“Гэмт халдлагаас хамгаалах” гэдэг нь Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн төрийн албадлага нөлөөллийн систем юм. Энэ нь Эрүүгийн хуулийг хэрэглэх онцгой ажиллагаа төдийгүй эрүүгийн эрх зүй чухам ямар агуулга, мөн чанарыг илэрхийлэх ёстойг харуулна. Дэлхийн улс орнуудын ихэнх нь эрүүгийн эрх зүйд хамгаалах чиглэл давамгайлсан (90 хувь) зорилт, зорилгыг дэвшүүлж тодорхойлсон байдаг. Эрүүгийн эрх зүйн зорилго нь ерөнхий ба тусгайлсан хамгаалалтын чиг үүрэг, агуулгыг тодорхойлох бөгөөд улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид<sup>94</sup> тусгагдсан нийт чиг хандлагаас үзвэл нийгмийг аливаа халдлагаас хамгаалах, дэг журмыг сахиулах, хүний эрх, өмчийн болон экологи үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байдаг. Сүүлийн жилүүдэд орчин үеийн эрүүгийн эрх зүй улам бүр шинэчлэгдэн хөгжиж, түүний зорилго, чиг үүрэг нь өргөжиж, улс орны нийгмийн төдийгүй олон улсын аюулгүй байдлыг хангахад чухал түлхэц үзүүлэх болжээ. Эрүүгийн эрх зүй дэх хэм хэмжээний субъектив хандлага гүнзгийрч хөгжихийн зэрэгцээ түүний процедурын агуулга улам тод илэрч, тэдгээрийн уялдаа хамаарал нэмэгдсээр байна.

### 3.2. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал

Монгол Улсад эрүүгийн эрх зүйн шинэчлэлт, өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаагийн нэг илрэл нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм. Ялангуяа 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь өмнөх Эрүүгийн хуультай харьцуулахад ялын бодлого, тогтолцоо харьцангуй хүмүүнлэг болсноос гадна гэмт хэргийн зүйлчлэл, бүрэлдэхүүний шинжийг орчин үеийн хандлага, арга зүйгээр авч үзэх шаардлагыг зохих хэмжээнд тусгаснаараа онцлог юм.

<sup>94</sup> Баруун Европын болон хөгжингүй орнуудын зонхилох хэсэг нь эрүүгийн эрх зүйн зорилгыг эрүүгийн хууль тогтоомжид тусган тодорхойлдоггүй, зөвхөн төрийн бодлого, үзэл номлол, шинжлэх ухааны бүтээлүүдэд томьёолж тодорхойлж иржээ. Харин Болгар, Турк, Румын, Орос, Польш, Чех, Монгол, Хятад, Вьетнам, Перу, Куба, Босни, Колумб зэрэг 34 орны Эрүүгийн хуульд эрүүгийн эрх зүйн зорилтыг тодорхойлж хуульчилсан байна. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2011, 67-р тал.

Эрүүгийн эрх зүй судлаач, доктор, профессор Ж.Эрдэнэбулган бичихдээ: “... Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд өмнөх гэмт хэргийн хууль зүйн үр дагавар нь арилаагүй байхад дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрх зүйн байдал нь шууд хүндэрч зүйлчлэгддэг байсныг өөрчилж, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох, давтан үйлдэл, ялтай байдал зэрэг ойлголтыг тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцохгүй болсон нь маш том дэвшил болсон бөгөөд энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1.3.5дахь хэсэгт заасан “Нэг гэмт хэрэгт нэг удаа л ял оногдуулна” гэсэн агуулгад нийцсэн гэж үзнэ...”<sup>95</sup> гэжээ.

2015 оны Эрүүгийн хуулиар цаазаар авах ял, албадан ажил хийлгэх ял, эд хөрөнгө хураах ялыг халж, хорих ялын хугацааны доод хэмжээг багасгаснаас гадна хорих ялын доод, дээд хугацааны хоорондын зайг ихэсгэсэн, ижил төст буюу бланкет диспозици бүхий гэмт хэргүүдийн давхардал болон төсөөтэй хэрэглэх боломжийг зогсоож, хязгаарласан зэрэг томоохон өөрчлөлт хийгджээ. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, бэлгийн мөлжлөг, ялгаварлан гадуурхах, мал хулгайлах, хууль бусаар нийгмийн халамж үйлчилгээ авах, зах зээл дэх монополь давамгайл байдлаа ашиглах, цахим мэдээлэлд хууль бусаар халдах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэх мэт 30 шахам гэмт үйлдлүүдийг шинээр гэмт хэрэгт тооцсон ба анх удаа хуулийн этгээдийн үйлдсэн 28 төрлийн гэмт хэргийг шинээр зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгов.

Үүний зэрэгцээ урьд нь гэмт хэрэгт тооцож байсан гүтгэх, доромжлох, хүнийг болгоомжгүйгээр алах, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, танхайрах зэрэг цөөнгүй гэмт хэргийг Эрүүгийн хуулиас хасч, тэдгээрийн заримыг зөрчилд тооцон Зөрчлийн тухай хуулиар зохицуулах болсон бол заримыг нь адил төст гэмт хэрэгт нэгтгэх буюу нэршил, томъёоллыг нь өөрчлөн Эрүүгийн хуульд шинэчлэн зүйлчилсэн байдаг. Өмнө нь гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэмт хэргийн шинж гэж хоёр янзаар хуульд хэрэглэж ирсэн ойлголтыг “гэмт хэргийн шинж” гэж нэгтгэн томъёолж, Эрүүгийн хуульд оруулсан.

Өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 ангилан зүйлчилж ирснийг 2015 оны Эрүүгийн хуулиар өөрчилж, (ЭХ 2.6) тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг, харин хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош жил оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэсэн хоёр ангиллыг бий болгосон.

Ялын төрөлд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах гэсэн хоёр шинэ ялыг нэмж хуульчилсны дээр торгох ялыг торгуулийн нэгжээр тооцож оногдуулах шинэ журам бий болгов. Мөн хорих ялыг хугацаатай болон

<sup>95</sup> “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2016, №1(56), 10-р тал.

бүх насаар нь хорих гэсэн хэлбэртэй байхаар хуульчлав. Үүний хамт хорих ялын тэнэсэн харгалзах нөхцөл, журмыг нарийвчлан тодорхой хуульчилсан (ЭХ 7.1) ба ял бус албадлагын арга хэмжээний төрлийг нэмэгдүүлж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах болон эмнэлгийн чанартай албадлага хэрэглэх, хөрөнгө орлогыг хураах зэрэг арга хэмжээг нарийвчлан тодорхойлж, энэ хуульд тусгаж оруулсан билээ.

Насанд хүрээгүй буюу өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тусгай бүлэг болгон Эрүүгийн хуульд оруулж, уг хуулийн 8.1-8.7 дугаар зүйлүүдээр тусгайлан хуульчилсан нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд шинэлэг ач холбогдолтой зохицуулалт болсон.

Дээр дурдсан шинэлэг өөрчлөлт, зарим онцлогийг дүгнэн шинжилж үзсэний үндсэн дээр 2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлалыг төрийн бодлогын хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд тоймлон илэрхийлбэл:

1. Ялын бодлогод хүмүүнлэгийн шинжтэй өөрчлөлт оруулж, цаазаар авах ялыг халж, хорих ялын хэт түгээмэл хэрэглээг хязгаарлаж, багасгах;
2. Гэмт хэргийн төрөл, ангилал, бүрэлдэхүүнийг Дэлхийн эрүүгийн загвар хууль, НҮБ-ын гэрээ, конвенци болон хөгжингүй улс, орнуудын эрүүгийн эрх зүйн суурь зарчим, нийтлэг жишигтэй нийцүүлж уялдуулах;
3. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгох;
4. Эрүүгийн хуульд хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хуулиар тогтоосон нэр томъёо, зүйл, хэсэг, заалтыг оновчтой хэрэглэх замаар зарим хэм хэмжээг тайлбарлах үед хуулиар тусгайлан эрх олгосны дагуу хэм хэмжээ тогтоосон актыг хэрэглэж болох талаар тусгах;
5. “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх” буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн “**Non double jeopardy**” зарчмыг тууштай мөрдөх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
6. Хорихоос өөр төрлийн ялын нөхцөл, агуулгыг нийтлэг жишиг, хүний эрхийн зарчимд нийцүүлэн өөрчилж, баривчлах, албадан ажил хийлгэх ялыг халах, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах зэрэг шинэлэг хэлбэрийн ялын төрлүүдийг бий болгох, Монгол Улсын онцлогт нийцүүлж жирэмсэн эмэгтэй, 55 наснаас дээш насны эмэгтэй, 60 наснаас дээш насны эрэгтэй хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахгүй байхаар тусгах;
7. Торгох ялыг торгуулийн нэгжийн нөхцөлөөр оногдуулахын зэрэгцээ ялтны хөрөнгө, цалин хөлс бусад орлого олох боломжийг харгалзан хэсэгчлэн төлөх боломжтой байхаар тусгах;
8. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн гэм буруутай болохыг хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх, хор уршгийг арилгах хүсэлтээ илэрхийлж, тэр бүхнээ нотлон харуулсан бол ялын тодорхой хэсгийг оногдуулах, тэнсэн харгалзах, эсхүл ялаас чөлөөлөх зэрэг уян хатан нөхцөл, боломжийг тухайн хуулиар хориглохгүйгээр зөвшөөрч тусгах;

9. Албадлагын арга хэмжээний төрлийг нэмэгдүүлж, хэрэглэх нөхцөлийг нь тодорхой болгон хуульчлах;
10. Эрүүгийн хуульд материаллаг бүрэлдэхүүний шалгуур, босго тогтоохоос аль болох зайлсхийж, гэмт үйлдлийн шинж, үр дагаврыг шууд тоочин дэлгэрүүлж тодорхойлох замаар өмнө нь ангилж ирсэн дөрвөн ангиллын уламжлалыг өөрчилж, гэмт хэргийг категоричлох, хууль зүйн техник ашиглан ялыг оногдуулахдаа гэмт хэргийг ангилахгүйгээр гэм буруу болон гэмт хэргийн хохирол, үр дагаврыг харгалзан үздэг шинэ хандлага, үзэл баримтлалыг тусгах;
11. Эрүүгийн хуулийн тусгай ангийн уламжлалт бүтэц, агуулгад өөрчлөлт оруулах, шинээр гэмт хэрэгт тооцох, эс тооцох, эрүүжүүлэх, эрүүгүйжүүлэх үйлдлийг нийтлэг жишиг, загвар хууль болон НҮБ-ын гэрээ, конвенцид нийцүүлж, шинэчлэн тусгахаас гадна **“эдийн засгийн гэмт хэрэг”** гэсэн шинэ бүлгийг нээж, орчин үеийн агуулгаар баяжуулж, шинээр зүйлчлэн томьёолж, хуульд оновчтойгоор тусгах;
12. Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулах нөхцөл, зарчим, журмыг улам боловсронгуй болгож, Эрүүгийн хууль дахь хэм хэмжээний давхардал, хийдэл, зөрчилдөөнийг арилгах зэрэг болно.

Эрүүгийн хууль нь өөрчлөгдөн шинэчлэгдсэн онцлог болон үзэл баримтлалын хувьд Монгол Улсад гарч буй гэмт халдлагыг таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн шаардлагыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь** 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилж байна.

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Эрүүгийн хэрэн хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалд *“... Мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны олон жилийн практикаар шалгагдсан хэм хэмжээнүүдийг авч үлдэх, олон улсын гэрээ, конвенци, НҮБ-ын зөвлөмжүүдэд тухайн хуулийг нийцүүлэх, Дэлхийн эрүүгийн процессын загвар хуулийн агуулга, зарчмыг судалж тусгах, судалгааны бүтээлүүдийг харгалзах, хүний эрхийн зарчим, шаардлагыг тусгах ...”* зэрэг үндэслэл нөхцөлүүдийг дурдсан байдаг. “Эрүүгийн байцаан шийтгэх хууль” гэж нэртэй байсныг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” гэж өөрчлөн нэрлэсэн нь зөвхөн хуулийн нэр томьёо, үг хэллэг өөрчлөгдсөн хэлбэрийн төдий зүйл биш, харин эрүүгийн процессын зарчим, зорилгыг хүний эрхийн шаардлагатай уялдуулсан агуулгын өөрчлөлт болсон юм.

Өмнөх 2002 оны ЭБШХ-тай харьцуулахад 2017 оны хуульд дор дурдсан зарчмын шинжтэй өөрчлөлт орсон. Үүнд:

1. Эрүүгийн хэргийг түргэн шуурхай, үе шаттайгаар шалган шийдвэрлэх боломж, нөхцөл нэмэгдсэн (*хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үе шат, хугацаа, нөхцөл журам*);

2. Эрүүгийн хэргийг хялбаршуулж шийдвэрлэх эрх зүйн орчныг оновчтой, тодорхой болгох алхам хийгдсэн;
3. Гэрч, хохирогчийг хамгаалах процессын нөхцөл, журмыг шинээр хуульчлан эрх зүйн тодорхой зохицуулалттай болгосон;
4. Эрүүгийн процесст оролцогч субъектүүдийн эрх зүйн байдлыг оновчтой болгон эрх, үүргийг зааглаж, хариуцлагыг нь тодорхой болгосон;
5. Албадлагын арга хэмжээг таслан сэргийлэх арга хэмжээ болгон өөрчилж, баривчлах, цагдан хорих нөхцөл, үндэслэлийг хүний халдашгүй эрхийн шаардлагатай уялдуулж, шинэчлэн хуульчилсан ба дээрх арга хэмжээг шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэх тогтолцоог бий болгосон;
6. Өмнө нь прокурорын бүрэн эрх мөрдөн хяналтын чиг үүргийн хүрээнд хязгаарлагдаж байсныг өөрчилж, шүүхийн өмнөх эрүүгийн процессын хяналтыг яллах чиг үүрэгтэй уялдуулж, прокурорын эрх хэмжээг цогц байдлаар хуульчилсан нь мөрдөн байцаалт ба яллах чиг үүргийг зааглах чухал алхам болсон;
7. Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмыг бий болгон хуульчилсан;
8. Мөрдөн шалгах ажиллагааны хэлбэр, хүрээг нарийвчлан тогтоож, прокурорын зөвшөөрөлтэй ба зөвшөөрөлгүй явуулах мөрдөн шалгах ажиллагааг зааглан тодорхой зохицуулалттай болгосон;
9. Эрүүгийн хэргийн нотлох ажиллагааг ихэнхдээ байцаалтад тулгуурлан явагдаж байсныг халж, гэрч, хохирогч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах хэлбэрт шилжсэн ба хяналт тогтоох, ажиглалт явуулах, хамтран ажиллах этгээдийг тогтоож, харилцан ажиллах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, хяналтын худалдан авалт хийх зэрэг өргөн хүрээнд явуулж байхаар хуульчилсан;
10. Нотлох баримтын агуулга, томъёоллыг өөрчлөн томъёолж, шүүхээс мөрдөн байцаалтад буцаадаг тогтолцоог халж, шүүхийн шийдвэр гаргах процесс, бүтэц, хэлбэрийг шинэчлэн тодорхойлсон г.м.

Энэ хуулийг баталж, мөрдөх болсноор бүх төрлийн хэргийг хэрэг бүртгэлтээр дамжин мөрдөн байцаалтыг явуулах шинэ журмыг тогтоон хэрэгжүүлэх болсон ба эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн билээ.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн үзэл баримтлалыг хураангуйлж илэрхийлбэл:

1. НҮБ-аас гаргасан эрүүгийн процессын загвар хууль, НҮБ-ын гэрээ, конвенцийн зарчим, жишигт энэ хуулийн агуулгыг нийцүүлж уялдуулах;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг мэдээллээр хангах, тэднээс эрхээ шаардах, эдлэх баталгааг хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, процесс ажиллагааны бүхий л үе шатанд хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлж, дуу дүрсний бичлэг хийх зэргээр орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах журмыг тогтоох;



3. Хүний эрхийг хязгаарласан аливаа ажиллагааг зөвхөн шүүх, прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр зааж, шүүхээс гадуур хүний эрхэнд халдах хойшлуулшгүй үндэслэл, журмыг тодорхой тусгах;
4. Шүүн таслах ажиллагааны өмнөх үе шатанд шүүх хуралдааны бэлтгэл хангах зорилгоор урьдчилсан хэлэлцүүлэг хийх, шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагаа ба яллах чиг үүргийг зааглан ялгах;
5. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл, журмыг шинэчлэн тогтоох, гэм буруугаа хүлээсэн, хохирол, төлбөрөө төлсөн нөхцөлд хүнд биш, хэргийн хувьд процесс ажиллагааг түргэн шуурхай шийдвэрлэх эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх;
6. Прокурорын чиг үүргийг нийтлэг жишиг, загвар хуулийн агуулгад нийцүүлж, эрүүгийн хэрэг үүсгэх, ял сонсгох асуудлыг бие даан шийдвэрлэх зохицуулалтыг тусгах;
7. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэх журмыг бий болгох;
8. Анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг зарим талаар өөрчилж, нарийвчлан тогтоохоос гадна шүүх, шүүгчийн бүрэн эрхийг өөрчлөн тодорхойлох;
9. Өсвөр насны хүнтэй холбоотой процесс ажиллагааны журмыг бие даасан институт болгон тусгайлан тогтоож, илүү тодорхой болгон хуульчлах;
10. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг нарийвчлан тусгах г.м.

Дээр дурдсан чиглэл бүхий үзэл баримтлал нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн үндсэн агуулгыг тодорхойлж байна.

Дүгнэн илэрхийлбэл 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэсэн энэ хоёр хууль бол Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг төдийгүй гэмт хэргийн зүйлчлэл, шинж, бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоох ялын бодлогыг орчин үеийн нийтлэг зарчим, шаардлагад нийцүүлж уялдуулах, шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

### **3.3. Гэмт хэрэг ба ялын онол, орчин үеийн чиг хандлагууд**

Орчин үед эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан өмнө үетэй харьцуулахад онол, арга зүй, технологи, зарчмын хувьд эрс өөрчлөгдөн хөгжиж ирсэн ба түүний хэрэглээ, хүртээмж нэмэгдэж, үнэт зүйлс нь шинэчлэгдсээр байна.

XXI зуун гарснаас хойш сүүлийн хорь шахам жилд даяарчлалаас үүдэлтэй эрх зүйн интеграцчиллын шинэ орчин бүрэлдэж бий болсон нь эрүүгийн эрх зүйн салбарт хууль тогтоомж, тогтолцоо төдийгүй онол, үзэл баримтлалын

хувьд эрс өөрчлөгдөх хүчин зүйл болсон билээ.<sup>96</sup> Ялангуяа эрүүгийн ялын залхаан цээрлүүлэх, албадан хүмүүжүүлэх зорилгын ач холбогдол буурч, харин ялын урьдчилан сэргийлэх, ухааруулах, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн үнэ цэнэ, үүрэг роль өсөн нэмэгдсээр байна. Түүнчлэн социалист тогтолцооны мөн чанар, түүхэн цаг үеийн бодлого, номлолоос улбаатай улс, нийгмийн эрх ашгийг хэт дөвийлгөн шүтэж, түүнийг хамгаалахад эрүүгийн эрх зүй олон жил үйлчлэн оршиж, гэмт хэргийн төрөл, ангилал, зүйлчлэлд материалист догматик онолын арга зүйг туйлчлан хэрэглэж ирсэн нь онолын сэтгэлгээний хөгжилд сөрөг нөлөө үзүүлснийг үгүйсгэж болохгүй. Гэмт хэргийн онолын материалист догматик хандлага нь гэмт хэрэг бүрийг материаллаг бүрэлдэхүүн бүхий объектив шалгуураар үнэлж тодорхойлоход чиглэгддэг.<sup>97</sup> Эдүгээ Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарт хийгдэж буй реформ нь Эрүүгийн хууль болон эрүүгийн шүүхийн практик өөрчлөгдөх болсноор хязгаарлагдаагүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол, арга зүй, сэтгэлгээнд ч өөрчлөлт шинэчлэлт явагдаж байна. Юуны өмнө дэлхий нийтийн хэмжээнд харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий орнуудад түгээмэл хэрэглэгдэж гэмт хэрэг зүйлчлэл, бүрэлдэхүүний болон ялын онолын гол чиглэл, үзэл баримтлал, тэдгээрийн онцлог, агуулгыг тоймлон авч үзье.

## I. ГЭМТ ХЭРГИЙН ОНОЛЫН ТАЛААР:

### 1. Гэмт хэргийн зүйлчлэлийн онол:

Энэ онол нь гэмт хэргийн шинжийг түүний нийгмийн болон эрх зүйн үр дагаврын шалгуураар авч үзэхтэй холбоотой хуулийн болон хуулийн бус томъёоллоор тодорхойлоход чиглэгдсэн үзэл баримтлал юм. Энэ онолыг улс, орнуудад хөгжиж тархсан байдлаар нь хоёр ангилалд ялган авч үздэг.<sup>98</sup> Үүнд:

А) Формаль онол (*Formal theory of crime*)

Б) Материалист онол (*Materialist theory of crime*)

А. *Формаль онол* гэдэг нь гэмт хэргийг нийгмийн мөн чанар талаас нь бус хуульд хориглосон эрх зүйн шинж, хууль зүйн үр дагаврын шалгуураар тодорхойлж тайлбарлахад чиглэгдсэн үзэл баримтлал юм.<sup>99</sup> Гэмт хэрэг бол “нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл” биш, энэ бол зөвхөн хуульд гэмт хэрэг гэж тусгайлан заасан эрх зүйн үр дагавар бүхий үйл ажиллагаа, үйлдэл, үйл хөдлөл гэж тайлбарладаг байна. Энэ онолоор бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэргийг тухайлан онцолж нэгтгэн тодорхойлох шаардлагагүй, харин Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэг бүрийн шинжийг дэлгэрэнгүй томъёолж, онцлог шалгуураар нь, төрөл, зүйлээр нь хооронд

<sup>96</sup> “Эрх зүй” сэтгүүл, 2014 №2-28, 101 дэх тал.

<sup>97</sup> Леже Р, Методология сравнительного уголовного права, М., 1978, с. 99-100.

<sup>98</sup> В.И.Додонов, Сравнительное уголовное право, М., 2009, с. 137-138.

<sup>99</sup> Ю.Е.Пудовочкин, Учение о преступлении, М., 2010, с. 48-49; Современные тенденции уголовно-правовой теории, М., 1994, с. 51.

нь ялгаж болохоор хуульчлах ёстой гэж номлодог.<sup>100</sup> Угаасаа ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхийг нэгдмэл тодорхойлолтоор ерөнхийлж хуульчлах боломжгүй, гэмт хэргийн төрөл тус бүр дээр ялгагдах онцлог шинжээр нь хуульчлан томъёолох, тэгэхдээ гэмт хэргийн категоричлолыг ялын санкцийн болон эрх зүйн үр дагаврын шалгуураар тодорхойлох явдлыг үгүйсгэдэггүй. Энэхүү хандлага баруун Европ, Латин Америк болон хөгжингүй орнуудын дийлэнхид хүлээн зөвшөөрөгдөж, эрүүгийн эрх зүйн хэрэглээнд нэвтэрч хэрэгжсэн байдаг.

*Б. Материалист онол* гэдэг нь гэмт хэргийг нийгмийн мөн чанар талаас нь материаллаг хүчин зүйл, объектив шалгуурыг голлох нөхцөл болгон авч үзэж, тайлбарлахад чиглэгдсэн үзэл баримтлал юм. Гэмт хэрэг бол нийгмийн шалтгаан, үр дагавар бүхий нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл мөн бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэргийн нийтлэг шинж, тодорхойлолтыг заавал томъёолох “ёстой” гэж тайлбарладаг. “Гэмт хэрэг гэдэг ойлголтыг тодорхойлоход ач холбогдол бүхий шалгуур нөхцөл, онцлог байдлыг илэрхийлэхээс гадна гэмт хэргийг гадаад, дотоод шинжээр нь ерөнхийлөн тодорхойлох ...”<sup>101</sup> нь арга зүй, практик хэрэглээний хувьд ач холбогдолтой гэж үзнэ.

Энэ онолын дэг сургууль ОХУ, Казахстан, Армен, Беларусь, Монгол зэрэг пост-социалист орнуудаас гадна Куба, Вьетнам, Хойд Солонгос, Хятад зэрэг социалист орнуудад түгээмэл тархсан юм. Материалист онолын мөн чанараас үүдэн Эрүүгийн хууль нь зорилт, зарчим, чиг үүрэг зэргийг криминализацийн агуулгаар дэлгэрэнгүй тодорхойлж, хуульчилсан байх ажээ.

## **2. Гэмт хэргийн бүтэц, бүрэлдэхүүний онол:**

Энэ онол нь гэмт хэргийн шалгуур, агуулгыг бүрдүүлэх дотоод зохион байгуулалтын элементүүдийн уялдаа, холбоо, бүрдэлжсэн байдлын зүй тогтлын тухай үзэл баримтлал юм.<sup>102</sup> Барууны болон хөгжингүй орнуудад “гэмт хэргийн бүтээцийн онол” пост-социалист орнуудад “гэмт хэргийн бүрэлдэхүүний онол” гэсэн нэрээр нэршин хэрэглэгдэж байна. Гэмт хэргийн бүтэц, бүрэлдэхүүний онол нь мөн чанар, агуулгын хувьд чухамдаа тухайн хууль зөрчсөн үйлдэл гэмт хэрэг мөн эсэхийг шалган үнэлэх арга зүйн баримтлал, үзэл санаа юм. Эрх зүйн систем, бүлийн онцлогоос хамаарч харилцан адилгүй аргачлал, бүтцийн шалгуурыг тодорхойлж ирсэн хэдий ч гэмт хэргийг таньж ялгах объектив ба субъектив хүчин зүйлсийн нөхцөлүүд нь адил төстэй байдаг.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүтэц, бүрэлдэхүүний онолын дараах загвар, хэв маяг байдгийг дурдах нь зүйтэй. Үүнд:

1. Хоёр элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол;
2. Гурван элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол;

<sup>100</sup> Флетчер Дж, А.В.Наумов, Основные концепции современного уголовного права, М., 2014, с. 81-83.

<sup>101</sup> Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй (IV хэвлэл), УБ., 2017, 91 дэх тал.

<sup>102</sup> J.Wigmore, Corpus delict. Evidence, W., 2006, p. 58-59.

3. Дөрвөн элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол гэх мэт Эдгээрийг тус бүрд нь ялгагдах байдлаар нь тоймлон авч үзье.

### **Нэг. Хоёр элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол:**

Энэ онол нь ихэнхдээ Англи-Америкийн эрх зүйн тогтолцоо бүхий улс, орнуудад өргөн тархсан ба гэмт хэргийн дотоод бүтцийг бүрдүүлэгч сэтгэл зүйн болон биет элементийн уялдаа, хамаарал, зүй тогтолт шинжээр тайлбарлахад чиглэгдсэн үзэл баримтлал юм.<sup>103</sup> Бүрэлдэхүүний хоёр элемент нь:

а) **Mental elements:** *Сэтгэл зүйн элемент*

б) **Physical elements:** *Биет элемент*

Сэтгэл зүйн элемент нь гэмт хэргийн сэдэл, зорилго, гэмт санаа, сэтгэцийн нөхцөл, хандлага зэрэг субъектив шинжүүдийн агуулгыг тодорхойлно. Орос, Монгол зэрэг улсад буюу бидний сэтгэлгээнд хэвшиж тогтсон субъектив талын шинж гэж догматик адилтгалаар ойлгож болохгүй. Ялангуяа сэтгэл зүйн элемент нь гэм буруугийн ойлголтыг агуулдаггүй, түүнээс ялгаатай шалгуураар авч үздэг.

Биет элемент нь гэмт хэргийн бодит үйлдэл, хохирол, гэмт үйлдлийн орчин, цаг хугацаа, хэлбэр зэрэг биежиж хэлбэржсэн бүтцийн шинжийг илэрхийлнэ. Зүй тогтолт шинжийн хувьд сэтгэл зүйн элемент нь биет элементийг тодорхойлсон байх бөгөөд голлох шалгуур нь болдог (***Mens rea-Actus reus***). Энэ онолын баримтлалд тухайн органик бүрэлдэхүүнээс гадна процедурын шалгуур бүхий функциональ бүрэлдэхүүний тухай өгүүлдэг. Гэмт хэргийн шалтгаант нөхцөл, ялын санкцийн хамаарал, хүндрүүлэх, хөнгөрүүлэх хүчин зүйл, гэмт хэргийн хохирол, үр дагаврыг арилгасан буюу ял тохиролцсон байдал зэргийг харгалзан тооцдог ажээ.<sup>104</sup>

Гэмт хэргийн функциональ бүрэлдэхүүний шалгуур шинжүүдэд: “а) Гэмт хэрэг гэдэг нь хууль тогтоомжид нарийвчлан томъёологдсон байх; б) Хохирол үр дагаврын зайлшгүй холбогдсон байх; в) Ялын санкцийн хамааралтай байх г.м” зэргийг оруулсан байдаг.<sup>105</sup> Энэхүү онолын хандлага нь АНУ, Англи, Канад, Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, Пакистан болон Франц, Бельги, Люксембург зэрэг цөөнгүй оронд хэрэглэгдэж байна.

### **Хоёр. Гурван элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол:**

Энэ онол нь Германы сонгодог эрүүгийн эрх зүйн онолын төлөөлөгч Е.Белинг, А.Шюбел, А.Фейрбах нарын үзэл, сэтгэлгээнд үндэслэгдэн боловсруулагдсан<sup>106</sup> бөгөөд эдүгээ Баруун Европын болон эх газрын эрх зүйн системийг баримжаалан хөгжиж буй дэлхийн ихэнх улс оронд түгээмэл

<sup>103</sup> Norman M.Garland, Criminal Law for the criminal justice professional, N.Y., 2003, p. 82.

<sup>104</sup> J.Wigmore, Corpus delict: Evidence, C.A., 1981, p. 21.

<sup>105</sup> R.Wayne, R.La.Fave, Criminal Law, West. A.Thomson reuters, 2010, p. 21-23.

<sup>106</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал, УБ., 2012, 35 дахь тал.

хэрэглэгдэж байна. “Гэмт хэргийн бүтээц” буюу гэмт хэргийн бүтцийн бүрэлдэхүүн нь эрүүгийн хэрэглээний арга зүй, зарчмыг тодорхойлох чухал нөхцөл нь болдог. Энэхүү онолын аргачлал нь Оросын буюу пост-социалист орнуудын гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элемент бүхий онолоос хэрэглээний зарчим, логик арга зүйн хувьд эрс ялгагддаг. Гурван элементийн онолын мөн чанар, онцлогийг тоймлон<sup>107</sup> илэрхийлбэл:

- а) Хуульд заасан хэргийн бүрдэл (*Tatbestand*)
- б) Хуульд харш чанар (*Rechwidrigket*)
- в) Гэм буруу (*Schuld*)

Эдгээр гурван элементийн онцлох шинжийг тус бүрд нь авч үзье.

*а) Хуульд заасан хэргийн бүрдэл:*

Энэ нь хуулиар тусгайлан тодорхойлж өгсөн гэмт хэргийн шинжүүдийн нийлбэр цогц юм. Объектив ба субъектив гэсэн хоёр бүрдэлт шинжийг илэрхийлнэ. Объектив бүрдэл гэдэгт гэмт хэргийн гаднах шинж болох гэмт үйлдлийн хэлбэр, үр дагавар, хор уршиг, гэмтэл, шалтгаант хамаарал зэргийг хэлнэ. Субъектив бүрдэл гэдэг нь гэмт хэргийн дотоод тал буюу гэмт санааны хүссэн ба мэдсэн байх хүсэл зоригийн шинж юм.

*б) Хуульд харш чанар:*

Гэмт хэрэгтний үйлдлийг зөвтгөх буюу гэмт хэргийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, хуулиар зөвшөөрөгдөөгүй нөхцөлт шинжийг авч үзэх боловч гэмт үйлдэл нь юуны өмнө хууль зөрчсөн байхаас гадна хуульд тусгайлан заасан шалгуур шинжүүдийг хангасан байхыг шаарддаг.

*в) Гэм буруу:*

Энэ элемент нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл хангагдсан байх, өөрөөр хэлбэл хэрэг хариуцах чадвар, нас, сэтгэцийн хувьд ял оноход хамааралтай шинж юм. Германы эрүүгийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг дээрх онол нь нэг төрлийн гэмт хэргийг нөгөөгөөс ялгах, аливаа эрүүгийн гэмт хэргийг бусад зөрчлөөс ялган таньж зүйлчлэх гол арга зүй нь болдог. Монгол, Орос болон Пост-социалист голдуу орнуудад гэм бурууг субъектив хүчин зүйлд багтааж сэтгэхүйн харьцаа, сэтгэл зүйн элементтэй холбон тайлбарладаг. Харин Германд гэм буруугийн асуудлыг субъектив хүчин зүйлээс ангид тусад нь авч үздэг. Германы эрүүгийн эрх зүйд Гэм буруугийн онолоор гэмт хэргийн үйлдэл нь зөвхөн шууд санаатай үйлдэгдсэн буюу төгс үйлдэл хийгдсэн үед л гэм буруугийн хамаарал бий болно гэж тайлбарладаг бол гэмт санааны онолоор гэмт үйлдэл нь хүссэн ба мэдсэн байх субъектив шинжийг бүрэн хангаагүй боловч гэмт үр дагаврыг бий болгосон бол хуульд тусгайлан заасан хэргийн бүрдлийн формаль шинжийг хангасан гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэх юм.<sup>108</sup> Дээрх онолыг гүнзгийрүүлж судлах, практикт хэрэглэх шаардлага өсөн нэмэгдсээр байгаа

<sup>107</sup> “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2017N°1(61), 52 дахь тал.

<sup>108</sup> А.Э.Жалинский, Современное немецкое уголовное право, М., 2004, с. 205.

билээ.

### **Гурав. Дөрвөн элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онол:**

Энэ онол Монгол Улсад 60 шахам жил идэвхтэй хэрэглэгдэж ирсэн нь уг онол Монголын хууль шинжлэх ухааны нэг үзэл баримтлал, арга зүй болтлоо хөгжиж, төлөвшсөнийг харуулна. 1964-2017 он хүртэлх Монгол Улсын эрүүгийн эрх зүйн сурах бичиг, ном бүтээлүүдэд гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элементийн онолыг уламжлалт хандлагаар дэлгэрүүлж тайлбарласан байдаг.<sup>109</sup> Энэ онолын сэтгэлгээ манай хуульч, шүүгчдийн дунд өнөө хэр төлөвшсөн хэвээр байгаа ба тухайн үзэл баримтлал, итгэл үнэмшил нь өөрчлөгдөөгүй өдий хүрсэн.

Дөрвөн элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг эрх зүйч, хуульч, шүүгч нар бүгд бүрэн мэдэж эзэмшсэн тул уг онолыг зөвхөн мөн чанар талаас нь цухас хөндөж, товчлон дурдъя. Дөрвөн элемент<sup>110</sup> гэдэг нь:

1. Объект;
2. Объектив тал;
3. Субъект;
4. Субъектив тал.

*Объект гэдэг нь* гэмт хэрэгт өртөгдөж, хөндөгдсөн буюу гэмт халдлагын зүйл болж буй эд юмс. Энэ нь ихэнхдээ материаллаг шалгуураар үнэлэгдэх объект байдаг. Маш хязгаарлагдмал хүрээнд нэр төр, алдар хүнд, мэдлэг, оюун ухаан, оюуны бүтээл зэрэг үнэт зүйлс гэмт хэргийн объект болно. *Объектив тал гэдэгт* гэмт хэргийн гэмт үйлдэл, түүний хэлбэр, хор уршиг, үр дагавар, шалгаант холбоо болон гэмт хэргийн үе шат, үгүйсгэх нөхцөл байдлуудыг авч үздэг. *Субъект гэдэг нь* гэмт хэрэг үйлдсэн этгээд бөгөөд нас, хэрэг хариуцах чадварын шаардлага хангасан субъект юм. Насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвар бүхий иргэн, албан тушаалтан байхаас гадна 2015 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 1.3.4-р зүйл болон 9.1-р зүйлд зааснаар хуулийн этгээд гэмт хэргийн субъект болно. Монгол Улсад 14 насанд хүрсэн хүн зарим гэмт хэргийн тухайд гэмт хэргийн субъект болно. *Субъектив тал гэдэгт* гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруугийн хэлбэрийг голчлон хамааруулж ойлгоно. Энд гэм буруугийн санаатай ба болгоомжгүй хэлбэр, гэмт хэргийн зорилго, сэдэлт зэрэг субъектив хүчин зүйлийг багтаан үздэг. Гэм буруугийн санаатай хэлбэр нь шууд ба шууд бус санаа, болгоомжгүй нь дотроо хайхрамжгүй хандах, хөнгөмсгөөр найдах гэсэн хэлбэрт хуваагдана. Гэмт хэргийн дөрвөн элементийн онолд объектив талын буюу материаллаг бүрэлдэхүүний агуулгыг илүү тодорхойлогч хүчин зүйл болгон авч үздэг. Сүүлийн жилүүдэд судлаачдын дунд энэ онолын зарчим, арга зүйг шүүмжлэх хандлага бий болоод байгаа ба ялангуяа гэм буруугийн ойлголтыг жишгийн шалгуураас өөрөөр хэт субъектив хандлагаар үнэлж байгааг шүүмжилдэг.

<sup>109</sup> Б.Батбаяр, А.Түвшинтулга, Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл (1911-2012), УБ., 2014.

<sup>110</sup> Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, (ред Ж.Бямбаа), УБ., 2010.

Түүнчлэн гэмт хэргийн шууд бус санаа гэж хэзээ ч байж болохгүй гэх бөгөөд “субъект” гэсэн ойлголт гэмт хэргийн бүрэлдэхүүний элемент биш гэж тайлбарладаг байна. Монгол Улсын хувьд цаашдаа энэ онолын хэрэглээнээс татгалзах шаардлага бий болсныг үгүйсгэх аргагүй юм.

## II. ЯЛЫН ОНОЛ:

Ялын онолын гол агуулгыг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, арга зүйн хүрээнд товч дурдаж өмнөх сэдвүүдээр авч үзсэн билээ. Энэ сэдвийн хүрээнд өмнө нь дурдсаныг зарим шинжийг нь тодруулж, дэлгэрүүлж тоймлон авч үзье.

Эдүгээ орчин үед ялын онолын гурван үндсэн хандлага бий болоод байгаа билээ.<sup>111</sup>

1. Абсолют буюу туйлын онол;
2. Релятив буюу харьцангуй онол;
3. Дундын буюу нийлмэл онол.

**1. Абсолют онол нь** 19-р зууны эхэн үеэс эрүүгийн анхны төрөлжсөн хуульд тусгагдаж ирснээр албан ёсны үзэл баримтлал болж хөгжиж ирсэн бөгөөд ял шийтгэл нь гэмт хэрэгтэйгээ яг тохирсон байхад энэ онолын гол агуулга оршдог. Харин 19-р зууны 50, 60-аад оны үе хүртэл идэвхтэй хөгжиж, түгээмэл тархсан боловч 1960-аад оны эхэн үеэс нэр хүнд, үүрэг, роль нь буурсан байдаг. Энэ онолын үнэт зүйлс, түүхэн ач холбогдол нь эрүүгийн эрх зүйд шударга ёсны зарчмыг хөгжүүлэх, бататган бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсанд оршино. Эрүүгийн ялын залхаан цээрлүүлэх зорилго, чиг үүргийг тодорхойлоход түүхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Харин уг онолын сул тал нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг засан төлөвшүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд сөргөөр нөлөөлсөн гэж үздэг. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн суурь зарчмуудад тулгуурлан хүний эрх, эрх зүйт ёсны агуулгаар авч үзвэл туйлын онолын хэрэглээ улам бүр хязгаарлагдсаар байгаа юм. Нэн ялангуяа сүүлийн хориод жилд цаазаар авах ялыг халсан улс орнууд нэмэгдэж, хорих ялыг түгээмэл байдлаар хавтгайруулж хэрэглэх явдлыг хориглон хязгаарлах болсон зэрэг дээрх онолыг шүүмжлэн үгүйсгэхэд хүргэсэн юм.

**2. Релятив онол нь** 20 дугаар зууны хоёрдугаар хагаст хүртэл түрэн орж ирж абсолют онолын сул талыг нөхөн, бие даасан урсгал байдлаар хөгжсөн байдаг. Харьцангуй онол нь ялын зорилгын цээрлүүлэх агуулгыг хязгаарлаж, улам илүү урьдчилан сэргийлэх буюу засан төлөвшүүлж нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой гэж үздэг. Энэ онолоор бол гэмт хэрэг үйлдсэн хүнд гэмт хэрэгт нь яг тохирсон ялыг оноох нь ялын зорилгод нийцэхгүй, харин ял нь яг эзнээ олсон, оновчтой байхын дээр урьдчилан сэргийлэх үүрэг хүлээх тухай өгүүлдэг.

Германы эрүүгийн эрх зүйд харьцангуй онолын урьдчилан сэргийлэх

<sup>111</sup> Энэ 3 онолын агуулгыг гарын авлагын 2 дугаар сэдвийн 1 дэх хэсэгтэй харьцуулж, эргэцүүлж судлах нь зүйтэй(Д.Б.)

зорилгыг нийгмийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээтэй уялдуулж, ялын үр ашигт, үр нөлөөт байдлын шалгуур нөхцөлөөр авч үзэж тайлбарладаг байна.<sup>112</sup> Энэ онолын сул тал нь түүнд ялын хэмжээг хязгаарласан шалгуур үзүүлэлтийг орхигдуулж тооцдог<sup>113</sup> гадна хүнд ноцтой гэмт хэрэг олон удаа үйлдсэн “засаршгүй ялтанд” ял завшуулах боломжийг олгодгийг үгүйсгэж болохгүй.

**3. Нийлмэл онол нь** туйлын болон харьцангуйн онолын сул талыг нөхөн тэнцвэржүүлэх зорилгоор орчин үед шинээр гарч ирсэн хандлага бөгөөд дэлхийн эрүүгийн загар хуулийн үзэл баримтлалд нэлээд тодорхой тусгагдсан байдаг. Энэ онолоор ял нь зөвхөн цээрлүүлэх, эсхүл урьдчилан сэргийлэх шинж чанар бүхий арга хэрэгсэл гэдгийг аль алиныг нь туйлшруулан хэт үнэлэх, нэгийг нь нөгөөтэй нь сөргөлдүүлэх, эсхүл аль нэг нь давамгайлсан байх хандлагыг үгүйсгэж тайлбарладаг. Гэхдээ нийлмэл онолын хэрэглээний хүрээ харьцангуй хязгаарлагдмал бөгөөд эдүгээ дөнгөж хөгжлийн эхэн үеийн шатандаа байна. “Нийлмэл онолын үзэл баримтлал дээр тулгуурлан орчин үед ялыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх зорилготой хариуцлагын арга хэмжээ гэж тодорхойлж...”<sup>114</sup> байгааг дурдах нь зүйтэй. Орчин үеийн эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн болон ялын онолын цаашдын хандлагыг дараах чиглэлээр тодорхойлох болжээ.<sup>115</sup>

*Нэгдүгээрт,* Гэмт хэрэг, ялын ерөнхий нөхцөл, шинжийг хатуу шалгуураар догматик байдлаар хуульчлан тогтоохоос аль болох зайлсхийж, формаль онолын аргачлалаар тэдгээрийн ялгагдах онцлог шинжийг давхардал зөрчилдөөнгүйгээр тусгайлан хуульчлах, тухайн хүрээг нь өргөжүүлж, эрүүгийн эрх зүйн хэрэглээний оновчтой орчин бүрдүүлэх;

*Хоёрдугаарт,* Гэмт хэргийн материаллаг бүрэлдэхүүний органик онолын уламжлалт хэрэглээнээс зайлсхийж, түүний оронд формаль болон функциональ бүрэлдэхүүний гурван элемент бүхий онолыг хүлээн авч, зохистойгоор реценцлэх замаар шинэчлэн хөгжүүлэх;

*Гуравдугаарт,* Ялын онолын уламжлалт абсолют онолоос татгалзаж, ялын бодлогын үзэл баримтлалыг шинэчлэх боловсруулах, орчин үеийн шаардлага, хүний эрхийн зарчимд нийцүүлж, харьцангуй болон нийлмэл онолын үндэслэлийг судалж, хөгжүүлэх, шүүхийн практик хэрэглээнд зохистойгоор нэвтрүүлэх;

*Дөрөвдүгээрт,* Гэмт хэргийн зүйлчлэлд орчин үеийн хууль зүйн техникийн онол, арга зүйг тусган, нэвтрүүлэх замаар эрүүгийн хуулийн бичлэг, томъёоллын бүтэц, стандартыг шинэчлэн нийтлэг жишгийн шалгуурт нийцүүлж, боловсронгуй болгох;

<sup>112</sup> Э.Хильгендорф, Д.Чанцандулам, дурдсан бүтээл, 19 дэх тал.

<sup>113</sup> Model codes for Post-Conflict Criminal Justice: Model Criminal Code, Vivienni O'Connor and Colette Raush, W, 2007.

<sup>114</sup> Т. Золбоо, Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги. Гэмт хэргийн бүтээц (2 дахь хэвлэл), УБ., 2018, 22 дахь тал.

<sup>115</sup> “Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” эмхэтгэл-1, УБ., 2013. 33 дахь тал.



Тавдугаарт, Хуулийн этгээдийн гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг судалж хөгжүүлэх;

Зургаадугаарт, Хорихоос өөр төрлийн ялын зорилго, агуулгыг оновчтой болгон хөгжүүлэх замаар тэдгээрийн төрлийг өргөжүүлж, олшруулах, альтернатив буюу сонгох ялын хэрэглээг индексжүүлсэн таблицын системчлэлд оруулах;

Долоодугаарт, Ял бус эрүүгийн хариуцлагын санкцийг хэрэглэх онолын үндэслэлийг судалж хөгжүүлэх;

Наймдугаарт, Ялаас хамааралтай гэмт хэргийн догматик ангиллын тогтолцоог халж өөрчлөх, гэмт хэргийн категорчлолын уян хатан, оновчтой зохицуулалтыг бий болгох;

Есдүгээрт, Орчин үеийн зах зээлийн тогтолцоо бүхий ардчилсан дэглэмтэй орнуудын жишгийг харгалзахын зэрэгцээ Монголын үндэсний онцлог нийгэм-ахуй ёс заншил, зан суртахуунтай уялдаж нийцсэн гэмт хэргийн катологи, төрлийг шинэчлэн хуульчилж дахин кодификацчилах үйл явцыг эрчимтэй хэрэгжүүлэх г.м.

### 3.4. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх онцлог<sup>116</sup>

Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь эрүүгийн хуулийг тайлбарлахаас ялгаатай ойлголт юм. Тайлбарлах ажиллагаа нь эрүүгийн хуулийн тодорхой бус заалт, агуулгын утгыг тодруулан дэлгэрүүлж тодорхойлоход чиглэгддэг бол тайлбарлан хэрэглэх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдсон процесс ажиллагаа юм. Улсын Дээд Шүүхээс 2002-2013 он хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоол гаргадаг нь эрүүгийн эрх зүйд эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлах ажиллагаа байсан. Харин эрүүгийн хэргийг бүх шатны шүүхээр хянан хэлэлцээд шүүхийн тогтоол, шийдвэр гаргаж байгаа нь эрүүгийн эрх зүйд хуулийг тайлбарлан хэрэглэж байгаагийн жишээ юм. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх гэдэг нь эрүүгийн хуулийн заалт, хэм хэмжээг эрүүгийн тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд иш үндэс болгон ашиглан хэрэгжүүлж буй процесс ажиллагаа мөн. Ингэхдээ тухайн шүүхийн шийдвэрийг гаргах үндэслэлээ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний утга, агуулгад нийцүүлж тодорхойлсон эрүүгийн хуулийн зүйл заалтыг ашиглан, түүнээс ишлэн эрх зүйн гипотез, диспозици, санкцийн агуулгыг нээн илрүүлэхэд чиглэгдсэн үйл явц юм. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь бусад салбар эрх зүйтэй харьцуулахад дор дурдсан онцлог шинжүүдтэй. Үүнд:

1. Хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх бүх талын боломж нөхцөлийг хангахад чиглэгдсэн;

<sup>116</sup> Энэ гарын авлагын 1 дүгээр сэдвийн 1,2 болон 2 дугаар сэдвийн 1,2,3 дахь хэсгүүдэд эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх нийтлэг ба онцлог шинж, мөн чанарыг хөндөж дэлгэрэнгүй авч үзсэн тул энэ сэдвийн хувьд аль болох давхардуулахгүйгээр товчхон илэрхийлсэн болно (Д.Б).

2. Хуульд үндэслэгдэх буюу хууль дээдлэх ёсны шаардлагыг яв цав хангаж, эрүүгийн хуулийг давж, түүний агуулгаас өөрөөр тайлбарлах нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад чиглэгдсэн;
3. Эрүүгийн хуулийг тайлбарлан хэрэглэхдээ эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх замаар казуаль буюу кейсийн логик аргад илүү тулгуурлаж хэрэгжүүлэхэд чиглэгдсэн;
4. Нэг бүрчилсэн шинжтэй бөгөөд эрүүгийн хэргийн нөхцөл бүхий хууль зүйн фактыг олж тогтоох, илрүүлэх, хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн г.м.

Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх нь шууд утгаараа зөвхөн эрүүгийн хуулийг хамааруулж хэрэглэх тухай ойлголт боловч шууд бус утгаараа эрүүгийн эрх зүйн эх сурвалжид хамаарч болох бусад материаллаг ба процессын хуулиудыг багтаан ойлгохыг хэлнэ. Монгол Улсын эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1.2.5-д: “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно” гэж заажээ. Яг энэхүү заалтад нийцсэн байдлаар эрүүгийн хуулийн 11.1-11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах гэмт хэргүүд нь хэрэв эрүүгийн хуульд эдгээр хохирол, гэмтлийн зэрэг, түвшинг тодорхойлж тайлбарлаагүй нөхцөлд бусад хууль, хуульчилсан актуудаар зохицуулах боломжийг үгүйсгээгүй байна.

2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад хүний биед учирсан гэмтлийн зэргийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллагаас хэм хэмжээ тогтоосон актуудаар тодорхойлж, зохицуулж байсан билээ. Жишээ нь: ЭМНХ Яамны Эмгэг судлал-шүүх эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 1999 оны 12-р сарын 31-ний өдрийн хурлаар баталсан “Хүний биед учирсан гэмтлийн зэргийг тогтоох зааврын тайлбар аргачлал”-ыг дурдаж болно. Одоо үйлчилж буй эрүүгийн хуульд байгаа “Хүнд”, “Хүндэвтэр”, “Хөнгөн” гэсэн хохирлын үнэлгээг өмнөх үеийн уламжлалт эрүүгийн эрх зүйд хэрэглэж тайлбарлаж ирсэн “Хүнд гэмтэл”, “Хүндэвтэр гэмтэл”, “Хөнгөн гэмтэл” гэсэн гэмтлийн ангилал, зэрэглэлтэй адилтган Яамнаас тогтоосон (хуульчилсан актын) журам, зааврыг баримтлан адилтган тодорхойлох сэтгэлгээний хандлага өнөөдөр ч хэвээр байна. Зүй нь эрүүгийн хуулийн холбогдох зүйлүүдэд дэлгэрэнгүй тайлбартай нэмэлт өөрчлөлт оруулах буюу тусдаа хууль гаргах, эсхүл шинээр хэм хэмжээний акт батлан мөрдөх зэрэг арга, замаар оновчтойгоор шийдвэрлэх нь зүйтэй юм.

2015 оны Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1.2.4-т: “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын Хууль, Монгол Улсын Хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэж заасан. Энэ нь нэг талаас эрүүгийн хуулийн төдийгүй бусад хууль, олон улсын гэрээний хэм хэмжээг тайлбарлан хэрэглэхдээ ишлэл болгон ашиглах боломжийг хуулиар зөвшөөрсөн байдлыг харуулж байна. Нөгөө талаас эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т заасанчлан эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж болохгүй гэсэн хууль ёсны

зарчмын агуулгад нийцэхүйц байдлаар тайлбарлан хэрэглэх шаардлагатай гэдгийг илэрхийлнэ.

Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэхдээ эрүүгийн хуулийг голлох үндсэн эх сурвалж болгон түүний зорилго, зарчим, агуулгыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг ба тусгай аргуудын<sup>117</sup> тусламжтайгаар хэрэгжүүлэхэд анхаарах ёстой.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18, 22, 23, 24, 25, 26, 27-р бүлгүүдэд орсон тодорхой төрлийн гэмт хэргийн зүйлчлэлийг томьёолсон агуулгад “... **Хууль бусаар... үйлдсэн**” гэсэн утга бүхий хэм хэмжээнүүд олон удаа тусгагдсан байдаг нь бланкет, диспозици бүхий заалтууд цөөнгүй байгаа нь эрүүгийн хуулиас өөр бусад хуулийг хэрэглэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Жишээ нь: “Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэх” (ЭХ13.6), “Сонгуулийг хууль бусаар явуулах” (ЭХ14.9), “Хүний цус, эдэрхтнийг хууль бусаар авах” (ЭХ15.3), “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” (ЭХ18.5), “Хууль бусаар дампууруулах” (ЭХ18.11), “Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах” (ЭХ18.12), “Хууль бусаар иргэний харъяалал олж авах” (ЭХ19.15), “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” (ЭХ24.2), “Хууль бусаар ан агнах” (ЭХ24.5), “Хууль бусаар мод бэлтгэх” (ЭХ24.6), “Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх” (ЭХ24.8), “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах” (ЭХ26.1), “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” (ЭХ27.10) гэх зэргээр эрүүгийн хуульд зүйлчлэгдсэн байдгийг харж болно. “Хууль бус” гэдэг бол хуулийн ямар нэг заалт, хэм хэмжээг биелүүлээгүй буюу зөрчсөн бүхий л тохиолдлыг илэрхийлдэг ойлголт билээ. Энэ нь үгийн шууд утгаараа “Хуулиас гадуур, хуульд захирагдаагүй, хуульд нийцээгүй” гэсэн агуулгыг илэрхийлдэг байна. Тэгвэл одоогийн үйлчилж буй зөрчлийн тухай хуульд ихэнх зөрчлийг “...Хууль зөрчих” гэж зүйлчлэн тогтоожээ. Чухамдаа эрх зүйн хэрэглээний зориулалт, агуулга талаас авч үзвэл “Ойн хууль зөрчих”, ба “Хууль бусаар мод бэлтгэх”, “Ан амьтны хууль зөрчих”, ба “Хууль бусаар ан хийх”, зэрэг нь утгын хувьд адил юм. Гэхдээ эрх зүйн зөрчилдөөн, хийдэл гаргахгүйгээр холбогдох хуулиуд батлагдан гарсныг үгүйсгээгүй болно. Эрүүгийн эрх зүй нь өөрийн зорилгоо хангахын тулд эрүүгийн хуульд тусгайлан заасан гэмт халдлагаас хүн, иргэн, нийгэм, төрийг хамгаалах чиг үүрэгтэй тул түүний хэм хэмжээг нэг мөр ойлгон хэрэглэх шаардлагыг хангахад энэ хуулийг эрх зүйн үндэслэлтэйгээр зөв тайлбарлах, улмаар оновчтойгоор хуульд нийцүүлэн хэрэглэх явдал онцгой ач холбогдолтой. Эрүүгийн хуульд нийцүүлж тайлбарлан хэрэглэх гэдэг нь эрүүгийн хуулийн зорилго, чиг үүрэг, зарчим, агуулгатай тухайн объектыг (хэрэг, тохиолдол, асуудал) сонгон харьцуулж, хуульд үндэслэгдэх болон хууль дээдлэх зарчмын зориулалтын утгыг нээн илрүүлэх процесс юм. Хэдийгээр эрүүгийн хуулийн хэрэглээнд бусад хууль, хуульчилсан акт (хэм хэмжээ

<sup>117</sup> Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлах аргуудыг гарын авлагын 2 дугаар сэдвээс сэргээн дэлгэрүүлж үзнэ үү.

тогтоосон акт) зайлшгүй холбогдох хамаарал гарч ирдэгч гол нь эрүүгийн хуулийн ерөнхий нөхцөл, тусгайлсан заалт, журамд уялдаж тохирсон байх ёстой. Өөрөөр хэлбэл эрүүгийн хуулиас давж, хуулийг төсөөтэй хэрэглэж болохгүй гэсэн үг. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүйг эзэмшихийн тулд юуны өмнө хууль тайлбарлах ерөнхий онолыг судалж эзэмшсэн байхаас гадна эрүүгийн хуулийг тайлбарлах тусгай аргуудыг мэдэх, тухайн эрх зүйн хэрэглээний онцлог болон эрүүгийн эрх зүйн зарчмуудыг танин мэдэх явдал онол практикийн ач холбогдолтой.

### 3.5. Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг харгалзан үзэхийн ач холбогдол

Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх онцлогийг бүрэн гүйцэд танин мэдэхийн тулд эрүүгийн хуульд тусгагдсан гэмт хэрэг, ялын тухай онолын баримтлал, чиг хандлагыг судалж эзэмшсэн байхын дээр эрүүгийн эрх зүйн зорилго, мөн чанарыг нийтлэг жишгийн шалгуураар ойлгож, мэдсэн байх учиртай. Үүний зэрэгцээ эрүүгийн эрх зүйн зарчмуудыг харгалзан үзэж, хэрэглэх явдал зайлшгүй шаардлага болж тавигддаг. Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг яагаад заавал харгалзан үзэх ёстой вэ? Үүнийг дор дурдсан үндэслэлээр тодорхойлж болно. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйн зорилгыг хамгийн зохистойгоор хангахын тулд онол, практикийн үндэслэл бүхий тодорхой үзэл баримтлал боловсруулах зайлшгүй шаардлага тавигдана;
2. Эрүүгийн хуулиар ямар харилцааг зохицуулах, ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох, ямар гэмт хэрэгт ямар төрлийн ялыг ямар нөхцөлөөр оногдуулах вэ? гэдгийг чухамдаа төрийн бодлогоор буюу эрх зүйн тусгайлсан зарчмыг хуульчлах замаар хэрэгжүүлнэ;
3. Эрүүгийн эрх зүйн хэрэглээг субъектийн дур зоргын буюу үзэмжээр ханган тооцох ямар ч боломжгүй бөгөөд зөвхөн хуульд нийцсэн байдлаар эрх зүйн тодорхой зарчмын тусламжтайгаар хэрэглэн тайлбарлах боломжтой;
4. Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь НҮБ-ын гэрээ, конвенц, Үндсэн хуулийн хэм хэмжээгээр урьдчилан тодорхойлогдож баталгаажсан байх тул тэдгээр нь шууд хэрэгжих агуулгыг илэрхийлдэг г.м.

Дээр дурдсан нөхцөлт үндэслэлүүд нь эрүүгийн эрх зүйн зарчмуудыг тухайн хэм хэмжээг хэрэглэн тайлбарлах ажиллагаанд харгалзаж баримтлах шалтгаант хүчин зүйлүүд болно.

Ер нь аливаа салбар эрх зүй бүр өөрийн онцлог бүхий эрх зүйн зарчмуудтай байдаг нь эрх зүйг хэрэглэх ажиллагаанд тодорхой үзэл баримтлал зайлшгүй гарч ирдэгтэй холбоотой. “Хууль зүйн шинжлэх ухааны уламжлалт хандлагаар авч үзвэл “Эрх зүйн зарчим” гэдгийг манай эрүүгийн эрх зүйн эрдэмтэд<sup>118</sup> (Г.Совд, С.Нарангэрэл, С.Жанцан, Ж.Эрдэнэбулган.) “Эрх зүйн харилцаа, хэрэглээ, үйлчилгээнд заавал удирдлага болгох суурь үзэл баримтлал” гэсэн агуулгаар тодорхойлж иржээ. “Эрүүгийн эрх зүйн зарчим” гэдгийг хууль ёс, шударга ёс,

<sup>118</sup> Эрүүгийн эрх зүйн эрдэмтдийн холбогдох бүтээлийг хөтөлбөрийн ном зүйн хэсгээс үзнэ үү.

тэгш эрх, гэм бурууд тооцох зарчмаар хэт хязгаарлан материаллаг эрх зүйн догматик шалгуураар явцууруулж авч үзэх, ингэхдээ хэт ерөнхий утгаар буюу зөвхөн үзэл баримтлал, үзэл санааны агуулгаар ойлгож хэрэглэх нь орчин үед ихэд өрөөсгөл бөгөөд эрх зүйн зарчмын үнэт зүйлс, мөн чанарыг алдагдуулдаг байна.

Эрүүгийн эрх зүйн зарчим нь тухайн эрх зүйн зорилгоос шууд хамааралтайгаас гадна эрүүгийн хэрэглээний арга зүйн чиглэмж, дүрэм төдийгүй төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлох нэг нөхцөл нь болдог.

Барууны орнуудын судлаач, эрдэмтэд үүнийг үзэл баримтлал гэхээсээ илүү практик хэрэглээний болон хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, үнэт зүйлсийн түвшинд, харьцангуй өргөн хүрээнд авч үзэж тайлбарласан байна. Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь дор дурдсан асуудлыг шийдвэрлэхэд арга зүйн гол чиглэмж, баримжаа бүхий чиглүүлэгч болдог. Үүнд:

- Хууль зөрчсөн ямар үйлдэл, үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох болон эс тооцох;
- Гэмт хэргийн төрөл, ангилал, зүйлчлэлийг хэрхэн тогтоож, ямар нөхцөлөөр хуульчлах;
- Эрүүгийн хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулахдаа хууль зүйн техникийн ямар арга, стандартыг удирдлага болгох;
- Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хэрхэн тодорхойлох;
- Эрүүгийн ялын болон ялын бус хариуцлагыг яаж тооцох;
- Эрүүгийн эрх зүйн сурвалжуудын хамаарал, уялдааг хангахад ямар нөхцөлийг харгалзах г.м.

Сүүлийн үеийн эрүүгийн эрх зүйн ном, сурах бичгүүдээс үзэхэд эрүүгийн эрх зүйн зарчмууд нь эрүүгийн эрх зүйн зорилго, чиг үүргийг тодорхойлон чиглүүлж буй хууль зүйн чиглэмж, баримтлал төдийгүй хуульчлагдсан хэм хэмжээ, стандарт, дүрмүүд гэж тодорхойлж болно.<sup>119</sup>

Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд зөвхөн харгалзах үндэслэл төдийгүй заавал баримтлах удирдамж, хэм хэмжээ болдгийг анхаарах ёстой. “...Аливаа зарчим бол практик үйл ажиллагаанд баримтлах шаардлагатай, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, практикаар шалгагдсан тэргүүний үзэл санаа”<sup>120</sup> мөн тул эрүүгийн эрх зүйн хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх чухал хөшүүрэг болно. Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд харгалзан үзэх нь онол, танин мэдэхүйн төдийгүй практик хэрэглээний ач холбогдолтой. Юуны өмнө эрүүгийн хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх ухамсар, соёлыг төлөвшүүлэхэд чухал түлхэц болно. Үүний хамт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялыг хуулийн дагуу шударгаар оногдуулах нөхцөлийг бүрдүүлэх хүчин зүйл болно. Эдгээр зармуудыг тууштай хангаж, бодитойгоор хэрэгжүүлж чадвал хууль ёс бэхжиж, хувь

<sup>119</sup> “Эрх зүй” сэтгүүл, 2013№1(23), 70-71 дэх тал.

<sup>120</sup> С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (1-р боть), УБ, 2009, 25-р тал.

хүн, иргэн байгууллага, төрийн нийгмийн хариуцлага дээшилж, дэг журам сайжирна. Эрүүгийн эрх зүйн зарчмууд үйлчлэх хэрэгжсэнээр эрүүгийн эрх зүйн зорилго бүрэн хангагдаж, эрүүгийн хуулийн зохистой орчин бүрэлдэнэ. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх ажиллагааг эрүүгийн эрх зарчмуудгүйгээр төсөөлөхийн аргагүй. Дээр дурдсан нөхцөл, ач холбогдол нь эрүүгийн эрх зүйн зарчмуудыг хэрхэн зохистой, зөв хэрэглэхээс шууд хамаарна. Энэхүү зарчмуудыг ухаалгаар, бодитойгоор хэрэгжүүлэх нь зөвхөн практик туршлага, ур чадвараас гадна эрүүгийн эрх зүйн онолын мэдлэг, сэтгэлгээний түвшин, хөгжлөөс ихээхэн хамаарна. Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуульд бататган тодорхойлсон хуульд үндэслэгдэх, шударга ёсны болон гэм буруугийн зарчим, тэгш эрхийн болон хүнлэг энэрэнгүй ёсны зарчим зэрэг эрх зүйн үнэт зүйлс болсон нийтлэг суурь зарчмуудыг тухайн эх сурвалжид тодорхойлсон утга, агуулгаар нь ойлгож, хэрэглэх явдал онцгой ач холбогдолтой.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**  
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУД  
ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА, ХУУЛЬ  
ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХДЭЭ  
ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ

## БҮЛЭГ 4. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУД ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА, ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХДЭЭ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ

### 4.1. Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмууд, тэдгээрийг тодорхойлох шалгуур

Эрх зүйн зарчим нь Үндсэн хуульт ёсны салшгүй үнэт зүйлс төдийгүй эрх зүйт төрийн агуулгыг тодорхойлох чухал хүчин зүйл болдог. Үндсэн Хуульд тусгагдаж, Олон улсын гэрээнд томъёологдсон байдгаараа эрх зүйн нийтлэг зарчмууд өөрийн онцлог, мөн чанар бүхий бие даасан байр суурь, үүрэг рольтой байх ажээ. Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмууд нь эрүүгийн эрх зүйн тусгай зарчмыг тодорхойлох суурь нөхцөл нь болно. Ихэнх улс оронд эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг зөвхөн Үндсэн Хуульдаа бэхжүүлж тогтоосон бол зарим оронд Үндсэн хуульд заахаас гадна эрүүгийн хуульдаа давхар хуульчилсан байх нь бий. Харьцуулсан эрүүгийн эрх зүйн судалгаанаас үзэхэд аль ч улс орны эрүүгийн эрх зүйн нийтлэг суурь зарчмуудад:

1. Хуульд үндэслэгдэх, хууль ёсны зарчим;
2. Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим;
3. Шударга, бодит байдлын зарчим;
4. Гэм буруугийн зарчим;
5. Хүнлэг энэрэнгүй ёсны зарчим;
6. Эрүүгийн хариуцлага зайлшгүй байх зарчим;
7. Гэм буруутай этгээд өөрөө хариуцлага хүлээх зарчим;
8. Эргэлзээтэй үед яллагдагчийн талд ашигтайгаар шийдвэрлэх зарчим;
9. Эрүүгийн эрх зүйг эцсийн арга зам болгох зарчим;
10. Эрүүгийн хууль цаг хугацаа, нутаг дэвсгэрт үйлчлэх зарчим г.м.

Дээр дурдсан нийтлэг зарчмуудаас гадна ялыг бусдад халдаан хэрэглэхгүй байх, гэмт хэрэг ба ялыг зөвхөн шүүх шийдвэрлэх, шударга шүүхийг хүндэтгэх, шүүхээр нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох, хувь хүнд нь биш гэмт хэрэгт нь ял оноох зэрэг цөөнгүй зарчмууд тухайн ангилалд хамааралтайг дурдаж болно. Эрүүгийн эрх зүйн нийтлэг суурь зарчмуудыг хууль зүйн эх сурвалжийн байдлаар нь дараах шалгуурт хуваана.

1. Олон улсын эрх зүйн шалгуур
2. Үндсэн хуулийн шалгуур
3. Эрүүгийн хуулийн шалгуур.

**Олон улсын эрх зүйн шалгуур нь** тухайн улсын нэгдэн орж, соёрхож баталсан Олон улсын гэрээ, конвенцод эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмыг тодорхойлсон байх нөхцөлийг илэрхийлнэ. Ж ишээ нь: Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 14-р зүйлийн 2-т: “Хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох ...”, 26-р зүйлд: “Бүх хүн хуулийн өмнө тэгш ,хуулиар тэгш хамгаалуулах ...”. 14-р зүйлийн 1-д: “Бүх хүн шүүхийн өмнө тэгш эрхтэй ...”, 9-р зүйлийн 1-д: “Хуульд заасан үндэслэл , журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч



болохгүй ..." гэж заажээ. Түүнчлэн хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглох тухай (7.1) дурджээ.

**Үндсэн хуулийн шалгуур нь** Үндсэнд хуульд тухайн зарчмуудыг хуульчлан тунхаглаж, баталгаажуулсан байх нөхцөлийг тодорхойлно. Жишээ нь: Монгол Улсын Үндсэн Хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т: "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим байна" гэж заасан. Мөн Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэгт "... Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэжээ. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт "Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүн, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэж заасан билээ. Үндсэн хууль нь аливаа улсын төрийн гол хууль тул түүнд тусгагдсан эрх зүйн үндэслэл, зарчмууд нь эрүүгийн эрх зүйн хувьд эрх зүйн суурь зарчмууд болно.

**Эрүүгийн хуулийн шалгуур нь** Эрүүгийн хуулийн ерөнхий ангид тусгайлан тодорхойлж, томъёолсон байх шаардлагаар нөхцөлдсөн байна.

Жишээ нь Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд "Хууль ёсны зарим", 1.4 дүгээр зүйлд "Гэм буруугийн зарчим" зэргийг тус тусад нь бие даасан байдлаар зүйлчлэн тэдгээрийн агуулгыг дэлгэрүүлж томъёолжээ. "Хууль ёсны зарчим"-д түүний ялгагдах мөн чанарыг эрх зүйн эх сурвалжийн үндэслэлд тулгуурлан тодорхойлсон бол "шударга ёсны зарчим"-ыг харьцангуй өргөн хүрээнд авч үзэж, "тэгш эрх", "гэмт хэрэг үйлдсэн этгээд зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээх", "эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэхгүй байх" зэрэг тус тусдаа байх зарчмыг нэгтгэн илэрхийлжээ. Түүнчлэн "нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах", "хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх" зэрэг зарим онцлог зарчмыг "шударга ёсны зарчим"-ын агуулгад багтаан хуульчилсан байна. Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.2 дахь хэсэгт "Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй" гэж заасан нь чухал ач холбогдолтой бөгөөд "шударга ёсны болон хүнлэг энэрэнгүй ёсны зарчим"-тай салшгүй холбоотой.

Эрүүгийн хуульд заасан нийтлэг зарчмууд нь Үндсэн хуулийн зарчим, Эрүүгийн хуулийн зорилготой уялдан холбогдож, харилцан хамааралтай байна.

Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмууд нь тухайн нийгмийн зорилго, эрх ашигт нийцэж, төрийн бодлого, үзэл баримтлалтай уялдсан байх ёстой. Энэ нь ард түмний язгуур ашиг сонирхол, хүсэл зоригийн хуульчлагдсан илэрхийлэл болж үйлчилнэ. Эдгээр нийтлэг, суурь зарчмуудыг гэмт хэргийн зүйлчлэх, ял оногдуулах болон ялаас чөлөөлөх зэрэг эрүүгийн эрх зүйн хэрэглээг хангах, түүнчлэн түүний хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гол баримтлал болгон хэрэглэнэ. Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмын эрх

зүй, нийгмийн шалгуураас гадна ёс суртахуун, соёлын шалгуурыг харгалзах нь чухал ач холбогдолтой. Энэ шалгуур нь тухайн нийтлэг зарчмууд ёс зүйн үнэт зүйлсийг хамгаалж чадсан эсэх, нийгмийн ёс суртахууны шаардлагад нийцсэн эсэхтэй холбоотой.

Нийтлэг зарчмууд нь эрүүгийн эрх зүйн зорилго, чиг үүрэг агуулгад яв цав нийцэж, эрх зүйн үндэслэлтэйгээр хуульчлагдсан байхаас гадна тэдгээрийг зөвхөн үзэл баримтлал төдийгөөр ойлгон хэрэглэх ёсгүй. Гагцхүү хуульчлагдсан хэм хэмжээ гэсэн агуулгаар ойлгож, шүүхийн практикт бүтээлчээр, идэвхтэй хэрэглэж хэвшүүлэх шаардлагатай. Ялангуяа эрүүгийн хэргийн шийтгэх болон цагаатгах тогтоолд ишлэл болгон дурдаж, тэдгээрийн агуулга, үндэслэлийг хэрхэн хангасан тухай заавал дурдаж байх ёстой юм. Орчин үед эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг эрх зүйн хэм хэмжээ гэж үзэж, шүүхийн практикт хэрэглэх хандлага бий болж байгаагийн дээр тэдгээрийн олон улсын болон нийгэм-эрх зүйн баталгаа улам бүр бэхжиж, эрх зүйн хамгаалах чиг үүргийг хангахад мэдэгдэхүйц нөлөөлөх болсон нь анхаарал татаж байна. Эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг таньж мэдэх нь практик хэрэглээний ач холбогдолтой бөгөөд түүний шалгуур нь хууль зүйн төдийгүй нийгэм-эрх зүйн агуулгаар баяжиж боловсронгуй болж хөгжиж байна.

#### 4.2. Эрүүгийн эрх зүйн зарчмын хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол

Эрүүгийн эрх зүйн зарчмыг зориулалт, хэрэглээний онцлог талаас нь нийтлэг ба тусгай зарчим гэж хоёр ангилан авч үздэг. Нийтлэг зарчим нь эрүүгийн эрх зүйн бүхий л асуудлыг шийдвэрлэхэд түгээмэл байдлаар хэрэглэгддэг бол тусгай зарчим нь тухайн тодорхой асуудлыг шийдэхэд хэрэглэгдэнэ. Энэ нь зарим талаар нийтлэг зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч ирэх нь бий. Жишээ нь: Хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх, хэрэглэх явцад хуулийг буцаан хэрэглэх явдал гардгаас гадна хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх шаардлага тавигддаг. Хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх нөхцөлийг хангахын тулд “*Lex certa*” зарчим буюу хууль нь заалт, хэм хэмжээний хувьд маш тодорхой шууд хэрэглэх боломжтой байх ёстой. Түүнчлэн эрүүгийн хууль үйлчлэх нөхцөл, түүний хэрэглээний онцлогийг тодорхойлсон тусгай зарчмууд байдаг. Жишээ нь: “*Lex specialist legi generali*” зарчим нь тусгай хуульд ерөнхийгөөс давуу хүчинтэй, “*Lex posterior derogat prior*” зарчим нь сүүлд гарсан хууль нь өмнөх хуулиасаа давуу хүчинтэй, “*Lex superior derogat legi interior*” зарчим нь дээд хүчинтэй хууль нь дагалдан гарсан хэм хэмжээнээс давуу хүчинтэй гэсэн утгыг илэрхийлнэ. Түүнчлэн Мерия-Левассарын зарчим ёсоор (**Merlia levessouri**) гэмт хэрэг үйлдэхээс өмнө батлагдсан хуулиар хэн ч эрүүгийн хариуцлагад татагдах ёсгүй гэсэн агуулгатай ба “шинийг дэмжих” гэсэн санааг илтгэнэ. Түүнчлэн “**Non bis idem**” буюу нэг гэмт хэрэгт нэг л удаа ял оногдуулах зарчмыг энд дурдаж болно. Герман зэрэг Баруун Европын цөөнгүй оронд “**Deliquere non potest**” буюу “Хамтарсан субъект буюу хуулийн этгээд гэмт хэрэгтэн байж болохгүй” гэсэн зарчим үйлчилдэг.

Эрүүгийн эрх зүйн нийтлэг болон тусгай зарчмууд нь хоорондоо уялдаж зохицсон байхын дээр хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд дараах үүрэг, ач холбогдолтой байдаг. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх үйл явцын зорилго, агуулгыг тодорхойлох үзэл баримтлал болж үйлчилнэ.
2. Эрүүгийн хуулийг нэгэн мөр зөв хэрэглэх нөхцөл, шаардлагыг хангах чухал хүчин зүйл болно.
3. Эрүүгийн эрх зүйн хамгаалах, урьдчилан сэргийлэх ба цээрлүүлэх, нийгэмшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд удирдлага болгох гол чиглэмж тул түүнийг хангаснаар хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн зорилго, агуулгад нийцэж, эрх зүйн үндэслэлтэйгээр хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
4. Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь хууль ёсны болон шударга ёсны шаардлагад нийцэх ёстой учраас эрүүгийн эрх зүйн зарчмууд нь нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэнэ.
5. Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах, түүнийг үндэслэлтэйгээр зөв хэрэглэх, тайлбарлахад чиглэгдсэн шүүхийн практикийг боловсронгуй болгон хөгжүүлэхэд эдгээр зарчмууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.
6. Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь хууль хэрэглэх ухамсар, соёлыг төлөвшүүлэх, хуулийг тайлбарлах мэдлэг, ур чадвар эзэмшихэд соён гэгээрүүлэх үүрэг гүйцэтгэнэ.
7. Эрүүгийн эрх зүйн зарчмуудын тусламжтайгаар эрүүгийн эрх зүйн хэрэглээний орчин бодитойгоор бий болж, хууль хэрэглэн тайлбарлах үйл явц нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хэрэгжинэ.
8. Хууль тайлбарлах, хууль хэрэглэх ажиллагаанд эрүүгийн эрх зүйн зарчмуудыг идэвхтэй, бүтээлчээр тусган хэрэгжүүлснээр хуульч, шүүгчийн мэргэжлийн ухамсар, соёл дээшилж, нийтлэг жишгийн шалгуур буюу орчин үеийн шаардлагад нийцэхүйц түвшинд үнэлэгдэнэ.
9. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад тухайн дүгнэлт шийдлийг гаргах үед эргэлзээтэй буюу хүндрэлтэй асуудал үүсвэл чухамхүү эрүүгийн эрх зүйн нийтлэг ба тусгай зарчмуудыг ашиглан дотоод итгэл үнэмшлээр хандах ёстой бөгөөд ингэснээр тэдгээр зарчмууд арга зүйн үүрэгтэйгээр нөлөөлнө.

Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг үзэл баримтлал, хэм хэмжээ гэж ойлгохын зэрэгцээ орчин үед тэдгээрийг эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд үнэлэн тооцож хэрэглэх болсон нь анхаарал татаж байна. Эдгээр зарчмууд нь хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд хэрэглэгдэх төдийгөөр хязгаарлагдахгүй. Эрүүгийн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх чухал хүчин зүйл юм. Учир нь тэдгээр зарчмуудыг тухайн төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод зайлшгүй харгалзан үздэг билээ. Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг эрүүгийн болон эрүүгийн процессын хуульд нийтлэг жишгийн агуулгаар нь хоорондын уялдаа холбоог нь хангаж, үнэн зөв томъёолж тодорхойлох нь чухал. Зарим тохиолдолд хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг олгосон

нөхцөлийг тэдгээр зарчмуудын агуулгад тусгах нь ойлгомжгүй, тодорхой бус байдлыг бий болгох төдийгүй эрүүгийн эрх зүйн мөн чанарт харшилна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 5-д: “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно.” гэж заасан нь зарим талаар судлаачдын дунд шүүмжлэл дагуулдаг. Энэ нь хууль ёсны зарчмын мөн чанар, агуулгад төдийлөн нийцэхгүйн дээр “Lex certa” зарчмын үндэслэлээр бол эрүүгийн хуулийн зарим заалт, нэр томьёог хуулийн агуулгаас өөрөөр тайлбарлах боломж гарч болохыг үгүйсгэхгүй юм. Цаашдаа эрүүгийн эрх зүйн зарчмуудыг шүүн таслах ажиллагаанд идэвхтэй хэрэглэж хэвшүүлэхээс гадна шүүхийн шийдвэр бүрт ишлэл авч үндэслэгдэх ёстой билээ.

#### 4.3. Хууль ёсны зарчим

Энэ зарчим нь эрүүгийн эрх зүйн нэн чухал суурь зарчмын нэг бөгөөд анх латины **“Nullum crimine sine lege, nulla poena sine lege”** буюу *“Хуульд заагаагүй бол гэмт хэрэг ч биш, ял ч биш”* гэсэн томьёоллын агуулгаас урган гарсан байдаг. Өөрөөр хэлбэл ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох, ямар гэмт хэрэгт ямар ял оноохыг чухамхүү хуульд юу гэж заасан байна, тэрхүү хуульчилсан нөхцөлөөр нь ойлгох ёстой гэсэн үг. Угтаа бол гэмт хэрэг, ял, тэдгээрийн нөхцөл, хэмжээ зэрэг нь хуульд тусгагдсан байх утгыг илэрхийлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд хууль ёсны зарчмын эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д: “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.” гэж заажээ. “...Нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, түүнд ял оногдуулах, ял эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан нэгдсэн Эрүүгийн хуулиар тогтоох шаардлагыг хангахад энэ зарчим чиглэгдэнэ. Энэ нь гэмт хэрэг ялын тухай асуудал Эрүүгийн хуулиас өөр салбар хуулиар зохицуулагдах ёсгүй гэсэн үг”.<sup>121</sup> “Хууль ёсны зарчим нь Эрүүгийн хуулийг төрийн дарангуйлал болохоос сэргийлж, хувь хүний жам ёсны эрхийг хамгаалах”<sup>122</sup> ба хуулийн зорилго, зарчим, заалт, хэм хэмжээг нэгэн мөр гуйвалтгүй даган мөрдөж, хуульд бүрэн захирагдах агуулгыг илэрхийлнэ. Энэ нь эрүүгийн эрх зүйн анхдагч тулгуур зарчим болохын хувьд бусад зарчмуудын агуулгыг тодорхойлж үндэслэсэн байдаг. Анх 1801 онд А.Фейрбахын дэвшүүлсэн үндэслэл буюу “Хуульд заагаагүй бол гэмт хэрэг биш, гэмт хэрэг биш бол ялгүй.” гэсэн томьёолол нь анх 1776 оны АНУ-ын Мэриланд муж улсын Үндсэн хууль болон Францын 1789 оны Хүний болон иргэний эрхийн тунхаглалд тусгалаа олжээ.

1789 оны Францын Хүний болон иргэний эрхийн тунхаглалын 5-р зүйлд: “Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө. Нийгэмд хохирол учруулсан,

<sup>121</sup> С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. 1-р боть. УБ., 2009. 28-р тал

<sup>122</sup> Т.Золбоо. Сургалтын Эрүүгийн хууль. УБ., 2017. 18-р тал

нийгэмд аюултай үйлдлийг хуулиар хориглоно. Хуульд заагаагүй буюу хуулиар зохицуулаагүй ямар ч үйлдэлд хэнийг ч албадан хүч хэрэглэж болохгүй.” гэж заажээ. Мөн тунхаглалын 6-р зүйлд: “Хууль бол бүх нийтийн хүсэл зоригийн илэрхийлэл. Хохирсон ба хохироосон, яллагдсан ба ялласан аль ч этгээдийн хувьд, хэн бүхний хувьд хууль адил үйлчлэх ёстой”. 8-р зүйлд: “Хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн нь хуулийн дагуу нотлогдож ял оноох нь зайлшгүй гэж шүүх тогтоосон үед л ял хууль ёсны бөгөөд гарцаагүй байх ёстой”<sup>123</sup> гэж заасан нь түүхэнд үлдсэн байна. Одоогоос 220 шахам жилийн өмнө хууль ёсны зарчмыг эрх зүйн үндэслэлийн хэмжээнд цогц байдлаар томъёолж чадсан нь өнөө хэр ач холбогдлоо алдаагүй байна.

Дэлхийн бүх улс орон хуультай гэж тооцвол хууль ёсны зарчим нь тухайн орны төрийн дэглэм, нийгмийн харилцааны хөгжил, онцлогоос үл хамаарч хууль заавал биелэгдэх нөхцөл, баталгааг бүрдүүлсэн байх ажээ.

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хууль ёсны зарчмын 4 үндсэн агуулгыг тодорхойлж авч үздэг. Үүнд:

**I. Lex certa:** *Хуулийн заалт, хэм хэмжээ тодорхой байх зарчим*

Эрүүгийн эрх зүй нь зорилго, мөн чанарын хувьд гэмт хэрэг, ялын институцийг тодорхойлж зохицуулсан, харьцангуй императив агуулгыг тусгасан байдгаараа түүний бүх заалт, нөхцөл, журмууд нь бүрэн ойлгомжтой, маш тодорхой байх ёстой. Тодорхой байх гэдэг нь:

- а) Шууд хэрэглэх боломжтой байх;
- б) Хоёрдмол салаа утгагүй ойлгомжтой байх;
- в) Маргаангүй байх;
- г) Оновчтой байх зэрэг нөхцөлийг хангасан байхыг хэлнэ.

Жирийн иргэний хувьд ямар үйлдэл нь хуулиар хориотой, ямар үйлдэл нь гэмт хэрэг болох, ямар гэмт хэрэгт ямар үндэслэлээр ял оноох эсэхийг Эрүүгийн хуулийг уншаад л шууд ойлгогдож байх учиртай. Хуульч, шүүгчийн хувьд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй удирдлага болгох Эрүүгийн хуулийн зарчим, заалт, хэм хэмжээнүүд нь оновчтой, шууд хэрэглэх бүрэн боломжтой байх ёстой. Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинж нь маш дэлгэрэнгүй, тодорхой, оновчтойгоор томъёологдож хуульчлагдсан байх шаардлага тавигддаг. Хөгжингүй орнуудын эрүүгийн эрх зүйн жишгээр гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг харьцангуй өргөн хүрээнд тодорхойлж ирсэн байдаг.<sup>124</sup>

**II. Lex scripta:** *Хууль заавал бичигдсэн байх зарчим*

Энэ нь албан ёсны бичиг баримтын хэлбэрээр баталгаажиж, хуульчлагдсан байх утгыг илэрхийлнэ. Аливаа гэмт хэрэг, ялын асуудал нь зөвхөн Эрүүгийн хууль гэсэн бичмэл хуулиар зохицуулагдсан байна. Өөрөөр хэлбэл заншлын эрх

<sup>123</sup> Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011. 33-р тал

<sup>124</sup> Э.Хильгендорф, Д.Чандалдулам. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2015. 22-р тал

зүй буюу бичмэл бус хэм хэмжээг дагаж мөрдөхгүй гэсэн үг. Аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцох, ял оноох эсэхийг тогтоохдоо заншлын болон жам ёсны эрх зүй үйлчлэхгүй, тэдгээрээс ангид байх агуулгыг тусгана. "...Харин зарим нэг тодорхой хэргийн тохиолдолд гэмт хэргийн субъектийн сэдэлт, зорилго зэргийг эрүүгийн эрх зүйд заншлын эрх зүйгээр тайлбарлах..."<sup>125</sup> хандлага байдаг. Ялангуяа эрүүгийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг "хохилогчийн эрхийг дээрдүүлэх", "нотлох баримтууд эргэлзээтэй бол яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх", "хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг үнэлэн харгалзах", "дотоод итгэлээр үнэлэх" зэрэг зохицуулалт, хэрэглээнд заншлын эрх зүйн зарчим хэрэглэгдэх нь бий.

### III. *Lex stricta*: Хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглох зарчим

Эрүүгийн эрх зүйд хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг хориглодог нь тухайн салбарын эрх зүйн хэм хэмжээнүүд маш тодорхой, хатуу заалттай гарч, шууд утгаар тайлбарлаж хэрэгжүүлэх онцлогтой холбоотой. "Хуулийг төсөөтэй хэрэглэнэ гэдэг нь хуульд байхгүй зүйлийг нөхөн гаргах, цоорхойг нөхөх, хуульд бичигдсэн өгүүлбэрийг цааш задлан шинээр утга бий болгохыг хэлнэ"<sup>126</sup>. Энэ утгаар нь авч үзвэл хуулийн заалт, хэм хэмжээг түүний үндсэн агуулгаас өөрөөр хэрэглэх тухай ойлголт юм. Гэхдээ тухайн хуулийн аль нэг заалт, хэм хэмжээг шууд хэрэглэх боломж хязгаарлагдмал, тодорхой бус байгаа нөхцөлд түүнтэй ижил утгатай хэм хэмжээг зэрэгцүүлэн адилтган жишиж хэрэглэх гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ хандлага иргэн, гэрээний эрх зүйн хэрэглээнд тодорхой тусгагдаж илэрсэн байдаг. Хуулийг төсөөтэй хэрэглэхийг хууль тайлбарлахтай адилтган, ижил утгатай мэтээр ойлгож болохгүй. Германы эрүүгийн эрх зүйн профессор Э.Хильгендорф, докторант, судлаач Д.Чанцалдулам нарын бичсэнчлэн "Хуулийг тайлбарлана гэдэг нь хуулийн утга учрыг тодотгон задлах ба шаардлагатай тохиолдолд цаг үеийн үзэл, хэрэгцээнд тохируулан ойлгон тодруулахыг хэлнэ."<sup>127</sup> Сүүлийн үед барууны эрүүгийн эрх зүйн хуульч, судлаачид<sup>128</sup> яллагдагчийн хэргийн нөхцөлийг хүндрүүлж буй хэм хэмжээг хатуу заалтын утгаар төсөөтэй хэрэглэхийг хориглох боловч, хөнгөрүүлэх заалтын нөхцөл, утгыг харьцангуйн онолын зарчмаар хязгаарлагдмал хүрээнд төсөөтэй хэрэглэх явдлыг зөвшөөрөх хандлагатай байна. Гэмт хэргийн зүйлчлэл, бүрэлдэхүүний хувьд хатуу заалт, тогтсон зарчмын дагуу шууд утгаар хэрэглэх ба энэ тохиолдолд төсөөтэй хэрэглэхийг хориглоно. Түүнчлэн эрүүгийн эрх зүйн тодорхой асуудлыг бусад салбар эрх зүйн орчин, харилцаанд хамаарах байдлаар авч үзэж болохгүйн дээр адил төстэй гэмт хэргүүд болон эрх зүйн зөрчлүүдийг хооронд нь адилтган төсөөлүүлэх байдлаар хэрэглэж болохгүй гэсэн үг юм.

<sup>125</sup> Т.Золбоо. Гэмт хэргийн бүтээц. УБ., 2016. 27-р тал. Энэ номноос тухайн зарчмын жишээг дэлгэрүүлж үзнэ үү.

<sup>126</sup> Э.Хильгендорф, Д.Чанцалдулам. Дурдсан бүтээл. 23-р тал

<sup>127</sup> Мөн тэнд.

<sup>128</sup> "Criminal Law and its process" journal. 2015. №3

#### **IV. Lex praeviva: Хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим**

Энэ зарчим нь шинээр батлагдсан эрүүгийн хуулийн үйлчлэх чадварын онцлогтой холбогдсон зарчим юм. Онолын хувьд зөвхөн маш хязгаарлагдмал хүрээнд ялыг хөнгөрүүлэх, гэмт буруутай этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх онцгой нөхцөл бий болсныг харгалзах шаардлагатай үед л эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг үгүйсгэхгүй. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1-д: “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.” гэж заажээ. Харин уг хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2-д: “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.” гэжээ. Энэ зарчимд цаг хугацааны асуудал зайлшгүй тооцох зүйлийн нэг мөн бөгөөд хугацааг тооцохдоо тухайн гэмт хэргийн үйлдэл эхэлсэн цаг үеийг голлох шалгуур болгон авч үздэг. Өөрөөр хэлбэл тухайн нөхцөлд үйлдэгдсэн гэмт хэрэг нь шинэ эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө эхэлсэн байхыг шаардана. Ер нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль тогтоомж бол гэмт хэргийг үйлдсэн цаг мөчид хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль байх нь зайлшгүй.

Хууль ёсны зарчим нь гэмт хэрэг, ялын холбогдол бүхий ямар ч асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө хуулийн заалт, хэм хэмжээнд үндэслэгдэх, түүнийг гуйвалтгүй сахих, хуульд хатуу чанд захирагдах шаардлагыг хангаснаар хэрэгжинэ. Эрүүгийн эрх зүйн хэрэглээ нь хууль ёсны зарчмаас ангид байх ямар ч боломжгүй. Монгол Улсын Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжиж эхлээд удаагүй байгаа энэ үед тухайн хуулийн заалт, хэм хэмжээ, утга, агуулгыг нь хууль тогтоогчийн үзэл баримтлал, хуулийн зорилго, агуулгад нийцүүлж гүнзгийрүүлж судлах, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр танин мэдэж, уг хуулийг хэрэглэх арга зүйг эзэмших нь хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болно.

#### **4.4. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим**

Гэм буруугийн зарчим нь эрүүгийн эрх зүйн нийтлэг суурь зарчмуудын нэг яах аргагүй мөн билээ. Гэм буруу нь тухайн хүний үйлдэлд гэмт хэргийн хамаарал байгааг харуулах эрүүгийн хэргийн онцлох нөхцөл байдал юм. Гэм буруу нь ял оногдуулах эсэхийн гол шалгуур төдийгүй гэмт хэргийн нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно. “Nulla poena sine culpa” буюу “Гэм буруугүй бол ялгүй” гэсэн сонгодог томъёолол нь гэм буруугийн зарчмын танин мэдэхүйн үндэс болдог. Гэмт хэрэг бүр тодорхой гэм буруутайгаар үйлдэгдсэн байх учиртай. Эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг л гэмт хэрэгт тооцно. Эртний Ромын эрх зүйд “Causa a nullo praestantur” буюу “Тохиолдлын төлөө хэнд ч хариуцлага хүлээлгэж болохгүй” гэсэн мөрдлөгийг баримталдаг байсан нь энэ зарчмын түүхэн үндэслэл болдог. Гэм буруугийн

зарчим нь нэг талаас гэм буруутай нь шүүхээр нотлогдвол эрүүгийн хариуцлага хүлээх, нөгөө талаас гэм буруугүй нь шүүхээр тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх агуулгыг илэрхийлдэг. Түүнчлэн "... Хуулиар тогтоосон журмын дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй болон гэм буруугүйгээр Эрүүгийн хуульд заасан хор уршиг учруулсныг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй."<sup>129</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийг "Гэм буруугийн зарчим" гэж нэрлэн хуульчилжээ. Дээрх хуулийн 1.4 дүгээр зүйлийн 3-д: "Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох нийгэмд аюултай хор уршигийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ"<sup>130</sup> гэж заажээ. Мөн зүйлийн 1.4.4-д: "Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй." гэж заасан байна. Эрүүгийн хуулийн 1.4.1 дүгээр зүйлд заасан "Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэсэн хэм хэмжээ нь уг зарчмын гол агуулга бөгөөд онолын үндэслэлийн хувьд шүүн таслах ажиллагааны үр дүнд гэм буруутай нь бүрэн нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоолд "Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай" гэж дурдагдсан тохиолдолд тухайн зарчим үйлчлэх учиртай юм.

Германы эрүүгийн эрх зүйд "Хувь хүн л гэм буруутай байх чадвартай, хуулийн этгээд болон аж ахуйн нэгжүүдийн хувьд гэм буруутай үйлдэл хийнэ гэсэн ойлголт байхгүй." гэсэн үзэл баримтлал давамгайлдаг. Манай Эрүүгийн хуулийн 1.3.4 дүгээр зүйл, 9.1.1; 9.1.2 дугаар зүйлүүдэд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл, үндэслэлийг тогтоосон билээ.

Шүүхээр нотлогдоогүй ямар ч тохиолдолд тухайн хүнтэй гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай мэтээр харьцаж, эрүүдэн шүүлтийн шинжтэй дарамт шахалт үзүүлж болохгүй юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.8.1 дүгээр зүйлд "бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх" гэмт хэргийг зүйлчилсэн. Харин гэм буруугүйгээр бусдад гэм хор учруулсан байвал эрүүгийн хариуцлага асуудал яригдахгүй. Гэм буруугийн зарчмыг онолын үндэслэлтэйгээр танин мэдэхийн тулд "Гэмт санааны онол" болон Гэм буруугийн онолыг сайтар судалж эзэмшихээс гадна гэм буруугийн презумпци, гэм бурууг хүлгэлцэх зэрэг ойлголтын талаар тодорхой төсөөлөлтэй байх ёстой. Шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагааг бүх талаар бүрэн бодитойгоор явуулсан боловч цугларсан нотлох баримт, нотолгооны баримт сэлтүүд нь тухайн хүнийг гэм буруутай гэж үзэх хангалттай үндэслэл болж чадахгүй бол тухайн сэжигтэн яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх жишиг, практик байдаг. Энэ нь эрүүгийн эрх зүй, эрүүгийн процесст харгалзан үзэх ёстой нэг зарчим болж тогтсон байдаг. Энэхүү жишиг, зарчимтай холбоотойгоор гэм буруугийн презумпцийн асуудал яригддаг ба гэм буруугүйд тооцох

<sup>129</sup> Г.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй. Гарын авлага. /"Шүүх эрх зүйн шинэчлэл" төсөл/. УБ., 2007. 48-р тал

<sup>130</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. /Шинэчилсэн найруулга/. УБ., 2017



боломжит нөхцөлийн тухай харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн хандлага юм. Гэм буруутай байх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх гол үндэслэл төдийгүй, гэмт хэргийн нэг шалгуур шинж нь болно. “Гэм буруугийн зарчмыг шууд утгаар нь төсөөлөхөд “гэмт хэрэг үйлдсэн хүн”, “гэм буруутай хүн” гэсэн хэллэг хэрэглэхийг үгүйсгэдэггүй.”<sup>131</sup> Зарим судлаачид “Гэм буруугүйн зарчим” гэсэн нэр томъёог дэвшүүлж хэрэглэсэн байдаг.<sup>132</sup> Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх нь шүүхээр нотлогдох гэдэг нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр гэр буруугийн асуудлыг мэтгэлцээний үндсэн дээр хуулийн дагуу шударгаар шүүн хэлэлцээний үндсэн дээр шүүх хуралдаанд хянан шийдвэрлэж, шүүхийн тогтоолоор гэм буруутайг нь тогтоохыг хэлнэ. Гэм буруугийн ойлголт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг үндсэн элемент мөн боловч барууны орнуудын эрүүгийн эрх зүйн жишгээс үзэхэд энэ нь гэмт санааны ухагдахуунаас ялгаатай. Манай уламжлалт эрүүгийн эрх зүйн онолын сэтгэлгээнд гэм бурууг субъектив талын элемент гэж ойлгон хэрэглэж ирсэн. Гэтэл Герман, Австри, Швед, Норвеги, Солонгос, Япон, Итали зэрэг Баруун Европын ихэнх орон, эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсад гэм буруу нь субъектив талын шинж биш, харин бие даасан шалгуур бүхий бүрэлдэхүүний элемент болдог байна.

Орчин үед гэм буруугийн хүлгэлцэх гэдгийг шүүхийн өмнөх шатанд гэм буруу нь тогтоогдсон боловч шүүхийн шийтгэх тогтоол хараахан гараагүй байдлыг холбон ойлгох хандлага бий. НҮБ-аас 1966 онд баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 14-р зүйлийн 2-д: “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.” гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-д: “...Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэж заажээ. Энэ бүхнээс үзэхэд гэм буруугийн зарчим нь зөвхөн хуульд заасан нөхцөл, журмын дагуу шүүхийн тогтоолоор нотлогдсон нөхцөлд үйлчлэн хэрэгжих боломжтой. Яллах баримт сэлтийг үндэслэлгүйгээр хэт үнэлэх, гэм бурууг урьдчилан тогтоох, цагаатгах нотлох баримтыг үгүйсгэх зэрэг нь энэ зарчмыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөтэй юм.

#### 4.5. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим

Энэ зарчмын эрх зүйн гол үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14-р зүйлийн 1, 2; Эрүүгийн хуулийн 1.3-р зүйл зэрэгт тусгалаа олсон. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь аливаа хүнийг арьсны өнгө, хэл, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй байх, хуулиар хүлээлгэсэн эрх, үүрэг, хариуцлагаа хэн боловч адилхан хангах хүн бүрийн эрх зүйн этгээд байх нөхцөл, боломжийг адил тэгш эдлүүлэх шаардлагаар дамжин илэрнэ. Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгахдаа шударга ёсны зарчимтай хамтатган хуульчилж

<sup>131</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан). УБ., 2000. 118-р тал

<sup>132</sup> Мөн тэнд. 117-р тал

тодорхойлсон байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2-д: “Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.” гэж заажээ. Энэ нь Эрүүгийн хууль бүх хүнд адил тэгш үйлчлэх нөхцөлийг хангахад чиглэгдэнэ.

“Дархан эрх, эрх ямба эдэлж буй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь энэ зарчимтай зөрчилдөхгүй. Дархан эрх, эрх ямба нь тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөвхөн ийм хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах тусгай журам тогтоосноор нийтийн ашиг тусын төлөө явуулж буй үйл ажиллагаагаа баталгаатай явуулах нөхцөлөөр хангаж өгдөг.”<sup>133</sup> Энэ зарчим нь Үндсэн хуульд заасан хүн бүр эрх зүйн этгээд байх үндэслэлээс урган гарах бөгөөд аливаа хүн хуульд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хэн ч байлаа гэсэн адилхан эдэлж, адилхан хэрэгжүүлнэ гэсэн үг юм. “Тэгш эрх нь нэг талаас нийгмийн гишүүн хэнд ч болов эрх зүйн хувьд адил нөхцөл, шаардлагыг бий болгон, түүний эрх зүйн этгээд байх боломжийг хангаж өгдөг бол нөгөө талаас хүн бүрийн нийгэмд оролцож амьдрах арга туршлага, мэдлэг боловсрол, эд баялаг бүтээх чадвар харилцан адилгүй байдгаас хамаарч энэ нь тэгш бус байдлыг аяндаа бий болгодог...”<sup>134</sup>

Эрүүгийн эрх зүйд тэгш эрхийн зарчим хэрэгжихдээ эрүүгийн эрх зүйн харилцаанд хүн бүр адил тэгш оролцож, эрх ашгаа адил тэгш хамгаалуулах боломжоор хангагдсан байхын зэрэгцээ гэмт хэргийг зүйлчлэх, ял оногдуулах, ялаас чөлөөлөх болон эрүүгийн хариуцлагын ба албадлагын арга хэмжээг авахдаа хүнийг ялгаварлан гадуурхахгүй, алагчлан хандахгүй байх агуулгыг илэрхийлнэ. “Тухайлбал үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлаж, аль нэг хэсэгт нь илт давуу буюу дутуу эрх эдлүүлэх, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлөх, хууль зөрчсөн тохиолдолд хүнд болон хөнгөн хариуцлага оногдуулахаар хууль гаргах буюу хуулийн заалтыг ялгавартай хэрэглэж болохгүй гэсэн үг.”<sup>135</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн бүрийн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхэнд халдсан зарим хууль бус үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, “эрүүжүүлсэн” (криминализаци) байдаг. Жишээ нь “Үндэсний эв нэгдлийг бусниулах” (ЭХ 19.9), “Ялгаварлан гадуурхах” (ЭХ 14.1), “Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх” (ЭХ 14.5), “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” (ЭХ 14.3), “Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх” (ЭХ 16.10), “Эрүү шүүлт тулгах” (ЭХ 21.12) зэргийг дурдаж болно. “Эрүүгийн хуульд үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохдоо ямар нэгэн этгээд, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг эрүүгийн

<sup>133</sup> Г.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй. Гарын авлага. УБ., 2007. 49-р тал

<sup>134</sup> Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 47-48-р тал

<sup>135</sup> С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 32-р тал

хариуцлагын гадна үлдэхгүй байх зарчмыг баримтлах ёстой.”<sup>136</sup>

Тэгш эрхийн зарчим нь Баруун Европын орнуудын эрүүгийн хууль тогтоомжуудад илүү тод илэрч биеллээ олсон байдгийн дээр ялангуяа барууны чиглэлийн номлолд нас, хүйс, ажил, албан тушаалтны ялгагдах онцлог байдлаар нь тусгайлсан шалгуур тогтоож, ялгаварлан хандахыг үл зөвшөөрдөг бол Оросын зэрэг зүүний чиглэлийн эрүүгийн эрх зүйн онолд өндөр настан, эмэгтэйчүүд, нялх хүүхэдтэй эмэгтэй (өрх толгойлсон) зэргээр ялгавартайгаар авч үздэг ба “тусгай субъект” гэсэн ойлголтыг дэвшүүлж, түүнийгээ зөвтгөн тайлбарлах хандлага бий. Харин дийлэнх орны эрүүгийн эрх зүйд зөвхөн хүүхэд, насанд хүрээгүй хүний эрх зүйн байдлыг хуулийн тусгайлсан институт болгон авч үзэх явдлыг хүлээн зөвшөөрдөг.<sup>137</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 5-д: “Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.” гэж заажээ. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 8-д: “Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар нь хорих ял оногдуулахгүй.” гэж заасан байдаг.<sup>138</sup> Харин эмэгтэйчүүдийн хувьд дээрх ялыг оногдуулж болохыг Эрүүгийн хуулиар зөвшөөрсөн байна.

Сүүлийн жилүүдэд жендерийн тэгш эрхийн үзэл санаа барууны хөгжингүй орнуудын эрүүгийн эрх зүйн номлолд хүчтэй тусгагдах болсон ба тухайлбал хүчингийн гэмт хэргийн гэм буруу хийгээд субъект, объектийн шалгуур, нөхцөлийг үнэлэх, тодорхойлоход жендерийн нейтраль зарчмыг харгалзах, хохирогчийн үйлдлийн негатив ба сөрөг сэдэл, шалтгаант зан үйлийн харьцааг шинээр авч үзэх, уламжлалт томъёоллоос өөрөөр тайлбарлах хандлага бий болж байна. Гэтэл эсрэгээр пост-социалист болон хөгжиж буй зарим орнуудад бэлгийн эсрэг гэмт хэргийн, тэр тусмаа хүчингийн гэмт хэргийн талаарх концепц уламжлалт хэлбэрээр хуульд тусгагдсан хэвээр байгаа билээ. Монгол Улсын эрүүгийн эрх зүйд зарим нэг шинэ хандлага бий болж байна. Жишээ нь: 2015 онд шинэчлэн найруулж баталсан Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар 1-д: “...Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсэн аль ч хүйсийн хүн байж болно.” гэж хуульчилсан байна. Ингэснээр өмнө нь хүчингийн гэмт хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэй хүн байсныг өөрчлөн, эрүүжүүлснийг харуулна. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын эрүүгийн эрх зүйн агуулга нь гэмт хэрэг үйлдсэн болон түүнд гэм буруутай болох нь шүүхээр нотлогдсон үед хуульд заасан эрүүгийн хариуцлагыг хэн боловч ялгаварлахгүйгээр адил хүлээх, хэрэв гэм буруугүй бол мөн адил эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх утга санааг илэрхийлнэ. Ялангуяа шүүх дээр хэрэг нь хянан хэлэлцэгдэх

<sup>136</sup> С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 33-р тал

<sup>137</sup> “Эрх зүй” сэтгүүл. 2013. №1(23). 69-р тал

<sup>138</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2017

үед хэн боловч боловсрол, албан тушаал, нас, хүйс, эд хөрөнгийн байдал ялгаварлахгүй шүүхэд хүндэтгэлтэй хандах, адил эрх, үүрэгтэй оролцох, адил тэгш хариуцлага хүлээх явдал юм. Үүний хамт шүүгч нь шүүн таслах ажиллагаанд оролцогчдод адил тэнцүү шаардлага тавих, хэргийг шүүн хэлэлцэхдээ хэн нэгэнд давуу байдал олгох буюу хэн нэгнийг ялгаварлан гадуурхахгүй байхад чиглэгдэнэ. Тухайлбал шүүн таслах ажиллагаа мэтгэлцэх зарчмын дагуу явагдаж буй нөхцөлд яллах талын субъект буюу прокурорт хэт давуу байдал олгох, цагаатгах тал буюу өмгөөлөгчийн эрхийг хязгаарлах, түүний үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх, нотолгооны баримт сэлт, эх сурвалжаа тайлбарлах боломжийг олгохгүй байх зэрэг нь мэтгэлцэх зарчим төдийгүй тэгш эрхийн зарчмыг зөрчсөн, тэдгээрийн агуулгыг алдагдуулсан хэрэг болно.

Эрүүгийн эрх зүй дэх тэгш эрхийн зарчим нь аливаа хүн нэг адил хэргийн төлөө адилхан ойролцоо хариуцлага хүлээх шаардлага төдийгүй, хууль, шүүхийн өмнө хэн боловч адил эрх, үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг тэнцвэртэй, зохистойгоор хангах явдал юм. Гэхдээ энэ нь нэг ижил хэргийн төлөө хүлээлгэх хариуцлагыг шууд тэгшитгэнэ гэсэн үг биш, харин гэмт хэрэг үйлдсэн хүн бүрийн хувийн байдал, хариуцлагын хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан ялыг хуулийн дагуу ялгавартайгаар оноож байгаа нь энэ зарчимд харшлахгүй.

#### 4.6. Шударга ёсны зарчим

“Шударга байх”, “шударга ёс” гэсэн ойлголт латины “Jus, justitia” буюу “тэнцвэртэй, зохистой, үнэн зөв, тогтвортой” гэсэн утгыг илэрхийлж, хэрэглэгдэж иржээ. Эртний Ромын нэрт хуульч Ульпиан: “Бусдад хохирол учруулахгүйгээр өөрийгөө болон өөрийн үйлдлээ зохистойгоор бүрэн хариуцах нь шударга ёсны илэрхийлэл” гэж тэмдэглэсэн байдаг. Харин Аристотель “Шударга ёс нь ёс зүйн хэм хэмжээ болж чадсан, зохистой, тогтвортой хүсэл зориг, сайн үйлийн шалгуур, илрэл болох” тухай өгүүлсэн байна. Барууны шударга ёсны онолын нэрт төлөөлөгч Ж.Роулс (J.A.Rawls)<sup>139</sup>: “Шударга ёс нь тэгш эрхийн үгүйсгэх ба зөвшөөрөх талын ялгагдах зарчмуудыг өөртөө агуулж, эрх чөлөөт боломжийн хязгаарлагдах хийгээд нөхөгдөх шаардлага, хэм хэмжээг тусган харьцангуй тогтвортой үнэлэмж, үнэт зүйлс болж оршдог.” хэмээжээ.

Шударга ёс нь ёс зүйн төдийгүй улс төр, эдийн засаг, эрх зүйн шалгуураар хэмжигдэж, нийгмийн хөгжлийн хүчин зүйл болдог учраас түүний үнэлэмж нь зарим талаар хувьсамтгай тогтворгүй байх нь бий. Шударга ёс нь эрх чөлөө, тэгш эрх, ёс суртахуунтай холбогдож, үнэт зүйлсийг зөв зохистой байдлыг агуулдгаараа эрх зүйтэй хамааралтай түүний салшгүй эд эс нь болсон байна. Шударга ёсны зарчим нь эрүүгийн эрх зүйн тулгуур зарчмуудын нэг салшгүй хэсэг мөн. Энэ зарчмын эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 17 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд

<sup>139</sup> Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 41-р тал

тусгалаа олсон байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1-д: “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан нь шударга ёсны зарчмын гол агуулгыг илэрхийлсэн хэм хэмжээ юм. Дээрх хуулийн тухайн зүйлийн 2, 3, 5 дахь хэсгүүдийн хуульчлагдсан байдлаас үзэхэд тэгш эрхийн болон гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх, нэг гэмт хэрэгт нэг л удаа ял оногдуулах зэрэг зарчмуудыг “шударга ёсны зарчим”-д багтаан хамааруулж, томъёолжээ. Шударга ёсны зарчим нь хууль ёсны болон тэгш эрхийн зарчмуудтай салшгүй холбоотой, эрүүгийн эрх зүйн хэрэглээнд зэрэгцэж буюу хамтдаа хэрэглэгдэх нь түгээмэл байдаг. Гэхдээ энэ зарчим харьцангуй бие даасан шинж, онцлогтойн дээр зориулалт хэрэглээний хувьд тусад нь авч үзэж ойлгож, тайлбарлах шаардлага гардаг. Юуны өмнө харьцуулсан эрүүгийн эрх зүйн аспектаар тодорхойлж авч үзэх нь тухайн зарчмыг илүү бодитой, үнэн зөв танин мэдэхэд чухал ач холбогдолтой. Шударга ёсны зарчмыг тухайн нэршлээр нь Эрүүгийн хуульдаа эрх зүйн зарчим болгон хуульчилсан орнууд харьцангуй цөөн бөгөөд Испани, Беларусь, Литва, Узбекистан, Монгол, Туркменистан, Азербайжан зэрэг орныг энд төлөөлүүлэн дурдаж болно. Эдгээр оронд ялын хэм хэмжээ нь гэмт хэргийн шинж, хор аюул, нөхцөл байдалтай тохирсон байх явдлыг шударга ёсны зарчим гэж түгээмэл байдлаар томъёолсон байх ажээ. Тэгвэл Унгар, Армени, Молдав, Аргентин, Турк зэрэг оронд ялыг тухай бүрт нь бодитойгоор оногдуулахыг шударга ёсны зарчимтай холбон хуульчилсан байна. АНУ-ын ихэнх муж улсад шударга ёсны шалгуурыг шүүх тодорхойлон үнэлэх онцгой эрхтэй бөгөөд (“хуульд томъёолдоггүй”) “plea bargaing” зарчимд үндэслэн гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрөө өөрийнхөө гэм буруу, хохирол, үр дагаврыг өөртөө бүрэн хүлээж, эдлэх ял, хариуцлагаа тохиролцох явдлыг шударга ёсны илэрхийлэл гэж үзэж ханддаг байна.<sup>140</sup>

Дэлхийн эрүүгийн загвар хуулийн үзэл баримтлал болон хөгжингүй орнуудын эрүүгийн эрх зүйн нийтлэг жишгийн хандлагаас үзэхэд шударга ёсны агуулга нь гэмт хэрэгт яг тохирсон ялыг нь хариу үйлдэл маягаар онооход биш, харин тухайн гэмт хэргийн үр дагавар, хохирол, хор уршиг арилсан, зөрчигдсөн эрх сэргээн нөхөгдсөн үед ялыг харьцангуйн онолын зарчмаар эзнийг нь олж, нийгмийн болон эрх зүйт төрийн зорилго, шаардлагад нийцүүлж, оновчтой нөхцөлөөр зохистойгоор оногдуулахад оршдог байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2-д: “Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршигийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ.” гэж заажээ. Шударга ёсны зарчмын шалгуур нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг харгалзан абсолют онолын агуулгаас ангид

<sup>140</sup> “Эрх зүй” сэтгүүл. 2013. №1(23). 69-р тал

байдлаар харьцангуй зохистой буюу бодитой байх нөхцөлт шинжийг улам илүү тусгах болжээ. Шударга ёс нь ёс зүйн болон эрх зүйн шалгуурт нийцэж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрч чадвал шүүхэд итгэх олон түмний итгэл, хуулийн нэр хүнд дээшилнэ.

“...Сүүлийн хорь шахам жилийн эрүүгийн эрх зүйн хэрэглээний хандлага, шүүхийн практикаас үзэхэд анхан шатны шүүхийн тогтоолын 45-аас доошгүй хувь хүчингүй болох буюу өөрчлөгддөг, шүүхэд шилжсэн хэргийн 50 шахам хувийг мөрдөн байцаалтад буцаадаг, шүүхийн тогтоолоор нийт эдлүүлсэн ялын 80 шахам хувийг шоронгийн дэглэмд эдлүүлдэг хорих ял эзэлдэг, хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн 47 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлдэг.”<sup>141</sup> Энэхүү сөрөг хандлагаас үүдэн гэмт хэрэг ба ялын тохиргоо алдагдаж, ялын шударга, тогтвортой байх шаардлага ихээхэн алдагдаж ирснийг харуулна.

2015 оны Эрүүгийн хууль нь ялын зохистой, шударга, үр нөлөөтэй байдлыг хангахад томоохон түлхэц үзүүлж байна. Хэдийгээр шинэ Эрүүгийн хууль үйлчлээд удаагүй боловч эрүүгийн эрх зүйд шударга ёсны зарчим сэргэн хөгжих таатай боломж бүрэлдэж байна. Ялангуяа өмнө нь ойлгож хэрэглэж байсан онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох, давтан гэмт хэрэг, ялтай байдал зэрэг ойлголтыг тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцохгүй буюу эдгээр ухагдахуун хэрэглэгдэхгүй болсон нь шударга ёсны зарчмыг жишгийн утгаар нь хангахад чухал алхам болсон. Энэ бүхэн нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 5-д: “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах” гэсэн шударга ёсны зарчмын заалтад нийцсэн зохицуулалт юм. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-д: “...Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй.” гэж заасныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Өмнөх Эрүүгийн хууль үйлчилж байсан үеийн шүүхийн практикт ялыг халдаан хэрэглэхгүй байх баталгаа бүрэн найдвартай бүрэлдээгүй байсан гэж үздэг. Энэ нь ялангуяа эд хөрөнгө хураах ялын хэрэглээн дээр яригддаг байв. Шинэ Эрүүгийн хуулиар эд хөрөнгө хураах ялыг халсан нь шударга ёсны зарчимд ял халдаахгүй байх шаардлагыг хангахад чухал алхам болсон билээ. 2015 оны Эрүүгийн хуульд хэлбэрийн болон холимог бүрэлдэхүүн давамгайлсан гэмт хэрэг зүйлчлэлийн тогтолцоог бий болгож, хувь хүн, гэр бүл, хувийн эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах нөхцөл боломжийг нэмэгдүүлж, сэтгэл санааны хүчин зүйл болон хор уршгийг бодитойгоор тооцох тодорхой нөхцөлийг шинээр хуульчилсан зэрэг нь шударга ёсны зарчмын баталгааг бүрдүүлэхэд зохих түлхэц үзүүлж байна.

Орчин үед эрүүгийн эрх зүй дэх гуманизаци болон глобалчлалын үйл явц гүнзгийрэхийн хэрээр ялаас хамааралтай гэмт хэргийн ангиллын зарчим үе өнгөрөөж, харин оронд нь гэмт хэргээс хамаарсан ялын тогтолцооны чиг хандлагыг илүү чухалчлан үзэх болсон байна. Түүнчлэн орчин үеийн эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны тогтолцоонд “өөрөө өөрийгөө гэмт халдлагаас хамгаалах” боломж, баталгааг хуулиар хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг

<sup>141</sup> “Шүүх эрх мэдэл” сэтгүүл. 2016. №4. 17-р тал

шинээр бий болгож байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа аргагүй хамгаалалтын үндэслэл, хүрээг өргөжүүлэх, аргагүй хамгаалалтын хэр хэмжээ хэтрүүлснийг гэмт хэрэгт тооцохгүй байх зэрэг декриминализацийн хандлага улс орнуудад бий болж байгаа юм.

Шүүхийн практик хэдий чинээ шударга, байх тусам нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж, анхан шатны шүүхийн шийдвэр улам бүр тогтвортой хэрэгжиж, гэмт хэрэг ба ялын зохицол, уялдаа зохистойгоор хангагдаж, эрүүгийн эрх зүйн хамгийн оновчтой хэрэглээ бий болсон цагт шударга ёсны үнэт зүйлс бүрэн хангагдах болно.

#### 4.7. Энэрэнгүй ёсны зарчим

Энэ зарчим нь хүнлэг ёсны шаардлагад нийцсэн ялын бодлогын хүмүүнлэгийн хандлагатай уялдаж гарч ирсэн зарчим юм. Энэрэнгүй ёсны зарчим бол эрүүгийн эрх зүйн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ гэмт хэрэг үйлдсэн хүний жам ёсны болон Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг хангах, ялын нөхцөлийг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, өршөөл, уучлал үзүүлэхтэй холбоотой нийтлэг зарчмуудын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, хууль зүйн үр дагавраа бүрэн арилгасан буюу тийнхүү арилгах нь бодитойгоор нотлогдсон үед нийгмээс тусгаарлахгүй буюу эрх чөлөөг нь бүрэн хязгаарлахгүйгээр ялыг хөнгөрүүлэх эсхүл богино хугацааны хорих болон хорихоос өөр төрлийн ял онооход чиглэгдэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-д: “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.” гэж заасан бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3-д: “Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.” гэж заажээ. Түүнчлэн эрүүгийн хариуцлагын зорилгыг цээрлүүлэх төдийгүй... “гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд...” чиглүүлэх тухай хуульчилсан нь бий (Эрүүгийн хуулийн 5.1.1-р зүйл).

Эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг зүйлчлэлийн болон ялын институцийг өөрийн зохицуулах зүйл болгон авч үздэгийн хувьд ялын үндэслэл, процедурын нэг салшгүй хэсэгт ялаас чөлөөлөх, ял оноохгүй байх, ял хойшлуулах, ялыг хөнгөрүүлэх зэрэг асуудал зүй ёсоор хамаарагдаж багтсан байдаг. Эдгээр асуудал нь энэрэнгүй ёсны зарчмыг хэрэглэхтэй зайлшгүй холбогдоно. Тэр тусмаа ялын үр нөлөө нь тухайн ял эдэлсэн хүн дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, эргээд нийгэмшсэн байх зэрэг бодит үр дүнд хүрэхэд оршино. Эрүүгийн эрх зүйн сонгодог онолын төлөөлөгч Чезаре Беккариа (Cesare Beccaria) нь “...Гэмт хэрэгтний бие махбодид аль болох бага зовлон зүдгүүр учруулахын хамтаар сэтгэл санаанд нь аль болох гүн хоногшиж, хүчтэй сэтгэгдэл төрүүлэх ялыг хэрэглэх нь зүйтэй.”<sup>142</sup> гэж бичсэн байдаг.

<sup>142</sup> Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай (Г.Эрдэнэбатын орчуулга). УБ., 2009. 49-р тал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4-д: “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.” гэж заасан нь энэрэнгүй ёсны зарчмын эрх зүйн үндэслэл болно.

Сүүлийн үед дэлхийн ихэнх улс орнуудад цаазаар авах ялыг халж, хүчингүй болгох үйл явц эрчимтэй өрнөж байгаагийн зэрэгцээ шоронгийн хаалттай дэглэмд хугацаатай болон бүх насаар нь хорих ялыг түгээмэл хэрэглэх явдал багасч байна. Мөн албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах ялыг хэрэглэх явдлыг шүүмжлэх хандлага бий болж, тэдгээрийг халж, өөрчлөх үйл явц хэрэгжиж байна.<sup>143</sup>

Дээр дурдсан хүмүүнлэгийн чиг хандлага эрүүгийн эрх зүйд, тэр тусмаа орчин үеийн ялын бодлогод гүнзгий илэрч тусгагдах болсон нь чухамдаа эрүүгийн эрх зүйд энэрэнгүй ёсны зарчим хэрэгжиж байгаагийн бодит илэрхийлэл юм. Эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчим нь Монгол Улсын Эрүүгийн хуульд орсон дор дурдсан хэм хэмжээнүүдэд илүү тод илэрч, тусгагдсан байна. Үүнд:

- Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх (ЭХ 1.9.1);
- 14 хүртэлх насны хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх (ЭХ 8.1.1);
- Жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд нийтэд тустай ял оногдуулахгүй байх (ЭХ 5.4.5);
- Нийгмийн хор аюулыг үгүйсгэх хуульд заасан нөхцөл байдалд бусдад хохирол учруулбал гэмт хэрэгт тооцохгүй байх (ЭХ 4.1 – 4.6);
- Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзвал эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх (ЭХ 2.8.3);
- Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх (ЭХ 6.7);
- Өсвөр насны хүнд энэрэнгүй хандсан хэм хэмжээ (ЭХ 8.1 – 8.7);
- Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд хэрэглэх (ЭХ 6.6);
- Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох (ЭХ 6.12);
- Өршөөл, уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх (ЭХ 6.14);
- Гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх (ЭХ 6.15);
- Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх (ЭХ 6.13);
- Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх (ЭХ 7.2 – 7.5);
- Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах (ЭХ 7.6) г.м.

<sup>143</sup> “Эрх зүй” сэтгүүл. 2010. №1-2(18-19). 92-93-р тал



Дээр дурдсан хэм хэмжээнүүд нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйд энэрэнгүй ёсны зарчмыг хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа төдийгүй ялын бодлогод хүнлэг ёсны хандлага тодорхой тусгагдсаны илрэл мөн.

2015 оны Эрүүгийн хуульд илүү энэрэнгүй, илүү уян хатан, урамшуулах буюу өршөөх агуулгатай хэм хэмжээнүүд өргөн хүрээнд тусгагдсанаараа онцлог юм. Энэ хуулиар цаазаар авах ял болон албадан ажил хийлгэх ял, эд хөрөнгө хураах ялыг хүчингүй болгосон. Түүнчлэн хугацаатай хорих ялыг түгээмэл байдлаар хавтгайруулан хэрэглэж байсныг хязгаарлаж, уг ялын хугацааны дээд, доод хязгаарыг уртасгаж, хорих ялын дэглэмийг нээлттэй ба хаалттай болгон шинэчлэн өөрчилсөн юм. Шинэ Эрүүгийн хуульд орсон хүнлэг, энэрэнгүй агуулга бүхий заалт, хэм хэмжээнүүд нь урьд өмнө нь хэрэгжүүлж байсан хэт хатуу (*шоронд хорих*) ялын бодлогыг өөрчилж, улам илүү хүмүүжил – нөлөөллийн буюу нийгэмшүүлэх зорилго, чиг үүргийг агуулж байгаагаараа ач холбогдолтой. Энэрэнгүй ёсны зарчим нь шударга ёсны зарчимтай уялдан хэрэглэгдэж ирсэн ба гэмт хэргийн шинж, ангилал, төрөл болон түүний учруулсан хохирол, хор уршгийн хэр хэмжээнээс хамаарч, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөлийг харгалзаж, эрүүгийн хариуцлага оноох буюу түүнээс чөлөөлөх асуудлыг хянан шийдвэрлэж ирсэн билээ.

2015 оны Эрүүгийн хуульд урьд өмнө байгаагүй цөөнгүй заалт, хэм хэмжээг шинээр оруулж хуульчилсан нь эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчмыг бодитойгоор хангахад томоохон алхам болсон. Жишээ нь Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.2-д: “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэлх хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол таван жил, түүнээс бага хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх” тухай заажээ. Энэ жишээтэй адилаар хэргийн шинж онцлог, ялын санкцийн байдлаас хамаарч тэнсэн харгалзах болон хорих ялаас чөлөөлөх тухай тодорхой журмыг шинээр хуульчилсан билээ. Энэрэнгүй ёсны зарчим бол хүний эрхийн хэм хэмжээ, стандарт шаардлагыг нийтлэг жишгийн дагуу хүлээн зөвшөөрч, ялын бодлогод хүмүүнлэгийн чиг хандлага тусгагдах болсныг харгалзан үзэж буй эрүүгийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг зүй ёсны зарчим яах аргагүй мөн билээ.

#### **4.8. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим**

Энэ зарчим нь эх газрын эрүүгийн эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг бөгөөд гол нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, зорилгыг агуулдаг. Эрүүгийн хариуцлага өөрөө хүлээх зарчим нь нэг талаас хувь хүн гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хувь этгээд өөрөө тухайн хийсэн хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээх, нөгөө талаас нэг этгээдийн үйлдсэн хэргийн төлөө өөр бусад этгээд өмнөөс нь хариуцлага хүлээхгүй байх гэсэн шаардлагаар нөхцөлдсөн байдаг. Монгол

Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-д: “Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдааж хэрэглэж болохгүй.” гэж заажээ. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.” гэж заасан билээ. Эрүүгийн эрх зүйн уламжлалт онолын хандлагаар авч үзвэл “Эрүүгийн хуулийн энэ зарчим нэг этгээдийн бурууг нөгөөд нь хариуцуулдаггүй, эцэг эхийн бурууг үр хүүхдэд нь хүлээлгэдэггүй гэсэн тодорхой агуулгыг илэрхийлнэ.”<sup>144</sup> Энэ зарчим харьцангуй хожуу үед 1930-аад оны дунд үеэс гэм зэмгүй олон хүмүүст “Хувьсгалын эсэргүү”, “Японы тагнуул”, “Ардын дайсан” гэх мэт хаяг зүүж, хилс хэрэгт хэлмэгдүүлэхийн зэрэгцээ тэдний гэр бүлийн гишүүд, төрөл садны хүмүүсийг ямар ч үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлагад татан шийтгэх, эд хөрөнгийг хураах, орон байрнаас хөөн гаргах, ажил төрөл, сургууль соёлгүй болгох, нутаг зааж суулгах, нутгаас зайлуулах зэргээр хоморголон хэлмэгдүүлж байсан хэлмэгдүүлэлт, завхралыг дахин гаргахгүй байхын хууль зүйн баталгаа юм. Энэ зарчим нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг үгүйсгэдэг. Гэтэл Монгол Улсын хувьд энэ зарчим нэлээд зөрчилтэй байдлаар хуульчлагдсан гэж үзэх үндэслэл бий.<sup>145</sup> Гэхдээ орчин үед энэхүү зарчмын агуулгыг шинээр авч үзэх хандлага бий болоод байгаа билээ.

“*Deliquere non potest*” буюу “Хамтарсан субъект гэмт хэрэгтэн байж болохгүй” гэж үздэг үзэл баримтлал орчин цагийн нөхцөлд өөрчлөгдөж байгааг Дэлхийн эрүүгийн загвар хуулийн 19-р зүйлийн тайлбарт дурджээ.<sup>146</sup> Үүний хамт уг зарчмыг зөвхөн ял халдаахгүй байх агуулгаар нь авч үзсэн нь бий. Өөрөөр хэлбэл “тухайн хүнд гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө түүнд тохирох ялыг бусдад халдаахгүй”<sup>147</sup> байх асуудал юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4-д: “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэж заажээ. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын онолоор бол хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төлөө хуулийн этгээдэд ажиллаж буй ажилтан, албан тушаалтан хариуцлага хүлээдэггүй. Зөвхөн тухайн хуулийн этгээд өөрөө хариуцлага хүлээдэг (*vicarious liability*). Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэх Германы эрүүгийн эрх зүйн сонгодог онолоор бол хуулийн этгээд оролцсон гэмт хэргийн төлөө тухайн албан тушаалтан буюу хувь хүн хариуцлага хүлээнэ. Энэ онолын үндэслэлээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй ажээ.

<sup>144</sup> Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ., 1973. 14-р тал

<sup>145</sup> Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал. Эмхэтгэл. УБ., 2017. 6-р тал

<sup>146</sup> “Эрх зүй” сэтгүүл. 2013. №3(25). 72-р тал

<sup>147</sup> Эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги (ред. Ж.Болдбаатар). УБ., 2016. 14-р тал

Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим нь эрүүгийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн онолын үндэслэлийн хувьд өөрийн гэсэн шалгуур бүхий бие даасан агуулгаар тодорхойлогдоно. Үүнийг нэгтгэн дараах байдлаар тоймлон илэрхийлбэл:

1. Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон хүн тухайн хэрэгтээ тохирсон ялыг зөвхөн өөрөө хүлээх ёстой.
2. Гэмт хэрэг үйлдсэн хүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд төлөөлөн хариуцлага хүлээж болохгүй.
3. Эрүүгийн ялыг гэр бүлийн гишүүдэд нь халдаан хэрэглэхгүй.
4. Эрүүгийн хариуцлагыг гэмт хэрэг үйлдсэн зөвхөн хувь этгээдэд оногдуулах ба хуулийн этгээдэд оногдуулж болохгүй.
5. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөвхөн хүнд нь зориулж ял оноож буй явдал биш, яллагдагч, шүүгдэгчийн хувьд үйлдсэн хэрэгт нь тохируулж оноож буй явдал г.м.

Энэхүү зарчмыг шүүхийн практикт хэрэглэхдээ юуны өмнө түүний онолын үндэслэл болон мөн чанарыг нь сайтар судалж ойлгосон байх шаардлагатай. Ялангуяа хуулийн этгээд болон албан тушаалтны аль аль нь оролцсон зарим тодорхой төрлийн гэмт хэргийн хувьд (*ЭХ 18.4, 18.9, 18.11, 18.6, 18.1*) эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хууль ёсны зарчим болон энэ зарчмын агуулгад нийцүүлж, эрх зүйн үндэслэлтэй хандах ёстой.

Эрүүгийн хууль үйлчлэн хэрэгжээд тун удаагүй байгаа энэ үед уг зарчмыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэх талаар албан тайлбар зайлшгүй шаардлагатай болж байна. Энэ зарчмыг бүрэн танин мэдсэнээр гэмт хэрэг үйлдсэн этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх шаардлага зайлшгүй болохыг онол, практикийн үндэслэлтэйгээр ойлгож эзэмших боломжтой.

#### **4.9. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим<sup>148</sup>**

Уг зарчим нь өмнө дурдсан зарчмуудын ихэнхтэй нь холбоотой боловч зарим талаар харьцангуй бие даасан онцлог, мөн чанарыг өөртөө агуулдаг. Эрүүгийн хариуцлага гарцаагүй хүлээх гэдэг нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг нэгэнт үйлдсэн л бол түүнд тохирсон эрүүгийн хариуцлагыг яг хуульд заасны дагуу шударгаар хүлээх шаардлагыг хангахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл энэ зарчим нь хэрэглээний зориулалт, шууд утгаараа шударга ёсны болон хууль ёсны зарчимтай уялдаж холбогдсон шинжтэй байдаг.

“Энэ зарчим нь гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших явдал гаргуулахгүй байх, гэмт хэрэг үйлдсэн этгээд эрт орой хэзээ нэг цагт түүнийхээ төлөө хариуцлага хүлээж, байх бүх нөхцөлийг бүрдүүлэхэд үйлчилнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүр заавал хариуцлага хүлээдэг байх нь эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн ач холбогдлыг

<sup>148</sup> Энэ зарчим нь хууль ёсны болон гэм буруугийн, шударга ёсны зэрэг зарчмуудтай салшгүй холбоотой тул энд товчлон авч үзэв /Д.Б./.

илэрхийлэх гол арга болдог”<sup>149</sup>.

Эрүүгийн хариуцлагын мөн чанар нь тухайн хариуцлага хатуу, зөөлөнд бус, гагцхүү зайлшгүй бөгөөд гарцаагүй байхад оршино. Гарцаагүй байх гэдэг нь зайлшгүй буюу өөр сонголтгүй, маргаангүй байх шаардлагаар нөхцөлдсөн байна. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдсон л бол эрүүгийн хариуцлагаас зайлсхийж, ял завших ямар ч боломжгүй юм. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага нь хуулийн дагуу ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх ял тэнсэх, хойшлуулах зэрэг асуудалтай зөрчилдөхгүй.<sup>150</sup> Учир нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал нь ямар ч нөхцөлд заавал яллах гэсэн зорилгыг агуулахгүй. Хамгийн гол нь тухайн хариуцлага нь эрх зүйн үндэслэлийн хувьд зайлшгүй хүлээлгэх шинжтэй байдаг. Энэхүү зарчим нь эрх зүйт төрийн мөн чанар, шаардлагаас урган гарч, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, тухайн гэм буруу нь шүүхээр нотлогдсон эсэхийг эрх зүйт ёсны шударга процессын (*Due process of law*) арга, хэлбэрээр шалган, эрүүгийн хариуцлага гарцаагүй хүлээх нөхцөлийг тогтооход чиглэгдэнэ.

Орчин үеийн эрүүгийн эрх зүйд криминализацийн үйл явц идэвхтэй өрнөж, шинэ төрлийн гэмт үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох, ялын бодлогыг нь чангатгах хандлага бий болж байна.<sup>151</sup> Эрх зүйн хөгжлийн глобалчлалын сөрөг үр дагавар болон шинээр гарч ирж буй зохион байгуулалттай, бүлэглэлийн үндэстэн дамнасан гэмт хэргүүд өсөх хандлагатай байгаа нь шинэ төрлийн гэмт хэргийг тухайн бүр нь шуурхай илрүүлж, таслан зогсоож байх шаардлагыг бий болгож байна.<sup>152</sup> Ялангуяа хүн худалдаалах, мөнгө угаах, цахим мэдээлэлд хууль бусаар халдах, терроризмыг санхүүжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, татвараас санаатай зайлсхийх, байгаль орчин, экологийн тэнцвэр алдагдуулж, ноцтой хохирол учруулах, авлига авах, хүнсний аюулгүй байдлыг алдагдуулах, хуурамч хууль бус эм, эмийн бэлдмэл бэлтгэх, нийлүүлэх, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, нийлүүлэх зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага гарцаагүй хүлээлгэх шинэ нөхцөл, хандлага бий болж байна.

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрэглэх хоёр үндсэн хандлага байдаг. Үүнд:

- 1) **Stricto sensu:** *Явцуу утгаар хэрэглэх*
- 2) **Lato sensu:** *Өргөн утгаар хэрэглэх*

Явцуу утгаар хэрэглэх буюу эхний хандлага нь иргэний нийгэм, эрх зүйт ёсны үнэт зүйлсийг зайлшгүй хамгаалах шаардлагыг хангахаас бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хангахаас бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагыг гарцаагүй хэрэглэх нь заавал байх зарчим биш гэж үздэг.

<sup>149</sup> С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. I боть. УБ., 2009. 38-р тал

<sup>150</sup> Г.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй. Гарын авлага. УБ., 2007. 50-р тал

<sup>151</sup> Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал. УБ., 2012

<sup>152</sup> В.Н.Додонов. Сравнительное уголовное право. М., 2009. с81

Өөрөөр хэлбэл хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, гэм буруугаа хүлээсэн нөхцөлд ял бус албадлагын болон нийгмийн нөлөөлөл хяналтын арга, механизмыг үр нөлөөтэй сонгон хэрэглэх боломж нээлттэй, хязгаарлагдаагүй нөхцөлд эрүүгийн ялыг ямар ч сонголтгүйгээр заавал шууд хэрэглэх нь эрүүгийн эрх зүйн орчин үеийн чиг хандлага, хүний эрхийн суурь зарчим, үнэт зүйлст нийцэхгүй гэж үздэг байна.

Өргөн утгаар хэрэглэх хандлага нь “Гэмт хэрэг үйлдсэн л бол ял зайлшгүй” гэсэн криминализацийн шаардлагад үндэслэгддэг. Өөрөөр хэлбэл хөнгөн, хүнд, ноцтой, онц аюултай ямар ч ангилал, төрөл, шинжийг харгалзахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдсон бол тухайн гэмт хэрэгт нь тохирсон ялыг нь заавал оноох, ял шийтгэл гарцаагүй байхыг шаарддаг.

Дээрх хоёр хандлагыг сул ба давуу талаас нь сайтар харгалзан нягталж, харьцангуй бодит байдалд нийцүүлж, хууль ёсны зарчимтай уялдуулж авч үзэх ёстой. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим нь нийгмийн шударга ёсыг тогтоон бэхжүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн ял завшихгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Өнөөгийн орчин үеийн хөгжингүй улс, орнуудад энэхүү зарчмыг бүхэлдээ хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлж байгаа боловч абсолют онолын ялыг туйлчлан хэрэглэх чиг хандлагыг үгүйсгэн шүүмжлэх болсонтой холбоотойгоор зарим талаар шинээр авч үзэх, хязгаарлах гэсэн үзэл баримтлал бий болж байна. Зарим улс, оронд эрүүгийн хариуцлагыг хүлээлгэх үндэслэл, нөхцөлийг нэлээд хязгаарлагдмал байдлаар томъёолж, Эрүүгийн хуульдаа тусгасан байх нь бий. Жишээ нь Сербийн Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлсийн 1-д: “Нийгмийн суурь үнэт зүйлс болон хүнийг хамгаалах зайлшгүй шаардлага нь гэмт хэргийг зүйлчлэх, эрүүгийн ялын ба эрүүгийн хариуцлагын хэмжээ, нөхцөлийг хязгаарлах үндэслэлийг тодорхойлно” гэж заажээ. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрэглэхэд юуны өмнө Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн үзэл баримтлал болон энэ хуулийн зорилго агуулгыг маш сайн ойлгож, шударга ёсны зарчмыг хууль ёсны зарчимтай нягт уялдуулж, хоорондын хамааралт байдалд нь судалж, танин мэдсэн байх нь арга зүйн ач холбогдолтой. Төр нь иргэнээ шийтгэж, яллан хариуцлага хүлээлгэж байгаа гэсэн утгаар ойлгож болохгүй. Энэ зарчмын зорилго, агуулга нь гэм буруугийн төлөө хариуцлага зайлшгүй хүлээх мөн чанарыг тусгаж, шударга ёсны шаардлагаар илэрч, тодорхойлогдсон байна. Монгол Улсад энэ зарчмыг дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу ойлгож, зөв зохистой хэрэглэх ёстой билээ.

#### **4.10. Эрүүгийн эрх зүйн зарчмыг хууль тайлбарлан хэрэглэхэд анхаарах зарим зүйлс ба товч дүгнэлт**

Эрүүгийн эрх зүйн зарчмыг хууль тайлбарлан хэрэглэх ажиллагаанд харгалзан үзэх үндэслэл, ач холбогдлыг гарын авлагын 3-р сэдвийн 4-р хэсэг, 4-р сэдвийн 2-р хэсэгт тодорхой дэлгэрүүлж авч үзсэн. Иймд энэ хэсгийн

хувьд эрүүгийн эрх зүйн зарчмыг гол нь шүүхийн практикт хэрхэн хэрэглэх асуудлыг онолын үндэслэл, арга зүйн талаас нь тоймлон илэрхийлэхийн зэрэгцээ эрүүгийн эрх зүйн хэрэглээний зарим тулгамдсан асуудлыг хөндөж товч дүгнэлт хийхийг зорилоо.

Эрүүгийн эрх зүйн зарчмууд бол нэг талаас эрүүгийн эрх зүйн бодлого, чиг хандлагын талаарх төрийн үзэл баримтлал, нөгөө талаас Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиар тусгайлан тогтоож хуульчлагдсан эрх зүйн хэм хэмжээ мөн.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэр тусмаа шүүхийн шүүн таслах ажиллагаанд эрүүгийн эрх зүйн нийтлэг суурь зарчмууд болон тусгайлсан зарчмуудыг бүтээлчээр хэрэглэж хэвшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Шүүгч нарын хувьд эрүүгийн эрх зүйн зарчмуудыг хэрэглэхдээ дор дурдсан зүйлд анхаарах зайлшгүй шаардлагатай юм. Үүнд:

- 1) Шүүгч бүр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үеийн шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд эрүүгийн эрх зүйн зарчмуудыг заавал дурдаж, нотлох баримтыг шалган үнэлэхдээ нотолгооны төдийгүй эрх зүйн үндэслэлийг дэлгэрүүлж, тэдгээр зарчмын агуулгыг тайлбарлан хэрэглэж байх;
- 2) Эрүүгийн хэргийн шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох болон тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлд заасан “Гэм буруугийн зарчим”, 1.3 дугаар зүйлд даасан “Шударга ёсны зарчим” 1.2 дугаар зүйлд заасан “Хууль ёсны зарчим” зэрэг тулгуур зарчмуудыг заавал тусган бичиж, үндэслэлийг нь тодорхой дурдаж байх;
- 3) Шүүн таслах ажиллагааны явцад нотолгооны болон гэмт буруугийн асуудлыг хянан шийдвэрлэх шүүх хурлын үед” нотолгооны баримт сэлтийг бүх талаар олж, шалган цуглуулсан боловч эргэлзээтэй байдал үүсвэл яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим” түүнчлэн “Энэрэнгүй ёсны зарчим” зэргийг харгалзан үзэж дээрх зарчмуудыг ишлэл болгон ашиглаж байх;
- 4) Эрүүгийн хуулийн зарим заалт, хэм хэмжээ зарим үед ойлгомжгүй, тодорхой бус нөхцөлд тэдгээрийг дур мэдэн, төсөөтэй хэрэглэхгүй байхад онцгой анхаарах ёстой. Энэ тохиолдолд хууль ёсны зарчмын дөрвөн үндсэн агуулгыг зайлшгүй харгалзан, ухаалгаар ойлгож, эрх зүйн онолын үндэслэлтэй хэрэглэх нь зүйтэй;
- 5) Хөгжингүй орнуудын эрүүгийн эрх зүйд нэлээд түгээмэл хэрэглэгддэг “**ultima ratio**” буюу “Эрүүгийн ялын санкцийг хамгийн эцсийн арга зам болгон хэрэглэх” зарчим нь хүнлэг, энэрэнгүй ёсны нэг хандлага бөгөөд ялангуяа гэм буруугаа хүлээж, хохирол, төлбөрөө төлсөн буюу тийнхүү арилгахаа илэрхийлсэн ноцтой биш хэрэг үйлдсэн хүний хувьд хорих ялыг тэнсэн харгалзах, хойшлуулах, ялаас чөлөөлж, албадлага-нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх боломжийг хуулиар зөвшөөрдөг байна. Энэ зарчим Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан бөгөөд шүүхийн практикт бүтээлчээр хэрэглэх шаардлага бий болж буйг

анхаарч харгалзан үзэх ёстой;

- 6) Эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн ойлголтыг хэт уламжлалт хуучинсаг онолд баригдан субъектив талын салшгүй элемент мэтээр догматик хандлагаар туйлшруулан ойлгож, тэрхүү консерватив арга зүйг шүүхийн практикт хэрэглэж ирсэн практикаас татгалзаж, гэм бурууг барууны орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн онолын үндэслэл, шалгуурыг баримтлан үнэлж, тодорхойлох ухамсар, сэтгэлгээг бий болгох, энэ талаарх эрүүгийн эрх зүйн мэдлэг, арга зүйг эзэмших зэрэг нь нэн тулгамдсан шаардлага болж байна;

Эцэст нь тоймлон дүгнэвэл:

- 1) Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь зөвхөн үзэл баримтлал төдийгүй хуульчлагдсан хэм хэмжээ мөн тул тэдгээрийг хууль зүйн эх сурвалжийн түвшинд үнэлж, шүүхийн өдөр тутмын практикт зохистойгоор, түгээмэл хэрэглэх орчин нөхцөлийг бий болгох шаардлагатай.
- 2) Хууль тогтоогчийн зүгээс Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, аутентик тайлбар хийх, Эрүүгийн хуульд бусад хуулиудыг нийцүүлэх шаардлага бий болсон үед юуны өмнө эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг заавал харгалзан үзэж үндэслэл болгон хэрэглэх учиртай.
- 3) Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4-д заасан..."Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах..." тухай заалтыг бүтээлчээр зөв хэрэгжүүлэхийн тулд "Хууль тайлбарлах үйл ажиллагааны журмын тухай" хуулийн төслийг шинээр боловсруулж, батлуулан, уг асуудлыг процессын эрх зүйн зохицуулалттай болгох зүй ёсны шаардлага бий болж байна.

~oOo~

